Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын референт О.Дөлгөөнтуул, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Ж.Батсуурь нарын тавьсан асуултад Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр нар хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 15
Бүгд: 45
66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:56/

Уг асуудлыг 15 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Органик бүтээгдэхүүний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын 6 гишүүн 2023.03.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, мөн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 15 цаг 57 минутаас хуралдааныг даргалав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Органик бүтээгдэхүүний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, П.Анужин, Т.Аубакир,

Ш.Адьшаа, Б.Саранчимэг, Ц.Туваан, Т.Энхтүвшин нарын гаргасан /цаашид “Ажлын хэсэг” гэх/ 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “дэмжлэг үзүүлэх” гэсний өмнө “төрөөс” гэж нэмж, төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Органик” гэсний дараах “хүнсний” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь хөдөө аж ахуйн болон байгалийн гаралтай органик хүнс, хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүн, мал, амьтан, тэжээл, бордоо, таримлын үр, суулгацыг үржүүлэх, үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, тээвэрлэх, хадгалах, савлах, шошголох, худалдаалах, экспортлох, импортлох үйл ажиллагаанд үйлчилнэ.

3.2.Энэ хуулийн 3.1-д заасан үйл ажиллагаа шилжилтийн үеийн органик үйлдвэрлэлийн бүх үе шатанд хамаарна.

3.3.Амьтны тухай хуулийн 4.1.7-д заасан агнуурын амьтны түүхий эдээр органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.1.“органик үйлдвэрлэл” гэж шилжилтийн үеийн болон органик үйлдвэрлэлийн бүх үе шатанд нөөцийг зохистой ашиглах, экосистемийн тэнцвэр, биологийн олон янз байдлыг хадгалахад чиглэсэн уламжлалт арга барил, биологи ба механик арга технологийг хослуулан эрхлэхийг;

4.1.2.“органик бүтээгдэхүүн” гэж зохиомол аргаар нийлэгжүүлсэн нэмэлт бодис, эрдэс бордоо, пестицид, антибиотик, өсөлтийн даавар, хувиргасан амьд организм, цацраг туяа хэрэглээгүй энэ хуулийн 4.1.1-д заасан үйлдвэрлэлийн үр дүнг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.7, 4.1.8, 4.1.9 дэх заалт нэмэх:

“4.1.7.“органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдэг” гэж эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаар баталгаажсан, органик бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн органик болон шилжилтийн үеийн түүхий эд, бүтээгдэхүүнийг гэрчилж, шошгод байршуулсан тэмдгийг;

4.1.8.“урьдчилан сэргийлэх арга хэмжээ” гэж органик бүтээгдэхүүн нь органик бус бүтээгдэхүүнтэй холилдох, энэ хуулийн 8.2-т заасан органик үйлдвэрлэлд хэрэглэхийг зөвшөөрсөн бодисын жагсаалтад зааснаас өөр бодисоор бохирдох эрсдлээс зайлсхийхийг;

4.1.9.“шошго” гэж органик бүтээгдэхүүний оноосон болон худалдааны нэр, органик үйлдвэрлэлийн талаар бичсэн, хэвлэсэн, зурсан, товойлгосон, сийлсэн аливаа үг, бичиглэл, мэдэгдэл, тэмдэг, дардас, зураг, тухайн бүтээгдэхүүнийг дагалдах баримт бичиг, хуудас, зүүлт, хавчуурга, бөгж, хүзүүвчийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 21

Бүгд: 39

46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 15

Бүгд: 40

62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 16

Бүгд: 40

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Органик үйлдвэрлэлд баримтлах зарчим

5.1.Органик үйлдвэрлэлд дараах зарчмыг баримтална:

5.1.1.хөрс, ус, агаар, ургамал, амьтан, хүн амын одоо ба ирээдүйд эрүүл, аюулгүй оршин тогтнох, тэдгээрийн дархлаа, дасан зохицох чадварыг дэмжих, нөхөн сэргээх;

5.1.2.экоосистемийн тэнцвэрийг хадгалах, биологийн олон янз байдлыг дэмжих, уламжлалт соёл, ёс заншлыг хүндэтгэх, үйлдвэрлэлийн нөөцийн тогтвортой байдлыг хангах;

5.1.3.зах зээлийн өрсөлдөөн, үйлдвэрлэлийн бүх үе шатанд шударга, энэрэнгүй ёсыг баримтлах, гадаад орцын хэрэглээг хязгаарлах, мэдлэгээ хуваалцах;

5.1.4.бүтээгдэхүүний органик болон байгалийн шинж байдлыг хадгалах, нөөцийг зүй зохистой ашиглахад чиглэсэн арга технологиор үйлдвэрлэл эрхлэх;

5.1.5.уламжлалт мэдлэгийг шинжлэх ухааны ололттой хослуулан органик үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, шинэ технологийг нэвтрүүлэхдээ урьдчилсан үнэлгээ хийх, эрсдлийг бууруулах, ил тод, нээлттэй шийдвэр гаргах;

5.1.6.шилжилтийн үеийн болон органик үйлдвэрлэлийг сайн дурын үндсэн дээр эрхлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 14

Бүгд: 39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн **ХОЁРДУГААР БҮЛГИЙН** гарчгийн **“ЭРХЛЭГЧИЙН”** гэснийг **“ЭРХЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА”** гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 6 дугаар зүйл нэмэх:

“6 дугаар зүйл.Органик үйлдвэрлэл эрхлэгчид тавигдах шаардлага

6.1.Органик үйлдвэрлэл эрхлэгч нь дараах нийтлэг шаардлагыг хангана:

6.1.1.энэ хуульд заасан шаардлага, журмыг баримталж органик үйлдвэрлэлд шилжих;

6.1.2.органик үйлдвэрлэлд шилжихдээ энэ хуулийн 8.2-т зааснаас бусад бодисыг тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хэрэглэхээ зогсоох;

6.1.3.усны бохирдлоос сэргийлэх, цас, борооны усыг ашиглах, хаягдал багатай, эсхүл хаягдалгүй усны технологи ашиглах;

6.1.4.биотехникийн болон биологийн олон янз байдлын чанарыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;

6.1.5.өөрийн болон хөрш зэргэлдээ, нийтийн эзэмшлийн газрын байгаль орчин, эд зүйлсийг хамгаалах.

6.2.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь органик үйлдвэрлэлд шилжихдээ хууль тогтоомжид заасан хүнсний аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

6.3.Хуулиар хориглоогүй бол улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон орчны бүсэд органик үйлдвэрлэл эрхэлнэ.

6.4.Орцын 95 болон түүнээс дээш хувь нь органик найрлагатай бүтээгдэхүүнийг органикт тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38

55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 6 дугаар зүйлийн гарчгийн “эрх” гэсний дараа “, үүрэг” гэж нэмж, мөн зүйлийн 6.1.2 дахь заалтын “энэ хуулийн 8.2-т заасан журмын дагуу” гэснийг “энэ хуульд заасны дагуу” гэж өөрчилж, 6.1.1 дэх заалтын “шилжилтийн үеийн, эсхүл органик болохыг илэрхийлсэн” гэснийг, 6.1.3 дахь заалтын “энэ хуулийн 8.2-т заасан бодис, хувиргасан амьд организм, цацрагийн боловсруулалт, өсөлтийн даавар хэрэглээгүй болон” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.1.4, 6.1.5, 6.1.6 дахь заалт тус тус нэмэх:

“6.1.4.органик үйлдвэрлэл эрхлэхэд үндэсний, эсхүл олон улсын стандартыг хэрэглэх;

6.1.5.баталгаажуулалтын байгууллагыг сонгох;

6.1.6.хамтын баталгаажуулалтын байгууллагын гишүүнээр элсэх хүсэлт гаргах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39

56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн “7 дугаар зүйл.Органик үйлдвэрлэл эрхлэгчийн үүрэг” гэснийг, мөн зүйлийн 7.1.3 дахь заалтыг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.10 дахь заалт, 7.2, 7.3 дахь хэсэг тус тус нэмэх:

“7.1.2.шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнийг энэ хуулийн 12.2-т заасан журмын дагуу мэдээллийн цахим санд бүртгүүлэх, мэдээллийн үнэн зөвийг хариуцах;

7.1.3.урьдчилан сэргийлэх арга хэмжээг багтаасан шилжилтийн болон органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөний төслийг боловсруулж, баталгаажуулалтын байгууллагаар батлуулан хэрэгжүүлэх, энэ хуулийн 6.6-д заасан мэдээллийн санд тайлан, мэдээг хүргүүлэх;

7.1.4.шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах;

7.1.10.ойн дагалт баялаг, байгалийн ургамлыг түүх ажлыг бусдаар гүйцэтгүүлэх бол холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, зааварчилгаа өгч, тэмдэглэл хөтлөх.

7.2.Сум, дүүргийн байгаль орчны асуудал хариуцсан албан тушаалтан энэ хуулийн 7.1.8-д заасан талбайг тогтоож, тодорхойлолт олгоно.

7.3.Органик үйлдвэрлэлд хэрэглэх бодист тавигдах шаардлага, тэдгээрийг үнэлэх

аргачлал болон жагсаалтыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.8.сүүлийн гурван жилийн хугацаанд энэ хуулийн 8.2-т заасан жагсаалтад орсноос бусад бодисыг хэрэглээгүй, авто зам болон бохирдлын эх үүсвэр, эсхүл органик бус аж ахуйгаас нэг км-ээс багагүй зайтай талбайгаас ойн дагалт баялаг болон байгалийн ургамлыг түүх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.6, 8.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.6.хөрсгүй технологи /гидропоник/ ашиглах;
8.1.7.энэ хуулийн болон эрүүл ахуйн шаардлага хангаагүй, буруу шошготой хуурамч түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, сурталчилах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.1.8 дахь заалт нэмж, мөн зүйлийн 8.2 дахь хэсгийг хасах.

“8.1.8.органик бүтээгдэхүүнтэй харьцах бүх төрлийн гадаргуу, сав, баглаа, боодолд нано бүтэцтэй материал ашиглах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн **ГУРАВДУГААР БҮЛГИЙН** гарчгийн **“ШОШГОЛОЛТ, БҮРТГЭЛ”** гэснийг **“БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САН, ШОШГО”** гэж өөрчилж, төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “тус тус” гэснийг хасаж, төслийн 9.4 дэх хэсгийн “түүнийг байгуулах,” гэсний дараа “бүртгүүлэх,” гэж нэмж, төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.5 дахь хэсэг нэмэх:

“9.5.Баталгаажуулалтын байгууллага нь эрх бүхий байгууллагаас олгосон

давхцалгүй бүртгэлийн дугаартай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.1.органик үйлдвэрлэл эрхлэх, баталгаажуулах тухай гэрээг үйлдвэрлэл эрхлэгчтэй байгуулах, хэрэгжүүлэх, хянах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.4, 10.1.5 дахь заалт нэмэх:

“10.1.4.энэ хуулийн 15.3-т заасан журмын дагуу органик үйлдвэрлэлийн байршил, төрөл, мэдээллийн сангийн бүртгэл, мэдээлэл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дүгнэлт зэргийг харгалзан шаардлагатай тохиолдолд шилжилтийн үеийн хугацааг тогтоох;

10.1.5.энэ хуулийн 12.2-т заасан журмын дагуу органик үйлдвэрлэл эрхлэх, баталгаажуулах тухай гэрээний хэрэгжилт, тохирлын үнэлгээний тайлан, баталгаажуулалтын гэрчилгээ, шилжилтийн болон органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөө, шаардлагатай бусад мэдээлэл, баримт бичгийг мэдээллийн санд оруулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11 дүгээр зүйл.Органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах, бүртгэх

11.1.Үйлдвэрлэл эрхлэгч органик үйлдвэрлэлд шилжих тухай хүсэлтийг мэдээллийн санд илгээхдээ дараах шаардлагыг хангасан байна:

11.1.1.дотоод хяналтын хуудсыг бөглөх;
11.1.2.мэдээллийн санд хэрэглэгчээр бүртгүүлэх маягтыг бөглөх.

11.2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардлага хангасан үйлдвэрлэл эрхлэгчийг хэрэглэгчээр бүртгэж, мэдээллийн санд хандах эрх олгоно.

11.3.Үйлдвэрлэл эрхлэгч мэдээллийн санд бүртгэлтэй баталгаажуулалтын байгууллагаас сонгож, органик үйлдвэрлэлд шилжих тухай хүсэлт, холбогдох бусад мэдээллийг баталгаажуулалтын байгууллагад илгээнэ.

11.4.Баталгаажуулалтын байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

11.4.1.үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаанд урьдчилсан үнэлгээ хийж, хуульд заасан шаардлага хангасан гэж үзвэл органик үйлдвэрлэл эрхлэх, баталгаажуулах тухай гэрээг байгуулж, хэрэгжилтийг хангуулах;

11.4.2.шаардлага хангасан үйлдвэрлэл эрхлэгчид шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнд баталгаажуулалтын гэрчилгээг олгож, холбогдох баримт бичгийн хамт мэдээллийн санд илгээх.

11.5.Мэдээллийн сангаас шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн бүртгэгдсэн тухай мэдэгдэл ирснээр үйлдвэрлэл эрхлэгчид бүтээгдэхүүний шошгод органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдэг хэрэглэх эрх үүснэ.

11.6.Энэ хуулийн 11.4.2-т заасан баталгаажуулалтын гэрчилгээний загварыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.7.Органик үйлдвэрлэл эрхлэгч нь органик үйлдвэрлэлийн талаарх олон улсын стандартын дагуу баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдгийг хэрэглэж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	16
Бүгд:	40

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.3.Органик бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох тохиолдолд гаалийн байгууллага нь тухайн бүтээгдэхүүнийг мэдээллийн санд бүртгэлтэй эсэхийг шалгаж улсын хилээр нэвтрүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	19
Бүгд:	40

52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг, 13.5.1 дэх заалтын “илэрхийлсэн” гэсний дараа, 13.5.2 дахь заалтын “дэвсгэртэй” гэсний дараа “гэрчлэх” гэж тус тус нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.7 дахь хэсэг нэмэх:

“13.7.Улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 13.6-д заасан үг болон эдгээртэй агуулгын хувьд дүйцэх үгийг хуулийн этгээдийн нэрээр баталгаажуулахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	24
-------------	----

Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төслийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.7.Органик бүтээгдэхүүний орц, найрлага тооцох аргачлалыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.3 дахь хэсэг нэмж, төслийн 14.3 дахь хэсгийн “Импортлогч” гэсний дараа “, экспортлогч” гэж нэмэх:

“14.3.Бөөнөөр нийлүүлсэн органик бүтээгдэхүүний шошгоны мэдээлэл жижиглэн савласан органик бүтээгдэхүүний шошгоны мэдээлэлтэй ижил байх ба савласан огноог шошгонд ил харагдахуйц тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төсөлд доор дурдсан агуулгатай 15 дугаар зүйл нэмэх:

“15 дугаар зүйл.Төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэг

15.1.Органик үйлдвэрлэлийн бодлого, эрх зүйн зохицуулалтыг төлөвлөх, удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх чиг үүргийг улсын хэмжээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага, сум, дүүрэгт хөдөө аж ахуйн нэгж хариуцан гүйцэтгэнэ.

15.2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага органик үйлдвэрлэлийн асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.2.1.Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих бодлогыг тусгах, салбар хоорондын уялдааг хангах, хэрэгжүүлэх;

15.2.2.энэ хуулийн 12.1-д заасан мэдээллийн санг байгуулах, шинэчлэх, шаардлагатай бусад мэдээллийн сантай холбох;

15.2.3.шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн, органик үйлдвэрлэл эрхлэгчийг мэдээллийн санд бүртгэх үйл ажиллагааг удирдах, холбогдох мэдээллийг олон улсын байгууллагад хүргүүлэх;

15.2.4.Хүнс хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн бүтцэд органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх судалгааны нэгж байгуулах;

15.2.5.органик үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон бүс нутгийн байгууллагатай хамтран ажиллах, гишүүний татвар, хандивыг улсын төсвөөс төлөх;

15.2.6.органик салбарын Үндэсний зөвлөлийг байгуулах, ажиллах журмыг батлах.

15.3.Органик үйлдвэрлэлд тавигдах шаардлага, баримтлах журмыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.4.Энэ хуулийн 15.3-т заасан журамд дараах асуудлыг тусгана:

15.4.1.мал аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх;

15.4.2.тариалангийн органик үйлдвэрлэл эрхлэх;

15.4.3.органик хүнсийг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх;

15.4.4.зөгийн органик аж ахуй эрхлэх;

15.4.5.хоол үйлдвэрлэл, үйлчилгээг органик зарчимд нийцүүлэн эрхлэх;

15.4.6.хүнсний бус органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх;

15.4.7.органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах, бүртгэх, органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдгийг шошгод байршуулах, нийтийн хэрэгцээнд нийлүүлэх;

15.4.8.органик бүтээгдэхүүнийг хадгалах, савлах, тээвэрлэх, экспортлох, импортлох.

15.5.Органик үйлдвэрлэлийг органик бус үйлдвэрлэлтэй хавсран эрхлэх асуудлыг энэ хуулийн 15.3-т заасан журамд тусгана.

15.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих талаар тухайн орон нутгийг хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулан, үр дүнг мэдээллийн санд оруулна.

15.7.Итгэмжлэлийн байгууллага нь органик бүтээгдэхүүний тохирлын үнэлгээний дүнг олон улс, бүс нутаг, гадаад улстай харилцан хүлээн зөвшөөрөх асуудлыг хариуцна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 16

Бүгд: 40

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтын “дотоодод үйлдвэрлэсэн” гэсний дараа “, баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй” гэж нэмж, мөн заалтын “ашиглаж байгаа тариалангийн анхан шатны” гэснийг “ашиглах тохиолдолд” гэж өөрчилж, мөн зүйлийн 15.1.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 17

Бүгд: 40

57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Төслийн 15 дугаар зүйлийн 15.2.2 дахь заалтын “органик бүтээгдэхүүнийг” гэсний өмнө “баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй” гэж нэмж, 15.2.1 дэх заалтын “ерөнхий боловсролын сургуулийн” гэснийг “бүх шатны боловсролын байгууллагын” гэж, 15.2.3 дахь заалтын “нийлүүлсэн” гэснийг “нийлүүлсэн нь Технологи дамжуулах тухай хуульд заасны дагуу нотлогдсон” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.1.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал.

Л.Мөнхбаатар: Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “үйлдвэр” гэснийг “үйлдвэрлэл” гэж, төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүн” гэснийг “бүтээгдэхүүний” гэж, төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “бичиг баримт” гэснийг “баримт бичиг” гэж, мөн хэсгийн “хяналт” гэснийг “хяналтыг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Органик бүтээгдэхүүний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолоор санал хураалт явуулав.

Нэг.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Л.Мөнхбаатар: Төслийн 1 дүгээр зүйлийн “3.2 дахь заалтын ““үйлдвэрлэл” гэсний дараа “импорт, экспорт” гэж тус тус” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжээгүй санал:

Нэг.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Л.Мөнхбаатар: Төслийн 1 дүгээр зүйлийн 39.1.4.5 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“39.1.4.5.нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсад үйлдвэрлэсэн, баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй органик бордоог ашиглах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Л.Мөнхбаатар: Төслийн 1 дүгээр зүйлийн 22.5.10¹ дахь заалтын “6.1.1-д” гэснийг “4.1.2-т” гэж өөрчилж, мөн заалтын “буюу тариалсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 25
Бүгд: 40
37.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Органик бүтээгдэхүүний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Бусад.Төр нийгмийн нэрт зүтгэлтэн, Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Бираагийн Чимэдийн нэрэмжит Монгол Улсын Их Хурлын 2024 оны шагналтан, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Нанзаддоржийн Лүндэндорж болон “Чимэд сан”-ийн төлөөлөл

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, Ш.Мөнхцоож нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 16 минут үргэлжилж, 72 гишүүнээс 58 гишүүн хүрэлцэн ирж, 80.6 хувийн ирцтэйгээр 16 цаг 37 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 12 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Эрхэм
гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын
Их Хурлын 2023 оны намрын ээлжит
чуулганы 2024 оны 01 дүгээр сарын 12-ны
өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг
мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар
хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, Хууль, тогтоолын
төслүүд эцэслэн батална. Нийт 115
төсөл батална. Үндсэндээ 2 хуультай
холбоотой. Нэг нь бол Нийгмийн эрүүл
мэндийн тусламж, үйлчилгээний тухай
хуулийн төсөл болон хамт өргөн
мэдүүлсэн хуулийн төслүүд. 2 дахь нь энэ
Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр
үзүүлэхтэй холбоотойгоор хууль
хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг
арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай болон бусад
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, нөгөө
цахим гарын үсгийг зөвшөөрч заавал
албан бичиг шаарддаг бүх хуулиудыг
өөрчилж байгаа учраас энэ 100 гаруй
хууль нь бараг үндсэндээ энэ төрийн
үйлчилгээг цахимаар үзүүлэхтэй
холбоотой хуулиуд байгаа. Ийм 2 хуулийн
төслийг дагасан, холбогдуулан
боловсруулсан 115 хуулийн төслийг
батална.

2 дугаарт, Элчин сайд нарыг
эгүүлэн татах, томилох тухай асуудлаар

зөвшилцөх тухай. Монгол Улсын
Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн саналыг
хэлэлцэнэ.

3 дугаарт, “Бүгд Найрамдах
Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод
Монгол Улсын ЭСЯ нээн ажиллуулах
тухай” Улсын Их Хурлын тогтоолын
төслийг хэлэлцэнэ.

4 дүгээрт, “Төрийн
байгууллагуудыг бүсчлэн байршуулах
тухай” Улсын Их Хурлын тогтоолын
төслийг Засгийн газраас өргөн мэдүүлсэн.
Сая ТББХ-оор хэлэлцэн шийдвэрлэсэн
байгаа.

5 дугаарт, “Монгол Улсыг бүсчлэн
хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга
хэмжээний тухай” Улсын Их Хурлын
тогтоолын төслийг хэлэлцэнэ.

6 дугаарт, Органик
бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл
болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн
төслүүдийн төслүүдийг хэлэлцэнэ.
Зарчмын зөрөөтэй 28 саналтай.

Үдээс хойших нэгдсэн
хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн
Баагаагийн Баттөмөрөөс Монгол Улсын
Ерөнхий сайд Оюун-Эрдэнэд хандаж
Монгол Улсын гадаад өрийг бууруулах
чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ,
цаашид баримтлах бодлогын талаар
тавьсан асуулгын хариуг сонсохоор
байгаа. Гэхдээ Баттөмөр гишүүн
мэдээллийг шинэчлэх шаардлагатай
учраас хойшлуулъя гэсэн санал ирүүлсэн,
албан бичиг ирүүлсэн байна. Ийм учраас
үдээс хойших асуулгын хариуг хойшлуулж
эдгээр асуудлуудаа бүгдийг нь хэлэлцэж
дуусгана.

Оронд нь өөр асуулга оруулж
болохгүй. Нөгөө урьдчилж материал
тараадаг дэгтэй учраас.

Монгол Улсын Их Хурлын чуулганы
хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д

заасны дагуу гишүүн хэлэлцэхээр тогтсон асуудлын тов, дарааллын өөрчлөх, асуудал нэмэх, горимын санал гаргах бол хуралдаан эхлэхээс өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа, Бөхчулууны Пүрэвдорж, Норовын Алтанхуяг нараас албан бичиг тус тус ирүүлсэн байна.

Ингээд Ширнэнбаньдын Адьшаа гишүүн 1 дүгээр сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хэлэлцэгдэх асуудалтай холбогдуулан өгөх саналаа үүгээр хүргүүлж байна гэсэн байна. Хэлэлцэгдэх асуудалтай.

Ш.Адьшаа: Эрхэм гишүүдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая. Энэ өдрийн хэлэлцэх асуудлаас нэг асуудлыг татаж авахыг би Их Хурлын гишүүний хувьд санал гаргаж байгаа юм. Сая энэ ТББХ-оор бүсчилсэн хөгжил, түүний дотор төрийн байгууллагуудыг орон нутагт шилжүүлэх тухай тогтоолын төсөл хэлэлцэж байна. Бид энэ эрх барьж байгаа улс төрийн хүчний бүх үйл ажиллагааг, ард түмний саналыг хүндэтгэж, дэмжиж ирсэн. Энэ ЗГ энэ эрх барьж байгаа улс төрийн хүчний энэ зарим зүйл чинь ингээд хэрээс хэтэрч байна. Сонгууль дөхсөн, дээр нь энэ бүсчилсэн хөгжлийн бодлого гэдэг нэрийн доор төрийн байгууллагуудыг орон нутагт шилжүүлнэ гэдэг энэ чинь цаг үеэ олсон асуудал юм уу. Ямар зүйлд зориулж ийм бодлогогүй, дээр нь судалгаагүй ийм юмыг оруулж ирж энэ Улсын Их Хурал нэг ажил хийсэн дүр эсгэж, ЗГ 1 бодлого боловсруулж байгаа ийм шийдэл маягаар ингэж цаг өнгөрөөхийг бид ард түмэн зөвшөөрөхгүй шүү дээ.

Тэгээд яах юм. Зам тээврийн яамыг Ховд аймаг руу, Хууль зүй, дотоод хэргийн яамыг Дорнод руу нүүлгэх юм уу. Түүний оронд энэ Хархорин хотоо нийслэл болгох асуудлыг бодлогын хэмжээнд оруулж ир ээ, эрх баригчид аа. Өнөөдөр орон нутаг руу яам тамгаа нүүлгэх байтугай Яармагт очсон Байгаль орчны

яаманд очих гэж ямар хүнд суртал гарч байна. Ямар асуудал гарч байна. Ингээд цаг үеэ олоогүй, ямар ч тооцоо судалгаагүй, юунд зориулсан ийм юмыг оруулж ирж энэ УИХ-аар хэлэлцүүлдэг юм бэ. ЗГ энэ асуудлаа татаж ав. Цаг үеэ олсон энэ ард түмний амьдрал, энэ зуд зурхан, бусад энэ сахилга хариуцлага, энэ хууль шүүхийн асуудлыг энд оруулж ирмээр байна. Оруулж ирмээр байна.

Одоо нөгөө их дуулиан шуугиан болсон нүүрсний сонсгол чинь хаачсан юм. УИХ-ыг Онцгой бүрэн эрхт комисс болгож гучаад оны асуудлыг санагдуулсан энэ нүүрсний хулгай луйврынхаа сонсголыг энэ Улсын Их Хуралд оруулж ирж яаралтай хэлэлцүүл л дээ. Яагаад үүнийг ингээд байгаад байгаа юм. Олон асуудал өнөөдөр ээдрээ будилаантай байгаа шүү дээ. Тэгээд л ингээд л нэг бүсчилсэн яам, тамга хөдөө орон нутаг руу нүүлгэнэ гээд ийм үлгэр яриад, цаг хугацаа алдаад ийм байдлаар өнөөдөр цаг өнгөрөөж болмооргүй байна, болмооргүй байна.

Дээр нь өнөөдөр би Улсын Их Хурлын даргад дахиад нэг хүсэлт тавья. Халзан Бүргэдэйн асуудлаар Монгол Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд Ерөнхий сайдад асуулга тавьсан. Жил гаруй болж байна. Яагаад үүгээр оруулж ирдэггүй юм бэ? Цөөнхийн гишүүний юм оруулж ирдэггүй юм уу? Нэг бол улс төрийн том эрх ашиг бүлэглэлийн асуудал байгаа учраас энэ асуудлыг ард түмнээс нуух, хаах асуудал байгаа учраас энэ Халзан бүргэдэйн асуудал оруулж ирдэггүй юм уу? Үүнийгээ оруулж ирмээр байна. Нэг оруулж ирээд Амарбаясгалан дарга бичиг өгөөд буцаачихсан. Одоо энэ асуудлаа оруулж ирье. Бид нар өнөөдөр ингээд сонгуулийн цикл эхэлсэн учраас хүмүүст таалагдах, хүмүүсийг хуурах, ард иргэдийн толгойг эргүүлсэн ийм асуудал ярихаа больё оо. Бүсчилсэн хөгжлийг ярих ёстой. Тэгээд энэ яам, тамга нүүлгэнэ энэ тэр гэдэг юмыг зүгээр нэг хууран мэхэлсэн юм хиймээргүй байна.

Дээр нь өнөөдөр энэ бүсчилсэн хөгжлийн бодлогынхоо асуудлуудыг бүр

бодлого гаргаж, тэр мөрийн хөтөлбөртэй, тусгай багтай явж үүнийг шийдэхээс биш энд нэг хэдэн судалгаа тооцоогүй тэр хэрэг эрхлэх газрын референтүүд юм хариулж чадахгүй байна шүү дээ. Сая ТББХ-г би харсан. Ингээж ажил явмааргүй байна. Эндээ та нар дүгнэлт хий. Энэ өвлийн хүйтэн болсон, цаг хугацаа, энэ чуулган чинь завсарлах болж байна.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Иргэдийн амьдрал маш хүнд байна. Өдрөөс өдөрт ядуурал нэмэгдэж байна. Тэгээд ҮСХ Дэлхийн банкнаас гаргадаг статистикаар 2020 онд 1 сая хүн нэн ядуу байна гэж дүгнэлт гаргасан. Гэтэл өнөөдрийг хүртэл 22 он хүртэл 23 он дуусаж байхад 3 жилийн туршид ядуурлын статистикийг ерөөсөө гаргасангүй ийм нөхцөл байдалд байж байна. Энэ нь юу илрүүлж байна вэ гэвэл улам их ядуурал нэмэгдсэн гэсэн үг. Тэгээд энэ бараа бүтээгдэхүүний үнэ өсөлт бол иргэдийн карман дахь мөнгийг тэр чигээр нь хоосолж байна. Яг 2022 оны 02 сарын 01-ний өдөр 50 мянган төгрөгийн үнэтэй байсан гурил өнөөдөр 140 мянган төгрөг болж өссөн байж байгаа, 120 хувиар инфляцад идэгдэж өссөн байж байна. Тэгээд энэ их бараа бүтээгдэхүүний үнэ өсөлтийг буулгах талаар ЗГ ерөөсөө ажил хийхгүй байгаад байгаа.

Тэгээд иргэдийн амьдрал буулгаж маш муу байгаагийн нэг статистик тоог та бүхэнд хэлье. Өнөөдрийн байдлаар 25 их наяд төгрөгийн зээл банкны салбараас нийт зээл гарсан байгаа. Тэрний 15 их наяд нь бол яг цэвэр иргэдийн цалингийн зээл, тэтгэврийн зээл, хэрэглээний зээл байж байгаа. Ипотекийн зээл зэрэг. 10 их наяд нь бол бизнесийн зээл байна. Ингээд 60 хувь болж байна.

Дээрээс нь ББСБ, ХЗХ, тэгээд ломбардын зээл бол тэр чигээрээ хувь хүний зээл байдаг. Ингээд нийт зээлийн 75 хувь нь иргэдийн зээл, 25 хувь нь бизнесийн зээл байгаа. Компани, аж ахуйн нэгжийн.

Энэ бол юуг илэрхийлж байна вэ гэвэл иргэд цалин, тэтгэвэр нь огт хүрэлцэхгүй, энэ зээлээс зээлийн хооронд амьдарч, ямар ч хуримтлалгүй болсон энэ л нөхцөл байдлыг илэрхийлж байгаа байхгүй юу даа. Гэтэл дэлхий даяар яадаг вэ гэхээр нийт банкных нь зээлийн хөгжингүй орнуудын нийт банкны зээлийн 25 хувь нь л иргэдийн зээл байдаг. 75 хувь нь бизнесийн зээл байдаг юм.

Тийм учраас энэ иргэдийн амьдрал маш хүнд байна. Цагаан сараа яаж хийх вэ гэж хүмүүс санаа зовниж байна. Тийм учраас энэ миний 1 сарын өмнө гаргасан Эрдэнэс Тавантолгой энэ жил 3 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж байгаа. Өнгөрсөн жилийн 1,3 их наядын цэвэр ашиг байгаа. Ингээд нийтдээ 3,3 их наяд төгрөгийн цэвэр ашигаас бас тодорхой хувийг нь авч үлдээд 580 мянган төгрөгийг иргэн болгондоо өгөх тэр санаачилгыг дэмжихгүй бол болохгүй нь. Яагаад гэвэл энэ цагаан сараас өмнө иргэддээ бас нэг хэдэн төгрөгийн энэ ядууралд хэт их нэрвэгдсэн, та нараас болоод 8 жил энэ янз янзын төрийн өмчийн компаниудыг хулгайлсан хулгайнаас болоод эдийн засаг буурсан, ядуурсан. Энэ зүйлийг шийдэхийн тулд Эрдэнэс Тавантолгойн тэр 580 мянган төгрөгийн ноогдол ашигийг өгөхийг шаардаж байна. Хэрвээ түүнийг өгөхгүй манай Ардчилсан намын бүлгийн Эдийн засгийн зөвлөх Даваадоржийн хэлснээр хос картын бодлого буюу энэ цагаан сарын дараагаар 4 сарын сүүл, 5 сарын эхээр 1000 доллар өгөхөөс өөр аргагүй болно. Ард иргэд 1000 доллар нэхнэ. Энэ үед ямар асуудал үүсэх вэ гэдгийг та нар бүгдээрээ мэдэж байгаа.

Цалин, тэтгэврийг 4 сарын 1-нээс нэмсэн нь энэ бас учиртай. Манай ард иргэд ээ. Хэрвээ 1 сарын 1-нээс нэмсэн бол 5 сарын эхэн гэхэд аль хэдийн инфляцтай цалин, тэтгэвэр нэмэгдэнгүүт барааны үнэ нэмэгдчихдэг, барааны үнэ нэмэгдчихээр нөгөө цалин, тэтгэвэр нэмэгдсэний огт үр дүн гардаггүй. Тийм учраас 4 сарын 1-нд нэмж байгаа хэрэг шүү дээ. Тэгээд дээрээс нь дахиад энэ ЗГ

тэр хос картын бодлогын дагуу 1000 доллар өгөх юм бол энэ иргэдийн бараа бүтээгдэхүүний үнэ ямар их өндөр өсөх вэ гэдгийг та нар бүгдээрээ мэдэрч байгаа байх.

Тийм учраас энэ иргэдэд өгөх ёстой, боломжтой тэр зүйлээ эртхэн өгөөд асуудлаа шийдээд, энэ ард иргэдийн энэ ядуурлаас бас хугаслах, хагаслах энэ зүйлийг яаралтай хийхгүй бол болохгүй нь. Цагаан сарын өмнө тэр Эрдэнэс Тавантолгойн ноогдол ашгийн 580 мянган төгрөгийг иргэн болгонд өгөхийг шаардаж байна.

Г.Занданшатар: Норовын Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Өглөөний амрыг айлтгая. Би нэг 2 асуудал хэлэх гэж байгаа юм.

1 дүгээр асуудал нь бол манай Их Хурал дээр энэ тоо баримт, мэдээллийг зориуд гуйвуулдаг, худлаа ярьдаг ийм юм нэлээн ийм архагшсан шинжтэй байгаа. Тийм учраас энэ дээр 2 асуудлаар би Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэдээ асуулга тавьсан юм. Их Хурлын дарга анхаарч, үүнийг бас асуулгыг маань Их Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж өгөөч ээ л гэж би хүсэж байгаа юм. Би өмнө нь нэг 2 удаа асуулга тавьсан хоёуланг нь чуулганаар хэлэлцүүлж өгөөч гэсэн, ороогүй юм. Тэгэхээр энэ удаа нэг оруулж өгөөч.

1 дүгээр асуудал нь Төсвийн тогтвортой байдлын тухай болон Ирээдүй өв сангийн тухай хуулийн хэрэгжилт ер нь ямархуу байгаа юм бэ? Үүнийг ингээд асуухаар энэ Их Хурал дээр худлаа юм яриад өнгөрчихдөг учраас асуулга тавиад, цаасаар нь авчихсан хөдөлгөөн байхгүй. Одоо үүнийг олон нийтэд энэ олон тоонуудыг хүргэх юм байна. Ирээдүй өв санг яаж алж, идсэнийг би тэр асуулгын хариулт дээр байна лээ. Тэгэхээр түүнийг нь бол сонсгомоор байх юм. Тэгэхгүй бол

Алтанхуяг худлаа яриад байгаа юм шиг ингээд юм яриад байдаг.

Төсвийн тогтвортой байдлын сан гэдэг юмыг чинь түүхий эдийн үнэ унасан үед нь түүнийг гаргаж хэрэглэдэг юмыг зүгээр төсвийн цоорхой нөхдөг ийм хэрэгсэл болгосон уу гэдгийг бас нөгөө баримт фактууд нь бол гараад ирчихсэн байна лээ. Тэгэхээр үүнийг ард иргэдэд хүргэмээр байна. Манай ард иргэд үнэнийг мэдэх эрхтэй. Тэгэхээр үүнийг Занданшатар дарга маань хэлэлцэх асуудалд оруулж өгөөрэй.

2 дахь нь, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар би асуулга тавьсан. Нэлээн их баримт материалууд ирсэн байна лээ. Тэгэхдээ Байгаль орчны яамныхан хулхидсан байна лээ. Нэг 40, 50 хуудас ямар ч хэрэггүй материалыг хавсралт болгоод явуулчихаж байж байх жишээтэй. Ер нь энэ бас яам, тамгын газар, Их Хурлын гишүүдийн тавьж байгаа асуулга энэ тэрт бас дахиад зөв бодитой баримттай тийм цаас ирүүлэх шаардлагатай. Тэгэхдээ яах вэ, энэ дотор бас иргэд сонсоод мэдээлэл авчихаар одоо ер нь цаашидаа энэ агаарын бохирдол гээд яах гэж байгаа юм бол. Мийтлинг гэдэг юмаа түлээд ингээд зарим үзүүлэлтүүд нь хортой байгаа, үүнийгээ үргэлжлүүлээд байх юм болов уу? Эсвэл хагас кокс руу шилжчих юм болов уу? Ер нь тэгээд энэ мийтлинг гэдгийг хэрэглэснээс хойш ямар ямар үзүүлэлтүүд нь сайжирсан юм, ямар үзүүлэлтүүд нь муужирчхаад байгаа юм. Үүнийг ер нь яаж шийдэх гэж байгаа юм гээд нэлээн олон асуудлууд бас түүн дээр ирүүлсэн байна лээ. Асуулгын дагуу.

Тэгэхээр үүнийг бас ингэж сонсгомоор байна, иргэдэд сонсгомоор байна. Би энэ 10 сард л хэлсэн шүү дээ. Энэ өвөл ер нь энэ юу түлж өвөлжих гэж байгаа юм бол, ямар ямар хортой бодис нь ялгарах юм бол? Аргаа барвал тэр ийм юм түлнэ ээ, ийм ийм хортой бодис гарна шүү, та нар минь маск зүү, тийм төрлийн маск илүү дээр шүү, хүүхдүүдээ яах вэ, зөв

юм хийсэн манайхан. Их Хурлынхан байна уу, засаг байна уу, энэ өвлийн амралтыг нь жаахан урт болгож өгсөн. Яах вэ, ингээд нэг агаар салхинд арай жаахан хотын утаанаас чинь холдуулах арга хэмжээ гээд авсан. Тэгэхээр энэ нэг зарчим л ер нь их сонин болчихоод байна. Би энэ Их Хурал дээр. Ард иргэдийг мэдээлэлжүүлэх гэдэг юм номер нэг асуудал байх ёстой. Мэдээж хэрэг бид нарын хийж байгаа, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ 100 хувь төгс төгөлдөр бас хараахан болж чадахгүй тийм тохиолдлууд бол зөндөө гардаг. Тийм учраас ийм хор уршиг хүргэж магадгүй шүү. Үүнээс хүүхдүүдээ, өөрсдийгөө, бусдыгаа, гэр бүлээ ингэж хамгаалаарай гэдэг ийм л юм Их Хурал дээр л ярьж, хэлж, сэрэмжлүүлж байх ёстой.

Тэгээд Занданишатар дарга та миний хэлээд байгаа Төсвийн тогтвортой байдлын тухай болон Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Засгийн газраас надад ирүүлсэн асуулгын хариу, мөн түүнчлэн агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх асуулгын хариуг УИХ-аар хэлэлцэх асуудалд оруулж өгнө үү. Баярлалаа.

Г.Занданишатар: Гишүүд хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлж дууслаа.

1 дүгээрт, Адьшаа гишүүний ярьсан 3 асуудал байна. Тэр төрийн байгууллагуудыг бүсчилж байршуулах асуудлыг өнөөдөр хэлэлцэх асуудлын жагсаалтаас хасъя гэсэн горимын санал гаргасан. Энэ саналаар санал хураалт явуулна.

2 дугаарт, Нүүрсний сонсголттой холбоотой асуудлаар. Нүүрсний сонсгол зохион байгуулагдаж, нүүрсний хулгайтай холбоотой асуудлыг хянан шалгах Түр хорооны тайлан, дүгнэлтийг Түр хороо хэлэлцэж, санал, дүгнэлтээ боловсруулж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан. Холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгсөн Улсын Их Хурлын тогтоолын

төслийг боловсруулж өгсөн байгаа. Ингээд ирэх 7 хоногийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, нүүрсний сонсголын санал, дүгнэлтийг сонсож. Ингээд Нүүрсний хяналт шалгалтын түр хорооны үйл ажиллагаа дуусгавар болж холбогдох байгууллагуудад чиглэл өгнө. Ийм Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуультай. Тийм учраас Адьшаа гишүүний яриад байгаа шиг тэр нүүрсний сонсгол хийгдээд мартагдсан хаягдсан зүйл байхгүй. Үүний заалт бүрийн талаар худал, үнэнийг нь олохын төлөө, үнэн зөвийг тогтоохын төлөө, ард түмэнд тэр мэдэх эрх мэдээлэх эрхийн хүрээнд сонсогдсон яригдсан зүйлүүд үнэн зөв бодитой байх эсэх асуудлыг шалгахын төлөө Улсын Их Хуралд анхаарал тавьж ажиллана.

3 дугаарт нь, Халзан бүргэдэйн асуудлаар Адьшаа гишүүн асуулга тавиад тов 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн товд оруулаад хэлэлцүүлэх байсан боловч Засгийн газрын санал болон өөртэй нь ярилцсан гээд ингээд хойшлуулсан. Тэгээд ахиж тов тогтоох хүсэлт ирүүлээгүй.

Алтанхуяг гишүүн агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдөр хариугаа авсан байна. Түүнээс хойш тов тогтоолгох бичгээ ирүүлээгүй байна. Та тэгэхээр Улсын Их Хурлын Тамгын газарт өчигдөр өгсөн үү? Өнөөдөр жагсаалтад системд ороогүй байна. Тэгэхээр тов тогтоолгож, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх тов тогтоолгох, саналаа ирүүлэх ёстой.

Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай болон Ирээдүй сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хариугаа авсан байна. Бас тов тогтоолгох бичиг ирээгүй байна. Энэ 2 тов тогтоолгох бичгээ өгөхөөр ингээд ирэх 7 хоногт чинь чуулган 4 дэх өдөр хаахаар төлөвлөж байгаа. Тэгэхээр хаврын чуулганаар л

сонсох нь байна гэж та бодох хэрэгтэй болж байна.

Ингээд эцэст нь ер нь ард иргэдийг мэдээлэлжүүлэх, иргэдийн мэдэх эрхийг хангахтай холбоотойгоор хууль тогтоомжийн төслийг Засгийн газраас өргөн барьж хэлэлцүүлэхдээ ард иргэдийн саналыг авч, Засгийн газрын гишүүд нэгдмэл байр суурьтай байж, олон санаа дагуулж болохгүй гэж нэгдсэн зарчмаар орж ирэх хэрэгтэй байна. Ийм учраас Улсын Их Хурал бол ард түмний төлөөлөгчдийн байгууллага учраас ард түмэн хэн байгаа нь ч гэсэн иргэний нийгмийн байгууллага улс төрийн намуудаас уулзаж саналыг нь авч сонсож бид хариу өгнө. Хэнтэй уулзахаа хэнээр ч заалгахгүй ээ, ард түмэнтэйгээ уулзаж ярилцах ёстой. Маш олон төрийн бус байгууллагууд, улс төрийн намуудаас ирж байгаа саналуудыг харгалзан үзэх ёстой, хууль тогтоох үйл ажиллагаанд. Аль нэг талыг баримталж хүчээр шийддэг асуудал байхгүй. Тийм учраас үүнийг онцгой анхаарвал зохино.

Ер нь цаашидаа ийм асуудлуудыг зөвлөлдөх ардчиллын механизм аргачлалаар тал бүрийн санал бодлыг сонсож, хэлэлцэж байх ёстой шүү. Тэгээд л үнэн худал нь мэдэгдэхгүй мэдээллээр ард түмнийг төөрөгдүүлдэг, хагаралдуулдаг, зөрчилдүүлдэг. Тэгээд эцсийн эцэст нь муу нэртэй, луу данстай Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурал руу бүх хог, шүүмжлэлээ шидэж байдгаа боливол таарна. Энэ дээр Улсын Их Хурлын гишүүдийн эрх ашгийг хамгаалахын төлөө харин бид нар харин ёстой хатуу ярина шүү. Тэгээд л муу л юм болохоор Улсын Их Хурлын буруу. Тэгтэл оруулж ирж байгаа хууль яригдаж байгаа асуудлууд нь ямар байна? Үүнийгээ Засгийн газрын гишүүд онцгой анхаарвал зохино.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орёе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд

хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан.

Ингээд санал хураалтыг явуулна.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд суудалдаа сууя. Норовын Алтанхуяг гишүүн хууль эцэслэн батлахад оролцвол их сайн байна. Санал хураалт.

Бүртгэлийн санал хураалт явуулахад энэ Адъяа, Алтанхуяг, Анандбазар, Батлут, Бат-Эрдэнэ, Бейсен, Болорчулуун, Ганбат, Дэлгэрсайхан, Жавхлан, Саранчимэг, Ундром, Цогтбаатар нарын гишүүд бүртгэлд ороогүй байна. Энэ гишүүнийг тасалснаар тооцно шүү. Бүртгэлийн санал хураалт дууслаа.

Одоо Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Пүрэвдорж гишүүн ээ, Туваан гишүүн ээ, энэ Чинзориг гишүүн чинь ам нь болдоггүй боловч бол сэтгэл нь бол цагаан юм байгаа юм. Хоргүй юм байгаа юм, зайлуул.

Санал хураалт явуулъя. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн нийтийн биеийн тамирын хуулийн хэлэлцүүлэгт энэ Баянтамирынхны бас нэг уулзалт асуудал гараад түр чөлөө аваад, 40 гэхэд орж ирнэ гээд гарч ирсэн. Одоо орж ирэх байх, өглөө 9:40-д орж ирж ирцэд бүртгүүлсэн.

Санал хураалт явуулна. Санал хураалт явуулъя.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Эцэслэн батлах санал хураалт дээр үг

байхгүй. Дараа нь эцсийн найруулга сонсох дээр эцсийн найруулга редакцыг ярина.

Норовын Алтанхуяг гишүүнийг суудалд суухаар санал хураалт явуулна. Баттөмөр гишүүн суудалдаа суугаарай.

Санал хураалт. 41 гишүүн дэмжиж, Нийгмийн эрүүл мэнд, тусламж үйлчилгээний тухай хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт, санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

4. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Өнөөдөр олон асуудалтай.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Одоо бол эрүүл саруул мэтгэлцээн өрнүүлж, зөвлөлдөх ардчиллын аргаар тэр 2-ыг би бол эвлэрүүлье гэж бодож байгаа шүү дээ. Пүрэвдорж л их гомдох юм байна даа.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн, Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Энэ Чинзориг сайд хажиглаж хардсаар байгаад явуулчихлаа. Ер нь тэгээд энэ сайд нар ч, гишүүд ч гэсэн ойрын нөхөд хэрэлдэхэд холын дайсан баярладаг гэдгийг байнга санаж явж бай.

2. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

3. Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Энэ Чинзориг сайд ингээд нэгэндээ яах гэж нэр өгч байдаг юм. Ад шоо үзээд л байсан тэгээд л одоо гүйдэг Адьшаа гэж хүнд нэр өгч байна, болохгүй шүү дээ. Энэ нөгөөдөх нь ч гэсэн зөвшөөрөөд. Үгүй ээ, та 2 л тийм юм яриад байгаа юм. Тэгж болохгүй шүү гэж байгаа юм. Нөгөө яг хууль батлахад гарч гүйдгээ болцгооё.

5. Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Тэгээд зөв өө гэхээр чинь л би дэмжиж үг хэллээ шүү дээ. Та 2 санал нийлж байна гэж байна.

6. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хуулийн эцэслэн батлагдлаа.

Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

11. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийг шилжүүлэх, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Адьяа гишүүнийг суудалдаа суухаар санал хураалт явуулна. Адьяа гишүүн ээ, суудалдаа суугаарай, санал хураалт үймүүлээд байна. Санууллаа. Гишүүдийг санал хураалт өгүүлэхгүй ингээд үймүүлээд яваад байна, санууллаа. Сануулах арга хэмжээ авлаа. Дараа нь цалин хасна. 15 хувиар хасъя гэсэн өөрөө санал тавьж байгаа юм уу? Адьяа гишүүн хурал үймүүлж байгаа учраас цалингийн 15 хувиар, цалингийн 15 хувийг

хасах саналын арга хэмжээг өөрийнх нь саналаар авлаа.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

14. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

15. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Орчихсон шүү дээ, та нар орчихсон.

16. Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Векселийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн

баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, 82,4 хувийн саналаар хууль эцэслэн батлагдлаа.

21. Газрын тосны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

22. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

23. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

43 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

24. Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

25. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

26. Далай ашиглах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг

эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Дараа нь Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Захиргааны ерөнхий хуулийн санал хураалт. Дараа нь Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Бэлдэж байгаарай.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн санал хураалт.

Дараа нь 34 дэх санал хураалт. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Аубакир, Батлут гишүүн. Дамбын Батлут гишүүн.

Д.Батлут: Сая санал өгсөн боловч төхөөрөмж ажилласангүй. Саяын санал

хураалтыг хүчингүй болгож өгч, ахиж санал хурааж өгнө үү гэж хүсэж байна.

Г.Занданшатар: Батлут гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

41 гишүүн дэмжиж, 80 хувийн саналаар Батлут гишүүний санал дэмжигдлээ. Тийм учраас 33-д энэ цахим хөгжүүлэлттэй холбоотой санал хураалтын 33 дахь санал хураалт. Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг дахиж явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

35. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль зөрчсөн нь батлагдлаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

39. Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

45. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Ж.Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Би дэмжиж санал өгсөн боловч төхөөрөмж ажилласангүй. Санал хураалтыг дахин явуулж өгнө үү? Баярлалаа.

Г.Занданшатар: Хүчингүй болгож өгнө үү гэсэн үү? Ганбаатар гишүүний гаргасан санал хураалтыг хүчингүйд тооцох горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

46. Монгол Улсын Хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

45. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг дахиж явуулъя.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

47. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя

гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зочид танилцуулъя.

Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Бираагийн Чимэдийн нэрэмжит Монгол Улсын Их Хурлын 2024 оны шагналтан, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Нанзаддоржийн Лүндэндорж болон Чимэд сангийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Монгол Улсын Их Хурлын даргын 2014 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 176 тоот захирамжаар судалгаа шинжилгээнд суурилсан хууль тогтоох ажиллагааг хөгжүүлэх, парламентат ёс, парламент судлал, Үндсэн хуулийн эрх зүй, үндэсний эрх зүйг тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр үнэ цэнтэй томоохон бүтээл туурвисан эрдэмтэн, судлаачдыг хөхүүлэн дэмжих зорилгоор төр, нийгмийн зүтгэлтэн, Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Бираагийн Чимэдийн нэрэмжит шагнал олгох журмыг баталсан. Үндсэн хуулийн эхийг баригч Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч Бираагийн Чимэдийн нэрэмжит шагналыг 2015 оноос хойш жил бүр нэг хүнд эсхүл судлаачдын багт олгож ирсэн бөгөөд Бираагийн Чимэдийн нэрэмжит Монгол Улсын Их Хурлын 2024 оны шагналыг философийн ухааны доктор, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Лүндэндорж хүртсэн юм.

Монгол Улсын Үндсэн хуульд ёсны үнэт зүйл, үзэл баримтлалыг олон нийтэд таниулан сурталчлах, түүгээр дэлгэрүүлэх, Үндсэн хуулийн эрх зүйн салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр

оруулж, Монгол Улсын Үндсэн хууль, шинжлэх ухааны тайлбар, бүтээл туурвисан доктор Нанзаддоржийн Лундэндорж танд Монгол Улсын Их Хурлын нэрийн өмнөөс чин сэтгэлийн халуун баяр хүргэе.

Үндсэн хуулийг мэдэгтүн, сахихтүн гэсэн энэ үндсэн утга агуулга бол Үндсэн хуулийг ойлгож, тайлбарлаж, мэдэж, тэгээд хэрэгжүүлэх энэ эрхэм үүрэг оногдож байгааг Их Хурлын гишүүд Үндсэн хууль дээрээ тангарагаа тавьж, Үндсэн хуулийг эрхэмлэн дээдэлж, сахин хамгаалахаа тангарагладгаас эхэлдэг. Ийм учраас хууль тогтоох бүхий л үйл ажиллагаанд Үндсэн хуулиа дээдлэн оролцож байх учиртай.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Санал хураалтыг үргэлжлүүлэе.

48. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн суудалдаа сууж байгаад санал хуралтад оролцоно уу. Пүрэвдорж гишүүн ээ суудалдаа сууна уу? Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Санал хураалт.

Энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Минийх дарсан боловч эсрэг гарсан байна. Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт дахиж явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

49. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Ирц унаад байна. Гишүүд анхаараарай.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Саналаа өгөөрэй, саналаа.

40 гишүүн дэмжиж, хуульд эцэслэн батлагдлаа.

52. Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Саналаа өгөөрэй, саналаа өгөөрэй, саналаа өгөөрэй. Чинзориг гишүүн, Чинзориг гишүүн, Чинзориг. Тэмүүлэн гишүүн саналаа өгөөрэй.

Энэ санал хураалт их сонин юм аа. Яг унисан мөртөө эсрэг гараад байгаа юм. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Миний санал унисан мөртөө эсрэг гараад байна. Санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

54. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Хүүш, энэ яг уншаад эсрэг гараад байх юм. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалтыг миний горимын саналаар санал хураалт явуулъя. Төхөөрөмж ажиллахгүй байна. Санал хураалт.

73,5 хувийн саналаар санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулна.

Цогтбаатар гишүүн ээ, тэр хавиар эсрэг гараад байна шүү. Хаана ярьж байгаа, тэр газар л эсрэг байна.

Санал хураалт.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

56. Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Энэ нахихгүйхэн шиг ингээд шулуухан явуулчихмаар байна.

57. Нөхөрлөлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Олон нийтийн радио телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Содномын Чинзориг сайд, гишүүн. Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Дарга аа, саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахиж санал хураалт явуулъя. Энэ уншаад байгаа ч эсрэг гараад байна.

Г.Занданшатар: Чинзориг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт дахиж явууллаа шүү.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

59. Органик хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын

томъёоллоор санал хураалт явуулъя.
Санал хураалт.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

60. Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Ж.Бат-Эрдэнэ гишүүн, Жавхлан гишүүн. Энэ Пүрэвдорж гишүүн үймүүлээд байна л даа. Сая Бат-Эрдэнэ гишүүний нэрийг дуудаж байгаад тэгээд саналаа өгсөн чинь эсрэг гарчихсан. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн. Яах вэ, нэр нэгтийн чих нэг гэж.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ Пүрэвдорж гишүүн элдэв янзын юм асуусаар байгаад уучлаарай, юу кноп дээр амжсангүй. Дахин зарлуулж өгөөч. Санал хураалтыг хүчингүй болгож өгөөч.

Г.Занданшатар: Бат-Эрдэнэ гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

39 гишүүн дэмжиж, хууль. Горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг дахиж явуулъя.

Энэ чинь харин ажиллахаа больчихлоо шүү. Энэ ажиллахаа больчихсон шүү.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

63. Патентын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Санхүүгийн түрээс лизингийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

СӨХ-ны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцын байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хуулийн 3-ны 2 нь батлагдаад байна. 3-ны 1 л үлдэж байна.

73. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

ТББ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

75. Төрийн хянан шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Ундрaм, Чойжсоо 2 юм уншаад суугаад байсан. Баттогтохын Чойжилсүрэн гишүүн.

Б.Чойжилсүрэн: Санал хураалт тоног төхөөрөмж гацах шиг боллоо. Эсрэг гарчихлаа. Хүчингүй болгож өгөх горимын санал гаргаж байгаа.

Г.Занданшатар: Чинбатын Ундрaм гишүүн. Ундрaм гишүүн.

Ч.Ундрaм: Дарга аа, би энэ дэмжсэн санал өгсөн боловч төхөөрөмж ажилласангүй. Тийм учраас санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалгаж өгнө үү.

Г.Занданшатар: Горимын саналаар энэ 2 гишүүний горимын саналаар санал хураалт явуулна. Тэгэхдээ би та 2-ыг харж байсан. Та 2 санал

өгөөгүй байхгүй юу. Нэг нь юм уншаад, санал өгөөгүй мөртөө санал өгсөн гээд худлаа ярьж болохгүй шүү.

Гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

84 хувийн саналаар санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

78. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

ХЗХ-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг

эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

84. Хог хаягдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

85. Хоршооны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

86. Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хувиргасан амьд организмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

88. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг

эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

89. Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Саналаа өгцгөөгөөрэй. Хонх яагаад удаад байна.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

90. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Саранчимэг, Нямаагийн Энхболд нарын гишүүдийнх эсрэг гараад байгаа шүү.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

91. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Саналаа өгцгөөгөөрэй. Арван наймхан санал үлдсэн байгаа.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

92. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Саналаа өгцгөөгөөрэй.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

93. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Туваан гишүүн ээ, саналаа өгөөрэй.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. Гишүүд саналаа өгцгөөгөөрэй. Хрван хоёрхон санал хураалт үлдсэн байгаа.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Үүнийг санал хураачихсан.

97. Хөрөнгө оруулалтын тухай хуульд. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцъё.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг

эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Саналаа өгцгөөгөөрэй. 9 санал үлдсэн байна.

40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

100 дахь хуулиа батлах гэж байна. 100. Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Бейсен, Бейсен гишүүн ээ.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Мөнхцэцэг гишүүн ээ, саналаа өгөөрэй.

39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Дөрөвхөн санал хураалт үлдсэн байна. Гишүүд саналаа өгөөрэй. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Уучлаарай, сая санал хураалт дээр уг нь дарсан юм. Тэгсэн чинь ингээд сөрөг гарчихлаа. Тэгээд дахин санал хураалт явж, үүнийг хүчингүй болгож өгнө үү? Баярлалаа.

Г.Занданшатар: Оюунчимэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Тэгэхдээ Оюунчимэг гишүүн хойшоо хараад байсан юм. Батжаргал, Пунцагаа гишүүн 2 руу л.

78 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Санал хураалт дэмжигдсэн учраас санал хураалтыг дахиж явуулъя.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

105. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

106. Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя

гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Сүүлийн 3 санал хураалт. Гишүүд санал хураалт аа, Ганболд, Цэрэнпунцаг 2 гишүүн.

43 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

107. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

108. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

44 гишүүн дэмжиж, тогтоол төсөл батлагдлаа.

Хуулийн төслүүдийг эцэслэн баталлаа. Нийт 115 хуулийн төслийг эцэслэн баталлаа. Энэ бол цахим шилжилтийн эрх зүйн орчныг бүрдүүлж, цахим гарын үсгийг баталгаажуулах зорилгоор нийтдээ 110 хуульд нэмэлт, өөрчлөлт орууллаа. Мөн Нийтийн эрүүл мэндийн тухай хуультай холбоотой 15 хуулийг дагаж баталлаа.

11.40 цаг

Баталсан тогтоолын эцсийн найруулгыг сонсгоё.

“Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

11.41 цаг

Цогтбаатар дарга аа, нөгөө тогтоол чинь албажсан шүү.

Дараагийн асуудалд орно. Ажлын хэсгийг оруулъя.

Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох саналыг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгугийн Содбаатар танилцуулна. Содбаатар даргыг индэрт урьж байна.

Я.Содбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсаас гадаад, зарим улсад суугаа Элчин сайд, байнгын төлөөлөгчдийг эгүүлэн татах, томилох саналыг тухай танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн:

1. Монгол Улсаас БНСУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сүхээгийн Сүхболдыг,

2. Монгол Улсаас БНПУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бархасын Доржийг эгүүлэн татаж, Монгол Улсаас БНПУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгальмааг,

3. Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Жанабазарыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Мөнх-Өлзийг,

4. Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч Варшаловын Энхболдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр Нямдоржийн Анхбаяр нарыг тус тус шинээр томилох саналыг зөвшилцөхөөр танилцуулж байна.

Элчин сайд, Байнгын төлөөлөгч нь Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд суугаа болон хавсран суугаа улс, олон улсын байгууллагадаа Монгол Улсыг төлөөлөн ажиллаж, ашиг сонирхол болон эрхийг нь хамгаалах, харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улсын хөгжлийн зорилтыг шийдвэрлэгдэх шаардлагатай судалгаа хийж, төр, засгийн байгууллагын мэдээллээр хангах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, 2 болон олон талын харилцааны асуудлаар яриа хэлэлцээр хийх, гэрээ хэлэлцээр байгуулах, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг олон улсын эрх зүй, суугаа орны хууль тогтоомжийн дагуу хамгаалж ажилладгаас гадна тэргүүлж буй Дипломат төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэгтэй байдаг.

Элчин сайд, Байнгын төлөөлөгчөөр томилон ажиллуулах нэр дэвшүүлж буй эдгээр албан хаагчид нь төрийн алба, дипломат албанд олон жил ажилласан, мэргэжлийн өндөр ур чадвартай, удирдах ажлын дадлага туршилагатай, гадаад хэлний мэдлэгтэй, төрийн болон дипломат албаны хууль тогтоомжийн шалгуурыг бүрэн хангасан албан хаагчид болно.

Иймд дээрх орнуудад суугаа Элчин сайд, НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийг эгүүлэн татах, шинээр томилох Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүхийн саналыг зөвшилцөн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Аюулгүй байдал гадаад бодлогын хорооны байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ТББХ-ны дарга Нямаагийн Энхболд танилцуулна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсаас БНСУ суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сүхээгийн Сүхболд, Монгол Улсаас Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгалмаа, Монгол Улсаас Шведийн Хант Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Мөнх-Өлзий, Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр Нямдоржийн Анхбаяр нарыг томилох тухай болон Монгол Улсаас БНПУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бархасын Дорж, Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Жанабазар, Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч Воршиловын Энхболд нарыг эгүүлэн татах саналыг 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр ирүүлснийг Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо 24 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг болон яамны холбогдох ажилтнууд эрхэлсэн ажлаа

амжилттай сайн гүйцэтгэж байгааг онцлон тэмдэглээд, бэлтгэгдсэн дипломат ажилтнуудыг Элчин сайдад нэр дэвшүүлсэн байна гээд шинээр томилогдох Элчин сайд нараас цаашид иж бүрэн стратегийн түншлэлийн хүрээнд Солонгос болон Европын Холбооны улс орнуудтай чөлөөт худалдааны гэрээ байгуулж ажиллах, тухайн улс оронд ажиллаж, амьдарч байгаа өөрийн оронд иргэд эрх ашгийг хамгаалах талаар ямар ажил хийхээр төлөвлөж буйг тодруулан асууж хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн нэр дэвшигч нарын боловсрол, мэдлэг, ажлын туршлага хангалттай сайн байгаа тухай, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын язгуур сонирхлыг хангахад чухал үүрэг хүлээж байгааг анхаарч ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар гадаад бодлогыг эдийн засагжуулах, худалдааны үр ашгийг нэмэгдүүлэх талаар судалгаа хийсэн эсэх, гадаад бодлогын уламжлалт шинж чанарыг хадгалж цаашид үргэлжлүүлэх, гадаад улсад амьдарч байгаа иргэдтэйгээ хүнлэг, ёс суртахуунтай харьцах талаар анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр гадаад харилцааг эдийн засагжуулах, хөрөнгө оруулалтыг татах, худалдааны бодлогоо сайжруулах, аялал жуулчлалыг нэмэгдүүлэх, эх орноо сурталчлахад шаардлагатай байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нэр дэвшигч нь мэргэжлийн дипломатч, салбартаа олон жил ажилласан, ажлын туршлага өндөртэй хүмүүс байгаад талархаад, суугаа орондоо иргэдийнхээ сонгох, сонгогдох эрхийг хангах талаар идэвх санаачилгатай, иргэдтэйгээ нягт хамтран ажиллах шаардлагатай болохыг нь дэвшигчдэд анхааруулсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан нэр дэвшигчдийг дэмжиж байгаагаа илэрхийлээд эгүүлэн татсан Элчин сайд нарыг Монгол Улсаа төлөөлөн гадаадын улс оронд ажиллах хугацаандаа хийсэн ажлын тайлан, үр дүнгээ Байнгын

хороонд тайлагнадаг байх, идэвх санаачилгатай сайн ажилласан Элчин сайд нарыг шалгаруулдаг, үнэлдэг, тодорхой шалгуур үзүүлэлттэй болгох, дээд, өндөр түвшний айлчлал, арга хэмжээний давтамжийг улам нэмэгдүүлэх, гадаад улс оронд амьдарч байгаа иргэдтэйгээ мэдээлэл солилцох, нягт уялдаатай байх талаар анхаарч ажиллах нь зүйтэй гэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Сүхээгийн Сүхболдыг Монгол Улсаас БНСУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Гунаажавын Байгалмааг Монгол Улсаас Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Цэрэндоржийн Мөнх-Өлзийг Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Нямдоржийн Анхбаярыг Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр тус тус томилох саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Түүнчлэн Монгол Улсаас БНПУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бархасын Дорж, Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Жанабазар, Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч Воршиловын Энхболд нарыг эгүүлэн татах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох саналыг зөвшилцсөн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Г.Занданиатар: Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх

Улсын Их Хурлын гишүүн байна уу? Жамбын Батсуурь гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгугийн Содбаатар, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх Эрдэнэцогтын Одбаяр, Гадаад яамны Бодлого төлөвлөлтийн газрын захирал Гүнтэвсүрэнгийн Бямбасүрэн, тус яамны Төрийн захиргаа удирдлагын газрын захирал Дашипүрэвийн Амарсайхан, Консулын газрын захирал Бат-Очирын Болд, нэр дэвшигчид Монгол Улсаас БНСУ улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сүхээгийн Сүхболд, Монгол Улсаас Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгалмаа, Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Мөнх-Өлзий, Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр Нямдоржийн Анхбаяр нар оролцож байна.

Тогтоол учраас асуулт, үг 2 нэг. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Өнөөдөр орж ирж байгаа хүмүүс яг мэргэжлийн, туршилагатай дипломатчид орж ирж байгаад үнэхээр сайшаалтай байна. Тэгээд бид нар өмнө нь бас нэр дэвшиж орж ирж байгаа хүмүүс дээр Гадаад хэргийн сайддаа бас хэлж байсан. Тийм ээ, гадаадын энэ дипломатуудын ажлыг дүгнэхдээ аль болохоор гадаад худалдаа, гадаад харилцааг эдийн засагжуулах, ялангуяа ковидын дараа энэ амаргүй геополитикийн нөхцөл байдлын үед энэ үр ашгийг нь нэмэгдүүлэх, ажлын дүгнэлтийг нь бараг жил болгон ингээд тайланг нь авч байгаад, дүгнэж байгаа гэж хэлж байсан. Одоогийн байдлаар энэ ажил ер нь хэр явж байгаа бол? Энэ дээр үнэхээр санаачилгатай, эдийн засгийн үр өгөөжтэй бас санал санаачилга авчих томоохон хөрөнгө оруулалтыг татах,

томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хамтраад хэрэгжүүлчих ийм ажлууд бол бас хэр гарч байгаа бол оо? Сүүлийн үед бол бас Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад айлчлалууд бол маш үр дүнтэй. Үнэхээр бас энэ Монгол Улсаа гадаадад нээх тал дээр сайн байгаа. Үүнийг бол хүн болгон өнөөдөр хүлээн зөвшөөрч ярьж байгаа. Харин үүний үр дүнг ажил хэрэг болгох нь өөрөө Засгийн газрын үйл ажиллагаа байдаг. Тийм учраас энэ тал дээр манай нэр дэвшиж орж ирж байгаа энэ дипломатууд маань ер нь ямар бодолтой байгаа бол оо гэдэг дээр бас би бүгдээс нь нэг товч товч хариулт авахыг хүсэж байна.

Тэгээд өмнө БНСУ-д жилийн өмнө нэг өөр Энхбат гээд хүнийг оруулж ирээд уг нь дэмжигдээд ингээд явсан. Өнөөдөр Сүхболд манайд туршилагатай. Үнэхээр сайн дипломатч маань ингээд орж ирж байгаа юм байна. Энэ бол уг нь бол их зөв. Харин яагаад ингээд өөрчлөгдөх болсон шалтгаан байгаа учрыг юу нэг бас мэдмээр байх юм. Яагаад ингэж асууж байна гэхээр сүүлийн үед энэ нөгөө БНСУ руу зорчих виз авчихсан иргэд яг Солонгосын хил дээр очоод Цагаачлалын алба нь виз чинь болохгүй байна гээд оруулахгүй гаргаад буцаагаад явуулах, энэ нь өөрөө нь иргэдийн 1 дүгээрт, хөрөнгө мөнгөөрөө 2-т, сэтгэл санааны хувьд тэгээд л олон талаараа хохирч байгаа ийм гомдлууд их ирсэн. Жишээ нь манай ЧД-ийн 4 иргэнээс залуучууд явчхаад буцаад ирье гээд энд гарахдаа мөнгөө аваад та болж байна, виз чинь гарчихсан гээд. Тэгээд нөгөө төлбөр тооцоогоо хийгээд явсан, тэгсэн чинь гаргаагүй. Тэнд 3, 4 хоног бараг л нөгөө цагаачлалын юун дээр нь хоригдож байгаад гэж бараг өөрсдөө хэлж байгаа байхгүй юу. Тэгээд буцаж ирээд үнэхээр ингээд хямарчихсан ийм байна л даа. Тэгээд ийм зүйлүүд яагаад гарах болоод байна аа? Энэ дээр цаашидаа яаж анхаарах вэ? Учир шалтгаан нь юу байгаа бол оо? Үүн дээр бас их анхаарах хэрэгтэй байна.

Тэгээд бусад нь бол та бүхэндээ амжилт хүсье. Ерөнхийдөө бүгдийг нь

дэмжиж байна. Манай Байгальмаа туршилагатай ийм дипломатч байна. Мөнх-Өлзий, Анхбаяр маань байна. Тэгээд та нартаа бас амжилт хүсье.

Г.Занданшатар: Үг хэллээ, тийм ээ. Асуулт. Батмөнхийн Батцэцэг сайд хөрөнгө оруулалтын асуудлаар 82.

Б.Батцэцэг: Сайн байцгаана уу. Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Элчин сайд нартаа бас байгуулсан гэрээний голлох заалтуудын хэрэгжилтийг бид нар бас гаргасан, 2 дахь жилдээ гаргаж байгаа. Нийт томилогдсон Элчин сайд нартай тусгайлан гэрээ байгуулж, энэ эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг сайжруулах, хөрөнгө оруулалт нэмэгдүүлэх, бизнесийн орчинд таатай нөхцөлийг бүрдүүлэх, эрх зүйн орчныг нь бүрдүүлэх чиглэлээр бол тодорхой үүрэг даалгавруудыг өгч ажиллаж байгаа. Бас үр дүнгүүд гарч байгаа. тэгээд сүүлийн 2 жил бас нэлээд олон өндөр дээд хэмжээний айлчлалууд хэрэгжүүлсэн. Айлчлал бол бас харилцааны нэг оргил нь байдаг. Айлчлалын үеэр олон сар жил, заримдаа олон жил ярьсан асуудлуудыг хүртэл тохирч, эцсийн баримт бичгийг байгуулдаг. Энэ айлчлалуудын үеэр бид нар сүүлийн 23 онд бол маш олон баримт бичгүүдийг байгуулсан. Энэ баримт бичгүүдийг байгуулахад манай Элчин сайд нар бол маш идэвхтэй ажиллаж байгаа.

Тэгээд жишээлбэл агаарын харилцаа хэлэлцээр байгуулах, шууд нислэг зохион байгуулах, авто тээврийн хэлэлцээр байгуулах, ХАА-н салбар болон Засгийн газрын мөрийн хөтөлбөр, шинэ сэргэлтийн бодлогын гэрээнд өргөжүүлж байгаа санхүүжилт босгох, хөрөнгө оруулалт татах ажлууд, аялал жуулчлалын чиглэлээр болон Монгол Улсаа гадаадад сурталчлах чиглэлээр, мөн 2 улсын яамд хоорондын хэлэлцээний механизм болон Засгийн газар хоорондын комиссуудыг идэвхтэй ажиллуулж, үр дүнг нь хэрэгжүүлэх, боловсрол, шинжлэх ухаан, сургалт энэ чиглэлийн хамтын

ажиллагаа, Монгол Улсыг сурталчлах чиглэлээр голдуу үр дүнгүүд нэлээн гарсан.

Энэ тайланг бол гаргаад бид нар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр болсон. Өчигдөр болсон Байнгын хорооны хуралдаан дээр бас энэ асуудлыг ярьсан байгаа. Тэгээд мэдээллийг бас гишүүддээ Байнгын хороондоо хүргүүлнэ.

Манай нэр дэвшигч нар тус тусдаа ярих учраас би сүүлийн 2 асуултад товчлоод хариулъя. Өмнө нь нэр дэвшиж байсан БНСУ-д Энхбат гэж хүн бол айлын талаас бол хариу өгөөгүй. Тэгээд Энхбат нэр дэвшигч маань өөрийнхөө хүсэлтээр, хувийн шалтгаанаар татгалзсан байгаа. Тийм учраас шинээр хүн нэр дэвшүүлж байгаа.

Иргэдийн Солонгост зорчиж байгаа Монгол иргэдийн визний асуудал дээр бас тодруулга өгье. Энэ нийтдээ БНСУ-д ганцхан Монгол Улс биш бусад олон орноос бас хууль бусаар оршин сууж, хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс байдаг. Нийтдээ 450 мянга орчим иргэн гадаад улс орнууд бас ажил хийж байгаа. Солонгосын Хууль зүйн яамны шийдвэрээр энэ эдгээр хууль бус иргэдийг 50 хувьд хүртэл бууруулах ийм компани ажил зохион байгуулагдах хүрээнд 2023 онд бол шалгалтыг нэлээд эрчимжүүлж, хилээр нэвтрэх иргэд дээр нэлээн эрчимжсэн ийм шалгалтууд хийгдэж байгаа. Ганцхан Монгол иргэдийг бол буцаагаагүй маш олон орны хууль бусаар оршин суудаг орнууд буюу буцаах гэж байгаа орнуудын тоонд орж байгаа улс орнуудыг бол иргэдийг нь бас манайхтай адилхан буцааж байгаа юм байна лээ.

Бид Солонгосын талтай энэ асуудлыг байнга ярьж байгаа. Асуудлыг тавьж байгаа. Аль болохоор ойлголцож, нэгэнт виз олгосон бол оруулах чиглэлээр ажиллаж байгаа. Солонгосын талаас хууль дүрэмд нийцэхгүй, зөрчил гаргасан, тодруулж хэлэх юм бол зорчиж байгаа зорилгоо тодорхой мэдэхгүй, очих байр буудлаа мэдэхгүй, буцах хугацаагаа

мэдэхгүй, тэгээд хүлээж авах урьсан хүн байхгүй гэх мэт виз мэдүүлэхдээ визний хуудсан дээр аппликэйшн дээрээ мэдээлсэн мэдээллээсээ зөрөх шалтгаанаа тайлбарлаж чадахгүй байх гэх зэрэг шалтгаанаар буцааж байгаа шүү, танай иргэдийг гэдэг ийм мэдээллийг хэлж байгаа.

Мөн Гадаад харилцааны яам бол Консулын хэлтэс, ЭСЯ бол байнга иргэдэд зориулсан мэдээлэл, сэрэмжлүүлгийг тогтмол өгч явуулж байгаа.

Л.Мөнхбаатар: Нэр дэвшигчид асуултад хариулъя. Нэмж хариулъя. Нямдоржийн Анхбаяр хариулъя. Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өгье.

Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. НҮБ-ын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр нэр дэвшиж байгаа Нямдоржийн Анхбаяр. Ерөнхийлөгч сүүлийн 3 жил дараалан НҮБ-ын Ерөнхий ассамблейн чуулганд оролцсон. Энэ үеэрээ олон талт хамтын ажиллагааны хүрээнд дэвшүүлсэн бодлогуудыг хэрэгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана гэж бодож байна. Тухайлбал “тэрбум мод” үндэсний хөдөлгөөн. Энэ төсөл хөтөлбөр, дээр нь ба бас олон талт олон арга хэмжээнүүдэд оролцож байгаа. Цөлжилттэй тэмцэх, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх зэрэг олон талт том бодлогууд дэвшүүлж байгаа. Энэ бодлогуудыг НҮБ-ын шугамаар бусад улс орнуудад таниулах, мөн гарах шийдвэрүүдэд Монгол Улсынхаа байр суурь, Монгол улсдаа хийгдэж байгаа ажлыг тусгах чиглэлээр идэвхтэй ажиллана гэж бодож байна.

Мөн энэ энхийг сахиулах ажиллагааны Монгол Улсын оролцоог сайжруулах, далайд гарцгүй хөгжиж байгаа Монгол Улсад төвтэй, Улаанбаатар хотод төвтэй судалгааны төвийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, худалдаа, тээвэр, логистикийг сайжруулах чиглэлээр, судалгааны үр өгөөжийг сайжруулах чиглэлээр НҮБ-ын удирдлагуудтай анхны уулзалтууд яриа хэлэлцээнүүдийг хийгээд явж байгаа.

Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах хүрээнд Монгол Улсад хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүд, НҮБ-ын суурин зохицуулагчийн газруудтай хамтран бас ажиллах ийм шаардлагууд байгаа. Товчхондоо хэлбэл одоо хийгдэж байгаа ажлуудыг үргэлжлүүлэн идэвхтэй ажиллана гэж хэлэх байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Сүхээгийн Сүхболд нэр дэвшигч асуултад хариулъя. Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье.

С.Сүхболд: Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. БНСУ-тай хийж байгаа нийт худалдааны эргэлт бол 23 оны байдлаар бол 565 сая орчим доллар байна. Энэ нь Монгол Улсын нийт гадаад худалдааны эзэлж байгаа нэлээн тэргүүлэх орнуудын нэг гэж тооцогдож байгаа юм байна. Тэгэхээр миний бие хэрэв томилогдох аваас энэ хөрөнгө оруулалтыг татах, ялангуяа худалдааны хувь хэмжээг нэмэгдүүлэх дээр онцгойрон анхаарна, ажиллана гэж тооцоолж байгаа. Учир нь Солонгос улстай 2016 оноос хойш чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээ явагдаж эхэлсэн. Өнгөрсөн оны 12 дугаар сараас эхлээд албан ёсны яриа хэлэлцээ явагдсан. 14 бүлэг асууд талаар хэлэлцээ хийж байгаа. Үүний нэг бүлгийг миний бие өөрөө ахлаад явж байгаа. Тийм болохоор энэ асуудлыг бас эцэслэн байгуулах чиглэл дээр үргэлжлүүлж ажиллана. Ингэснээрээ 2 талын худалдааны нөхцөлүүд бол хөнгөлөгдөх ийм бүрэн боломж бол нээгдэнэ гэж тооцоолж байгаа.

Энэ чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулахтай холбогдуулаад 2 улсын Засгийн газар хооронд хамтран чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахад хэрхэн ашигтай байх вэ гэсэн хамтарсан судалгааг хийсэн байдаг. 2021 онд. Энэ судалгааны үр дүнгээс ажиглах юм бол 4 салбарт ер нь харилцан ашигтай ажиллах бололцоо байна гэдэг дүгнэлтийг шинжээчид бол гаргаж өгсөн байдаг.

1 дүгээрт, үйлдвэрлэлийн чиглэлээр, 2 дугаарт, эрчим хүчний салбар, 3 дугаарт, мэдээлэл харилцаа холбоо технологийн салбар, 4 дүгээрт нь, аялал жуулчлалын салбараар бол хамтарч ажиллахад бол ашигтай юм байна гэдэг экспертүүдийн дүн шинжилгээ гарсан байдаг. Үүн дээр миний бие онцгойлон анхаарах нэг зүйл бол энэ үйлдвэрлэлтэй холбогдуулаад, ялангуяа энэ уурхай бүтээгдэхүүнд түшиглэсэн нэмүү өртөг шингэсэн үйлдвэрүүдийг ялангуяа байгуулбал илүү бас үр ашигтай, Солонгост энэ худалдааг хийхэд илүү үр ашигтай юм байна гэдгийг бол харж байгаа. Тийм учраас бас энэ чиглэлээр бас үргэлжлүүлэн ажиллана гэж бодож байгаа. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 86 дугаар микрофоныг өгье. Цэрэндоржийн Мөнх-Өлзий асуултад хариулъя.

Ц.Мөнх-Өлзий: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Шведийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилогдох нэр дэвшигч Цэрэндоржийн Мөнх-Өлзий гэж хүн байна. Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Монгол Улс Шведийн Хаант улсын худалдааны эргэлт бол 2022 оны эцсийн байдлаар 36 сая доллар, шууд хөрөнгө оруулалтын хэмжээ бол 10 сая доллар гэсэн ийм тоо үзүүлэлттэй байгаа. Миний бие Элчин сайдаар томилогдох аваас энэ худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлд түлхүү анхаарах шаардлагатай гэж үзэж байгаа. Ялангуяа нэг талын худалдаа буюу манайхаас Шведийн Хаант Улсад гаргаж байгаа бараа бүтээгдэхүүн их бага, айлын талаас манайд нийлүүлж байгаа бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт харьцангуй өндөр байгаа учраас энэ худалдааг дэмжих. Манайхаас гаргаж байгаа ноос, ноолууран бүтээгдэхүүний худалдааг Шведийн зах зээлд гаргах чиглэлээр түлхүү анхаарч худалдааг 1 талдаа, 2 талдаа аль болохоор тэнцвэржүүлэх, харилцан ашигтай байх чиглэлд анхаарах ажиллах ёстой юм болов уу гэсэн ийм бодолтой байна.

Мөн эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр Монголын компаниуд, ААН-үүдэд хөрөнгө оруулалт, хөгжлийн санхүүжилтийн зээл авах, хувийн хэвшлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд нь илүү анхаарах, ажиллах шаардлагатай гэж үзэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Элчин сайдад нэр дэвшигч Гунаажавын Байгальмаа асуултад хариулъя. Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье, 87 дугаар микрофоныг өгье.

Та бүхний энэ өдрийн мэндийг хүргэе. БНПУ-д Элчин сайдаар томилогдох нэр дэвшсэн Гунаажавын Байгальмаа байна. Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Монгол Польшийн хооронд өндөр дээд түвшний харилцан айлчлал ер нь идэвхтэй явагдаж ирсэн. Өнгөрсөн онд гэхэд 2023 онд БНПУ-ын Ерөнхийлөгч Дуда Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүхийн урилгаар төрийн айлчлал хийсэн байгаа. Энэ үеэр талууд 2 талын хамтын ажиллагааг эдийн засаг, худалдаа, боловсрол, шинжлэх ухаан, геологи, архив, байгаль орчин зэрэг салбарт өргөжүүлэн хөгжүүлэхээр тохирсон.

Мөн Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй Хүнсний хангамж, аюулгүй байдал, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Илгээлт 2100 хөтөлбөрийн хүрээнд Польшийн талтай хамтран ажиллахаар тохиролцсон байгаа.

Монгол Польшийн хоорондын худалдааны хувьд ярихад өнгөрсөн 3 жилийн хугацаанд 2 талын худалдаа 2 дахин нэмэгдээд 100 сая ам.долларт хүрсэн. Энэ нь юу харуулж байна вэ гэвэл цаашид 2 талын худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх боломж бидэнд байгааг харуулж байгаа. Ийм учраас хэрэв Элчин сайдаар томилогдон ажиллах бол бид хамгийн түрүүнд 2 талын худалдаа, хөрөнгө, оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажиллана.

Дуда Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр мөн 2 талын бизнес форумыг зохион байгуулсан. Уг бизнес форумын үеэр Монгол Улсын Үндэсний ХАҮТ Польшийн хөрөнгө оруулалт худалдааны агентлагтай хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулсан. Иймд 2 улсын ААН-үүдийг хооронд нь холбох чиглэлд Элчин сайдын хувиар мөн анхаарч ажиллахаар болно. Ажиллах болно. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Дараагийн гишүүн асуултаа асууя. Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт асуултаа асууя.

С.Бямбацогт: Баярлалаа. Тэгээд яах аргагүй бол сүүлийн жилүүдэд Монгол Улсын гадаад харилцаа маш идэвхтэй маш өргөн хүрээтэй өргөжиж, хөгжиж байгаа. Гадаад харилцааны яам, Монгол Улсын төрийн тэргүүн санаачилгатай ажиллаж тодорхой үр дүнгүүд гарч байгаа. Зөвхөн ингээд зам, тээврийн салбарт гэхэд маш олон гэрээ хэлцлийг хийсэн. Энд бас манай Гадаад харилцааны яамныхан байнга бас тусалж, анхаарч, дэмжиж байсанд бас талархлаа илэрхийлье.

Гадаад харилцааг эдийн засагжуулах гэж их ярьж байгаа, бид нар. Энэ бол гарцаа байхгүй бидний хийх ёстой ажил, хийгдэж байгаа. Өнгөрсөн жил гэхэд 23 онд бид нар Монгол Улсын ОХУ-ын хооронд 1949 оны УБТЗ-ын хэлэлцээрт өөрчлөлт оруулсан, Гадаад харилцааны яам маш санаачилгатай ажилласан, үр дүн гарсан. Олон жил энэ хэлэлцээрийг өөрчилж чаддаггүй байсан. УБТЗ-ын дүрмийн сан нэмэгдсэн. 200 гаруй тэрбум төгрөгийн өр төлөгдсөн, их өр тэглэгдсэн. Хүчин чадал, санхүү үзүүлэлтүүд сайжирсан. Үүний үр дүнд УБТЗ жишээ нь энэ жил түүхэндээ анх удаа 70 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байгаа. Өнгөрсөн бас Монгол Улсын Ерөнхий сайдын Хятад айлчилсан айлчлалын үеэр бид нар 1955 оны юуны авто тээврийн хэлэлцээрт Хятад улстай байгуулсан, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт

ордуулсан. Үүний үр дүнд үндсэндээ бид нар Монголын автомашинууд Хятад улсын нутаг дээр тээвэр хийх бололцоотой болсон. Гуравдагч улсууд тээвэр хийх бололцоотой болсон. Монгол автобус өнөөдөр Бээжин, Хөх хот, Тяньжин орох бололцоотой болсон. Монгол жуулчид маань жуулчид ирэх, Монгол автобусаараа. Энэ бол үндсэндээ Гадаад харилцааны яамны яамны бас хийсэн ажлын үр дүн.

20 гаруй жил хүсэн хүлээсэн ярьж байсан АНУ-тай нислэг үйлдэх open sky хэлэлцээрийг 20 жил ярьсан, 20 жил ярьсан энэ хэлэлцээрийг өнгөрсөн жил бид байгуулсан. Үүний үр дүнд үндсэндээ маш том бас эдийн засагт томоохон бас эргэлт бий болно гэж үзэж байгаа. Гэх мэтчилэн яах аргагүй гадаад харилцааг эдийн засагжуулахад Вьетнам улстай шууд нислэгтэй боллоо. Лаос улстай шууд нислэгтэй агаарын тээврийн хэлэлцээр байгууллаа. Грек улстай байгууллаа. Катар улстай агаарын тээврийн хэлэлцээр байгууллаа. Герман улстай авто тээврийн хэлэлцээр байгуулах гэж байна. Польш улстай авто тээврийн хэлэлцээр байгуулах гэж байна. Энэ бүхэнд Гадаад харилцааны яам л оролцож байсан. Энэ бүхний үр дүнд үндсэндээ Монгол Улсын манай зам, тээврийн салбарын өнгөрсөн оны өсөлт 73 хувьтай гарч байгаа. Монгол Улсын эдийн засгийн өсөлт 7 хувьтай байсан бол зам, тээврийн салбарын өсөлт бол 73 хувьтай. Ингэж үндсэндээ 2 хөршийн хооронд гуравдагч улс руу зорчигч болон ачаа тээвэрлэх энэ бололцоо боломж бий болсны үр дүнд ингэж бас Монгол Улсын эдийн засагт, зам, тээврийн салбарт бас тодорхой үр дүн гарч байгаа. Энэ бол үндсэндээ гадаад харилцааг эдийн засагжуулахад манай Гадаад харилцааны яамны маш том үүрэг оролцоо байсныг илэрхийлж байгаа.

Тэгээд энэ нэр дэвшиж байгаа, нэр дэвшиж байгаа Элчин сайдад нэр дэвшиж байгаа та бүхэн бол маш сайн ажиллаж байсан. Бид бүхэнтэй хамтарч. Анхбаяр, Сүхболд, Мөнх-Өлзий, Байгалмаа энэ мундаг бас боловсон хүчин туршилагатай

хүмүүсээ явуулчихаар ард нь бидэнд юу болно гэж жоохон санаа зовж байна. Батцэцэг сайд аа. Гарцаа байхгүй, нүдээ олсон, хүлээн зөвшөөрөгдсөн ийм хүмүүсийг бас ингээд Ерөнхийлөгч оруулж ирж байна. Гадаад харилцааны яам санал болгож оруулж ирж байна. Тэгээд ард нь бас сайн хүмүүсээ томилоод бас манай салбарын бас үйл ажиллагааг сайхан дэмжээд ажиллаарай тэгээд бид бүхэнд бас хийх ажлууд байгаа.

Тэгээд 55 оны төмөр замын хэлэлцээртээ бас өөрчлөлт оруулмаар байна. Хятад улстай бид ганцхан төмөр замаар холбогддог байсан бол 5 төмөр замаар холбогддог болмоор байна. Эрдэнэбүрэнгийн УЦС 1968 оноос хойш яригдсан энэ төслийг бас ажлыг эхлүүлэхэд, зээлийн хэлэлцээрийг бас ойрын үед байгуулмаар байна гэх мэтийн бас бид бүгдийн өмнө бас шаардлагатай бас тулгамдсан ажлууд байгаа. Энэ бүхэнд бас та бүгдийгээ бас анхаарч ажиллахыг хүсье. Тэгээд үнэхээр нүдээ олсон томилгоо хийж байна. Гарцаа байхгүй бас ийм бэлтгэгдсэн хүмүүсийг бас томилж, Монгол Улсдаа та бүхэн маань бас Монгол Улсынхаа нэрийг өндөрт өргөж, улам энэ гадаад харилцааг эдийн засагжуулах, энэ эхлүүлсэн ажлаа улам эрчтэй үргэлжлүүлэх тал дээр бас илүү үр дүн гаргана гэдэгт итгэж байна. Батцэцэг сайддаа ч гэсэн бас амжилт хүсье. Мундаг сайн ажиллаж байгаа танд бас баярлалаа. Тэгээд амжилт хүсье та бүхэндээ.

Л.Мөнхбаатар: Бямбацогт гишүүн нэр дэвшигчдийг дэмжиж үг хэллээ. Тийм ээ, асуулт байхгүй.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа асуултаа асууя.

Ш.Адьшаа: Өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад улсад суух Элчин сайдуудын асуудлыг УИХ дээр оруулж ирж байна. Монгол Улсын гадаад харилцааны боловсон хүчний бодлого сүүлийн жилүүдэд бас Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, Монголын

төрийн хэмжээнд ажиллах ийм чадвар бүхий хүмүүсийг Монгол Улсын төрийн тэргүүн, Гадаад харилцааны сайд Батцэцэг нар ингэж оруулж ирж байгаад би бас ард түмний төлөөллийн хувьд бас үүнийг нэг зөв бодлого байна л гэж хэлж байгаа. Урьд нь их алдаа дутагдал байсан. Ялангуяа Монгол Улсыг төлөөлж гадаад улсад суух элч төлөөлөгчийн асуудал дээр олон янзын хүнийг, ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүсийг томилдог, тэр нь очоод ажил хэргийн хувьд, хувь хүний хувьд, ёс зүйн хувьд олон ийм асуудал гаргаж байсныг бид бас мартаж болохгүй.

Өнөөдөр энэ НҮБ-д суух Анхбаяр, БНСУ-д суух Сүхболд, Шведэд суух Мөнх-Өлзий, Польшид суух Байгалмаа нар бол Монгол Улсын гадаад харилцааны байгууллагад олон жил ажилласан, бэлтгэгдсэн манай залуу боловсон хүчнүүд гэдэгтэй хэн ч маргахгүй. Энэ хүмүүс өнөөдөр зүрх сэтгэл гаргаж, Монгол Улсынхаа гадаад харилцаа, түүний дотор Монгол Улсын хөгжлийн асуудлын төлөө сайн ажиллах л ийм үүрэг хариуцлага байна. Надад асуух асуулт байхгүй.

Өнөөдөр Монгол Улсын тухайд 2 том гүрний дунд байдаг, геополитикийн асуудал өнөөдөр дэлхий нийтээрээ олон асуудалд орсон энэ цаг үед Монгол Улсаа төлөөлж, тухайн оронд суух энэ Элчин сайдууд бол Монгол Улсын эрх ашиг, Монголын ард түмний эрх ашиг, аялал жуулчлал, эдийн засаг түүний дотор тухайн оронд сууж байгаа, амьдардаг, ажилладаг, сурдаг иргэдийнхээ эрхийн асуудал. Түүнчлэн олон улсын хэмжээнд Монгол Улсын байр суурийн асуудал дээр маш сайн бодлоготой Үндэсний аюулгүй байдлын зөвлөлтэйгөө, ГХЯ-тайгаа ажиллаж энэ бодлогыг л бид тэргүүн зэрэгт гаргаж ирэх нь та бүгдийн сэтгэл зүрх, итгэл үнэмшил, сахилга хариуцлагаас хамаарна гэдгийг нь тэмдэглэж хэлье. Тэмдэглэж хэлье.

Одоо энэ Анхбаяр нэр дэвшигч бас НҮБ-д суух төлөөлөгчөөр сонгогдсон

байна. Би үүнийг бас бэлтгэгдсэн боловсон хүчний хувьд, ажил мэргэжлийн хувьд дэмждэг юм. Ингээд л хэвлэл мэдээллээр Нямдоржийн хүүхэд энэ тэр гээд л элдэв юм яриад байгаа. Бид өнөөдөр хэнбугай ч байсан Үндсэн хуулийнхаа тэр зарчим, хүний эрхийн хүрээнд хэний хүүхэд байсан, ямар байх нь сонин биш. Тэр хүн өнөөдөр улсынхаа төлөө мэдлэг, мэргэжлээ олоод ажиллах энэ эрхийн хүрээнд л энэ хүн ажиллаж явж байгаа гэж ойлгож байгаа.

Ингээд энд томилогдож байгаа Элчин сайдуудад амжилт хүсье. Та бүгдийн үйл ажиллагаанаас Монгол Улсын гадаад харилцааны асуудал, Монгол Улсын эрх ашгийн асуудал, аялал жуулчлалын асуудал хамаарна шүү гэдгийг л энд анхаарах ёстой. Тэгээд та бүгдэд амжилт хүсье. Асуулт байхгүй.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил асуулт асууж, үг хэлье. баярлалаа.

Ц.Мөнх-Оргил: Содбаатар дарга, Батцэцэг сайд нар зөв хүмүүсийг зөв газарт нь нэр дэвшүүлж оруулж ирж байгаа юм байна гэж би бодож байна. Ажилласан жил, нас сүүдэр, туршлага, хэл ус, эд нараараа бол яг очиж байгаа газрууддаа бол таарч байгаа юм байна. Тэгээд энэ дандаа мэргэжлийн дипломадууд байгаа юм. Тэгээд энэ дээр нэг манайхан нэг буруу ойлголт зарим газар сошиал эд нараар яваад байх шиг байгаа юм. Нэг зарим хүмүүс нь татлаа түлхээгээр, аав ээжийнхээ татлаа түлхээгээр явж байна энэ тэр гээд. Тийм юм бол энд байхгүй. Би энэ хүмүүстэй хамт ажиллаж байсан хүний хувьд бол дандаа мэргэжлийн, олон жил ажилласан, дагнасан дипломадууд гэдгийг баталгаатай хэлж чадаж байгаа юм. Анхбаяр жишээ нь Гадаад яамны Консулын хэлтсийн дарга, Гэрээ эрхийн хэлтсийн дарга, ТУЗ-ийн, Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, Төрийн нарийн бичгийн дарга гээд, Мөнх-Өлзий ч гэсэн олон жил газрын дарга, Сүхболд ч газрын дарга, Байгальмаа ч газрын дарга гээд

ингээд хийгээд явж байгаа учраас энэ дандаа мэргэжлийн хүмүүс томилогдож байна, баяртай байна.

Энэ дээр зүгээр дараагийн удаа Содоо дарга, Батцэцэг сайд нар хүмүүс оруулж ирэхдээ энэ гадаад харилцааны салбараас гадна манай нийгмийн, улс төрийн, бизнес, эдийн засгийн салбараас бас хүмүүс түлхүү оруулж ирэхийг бодоорой. Ер нь болдог бол зүгээр миний хувийн бодол шүү. Болдог бол Элчин сайд нарын корпусыг 50, 50 хувиар бүрдүүлж байвал их зүгээр юм шиг надад санагдаад байгаа юм. Өөр салбараас орсон Элчин сайд нар бас сайн ажиллаж байгаа газрууд зөндөө байна. Бөөн хэрүүл уруул болж явсан Америкт сууж байгаа Элчин сайд Батбаяр миний бодлоор бол их ажлаа их сайн хийж байна гэж би хараад байгаа юм. Би энэ өөрөө Монгол Америкийн парламентын бүлгэмийн дарга хийдэг. Тэгээд яг явж байгаа ажил төрөл юм хумнуудыг нь хараад байгаа учраас тэр хүн бол жишээ нь сайн ажиллаж байна. Москвад Энхтүвшин сайд байна. Бээжинд Бадрал генерал байна. Тэгээд тэгэхээр энэ өөр салбараас орж ирэх нь манай гадаад харилцаанд ч гэсэн, Гадаад яаманд ч гэсэн, энэ Монгол төрийн дипломат албанд ч гэсэн их хэрэгтэй юм байна лээ гэж бодоод байгаа юм. Тэгээд энэ дээр бас анхаараарай гэж хэлэх гэсэн юм.

2-т, энэ гадаад харилцааг эдийн засагжуулна гээд тэгээд манай гадаадад сууж байгаа дипломадуудад ингээд л нэг хөрөнгө оруулалт олж ир гээд л даалгавар, захиа даалгавар өгөөд байдаг. Тэгээд энэ дээр яг ний нуугүй хэлэхэд тэр дипломадуудаасаа илүү асуудал нь энэ Монголдоо байгаа юм. Монголд яг ямар бараа бүтээгдэхүүн нийлүүлэх бололцоотой байгаа юм гэдгээ мэдээллээ өгдөггүй. Дипломадууд нь ЭСЯ-дууд нь санал онол явуулахаар хариу ирдэггүй, яамдаас нь хариу ирдэггүй, ганц нэг юм холбоод хийгээд өгөхөөр манай бизнесүүд нь өөрсдөө хулхидаад алга болчихдог. Монголдоо проблем их байгаа юм.

2 дугаарт, ЭСЯ-ны чинь гол ажил бол гадаад улс төрийн харилцааны асуудал шүү дээ. Тэгээд энэ ажил чинь өөрөө их чухал ажил байхгүй юу. Зүгээр нэг айлчлал хийлгүүлээд байгаа ч гэж бодоод байж болохгүй шүү дээ. Энэ чинь өөрөө чухал тусдаа мэргэжлийн ажил байгаа байхгүй юу. Үүний хажуугаар энэ худалдааны төлөөлөгчийн газраа энэ ХАҮТ-тай хамтраад, бизнесүүдтэй хамтраад яг гол худалдааны цэгүүд дээрээ нэмж нэмж байгуулах, түүн дээрээ энэ худалдаа хөрөнгө оруулалт дээрээ анхаардаг. Тэр ажлаа хэдүүлээ бас их бодмоор юм байна гэж л надад зүгээр бодогдоод байгаа. Үүнийг Содбаатар дарга, Батцэцэг сайд нар анхаарна биз дээ.

Тэгээд бүгдэд нь амжилт хүсье. Байгалмаад манай Гадаад хэргийн яамны эмэгтэй Элчин сайд нарын залгамжийг үргэлжлүүлж байгаад ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Мөнх-Оргил гишүүн дэмжиж үг хэллээ. Одоо Өнөрболор гишүүн үг хэлье, асуулт асууя.

Д.Өнөрболор: Олон жил энэ дипломат албанд бас тогтвортой ажиллаж ирсэн, бас тууштай ажиллаж ирсэн ийм залуусыг Монгол Улсын Ерөнхийлөгч бас томилж оруулж ирж байгаа юм байна. Баяр хүргэе.

Миний хувьд бол энэ Монгол Солонгосын парламентын бүлгийн даргын хувиар энэ 2 орны хамтын ажиллагаа дээр бас санаа зовж явдаг хүний хувьд бол бас 2 хэд хэдэн санал, хэд хэдэн асуултыг бас асууя гэж бодож байна. Манай 2 орон энэ бие биеэ нөхсөн харилцан ашигтай ийм хамтын ажиллагааг улам сайн хөгжүүлэх бүрэн боломжтой гэж миний хувьд үздэг юм. Гэтэл 99 оноос хойш дээд түвшиндээ энэ харилцаа нэрийн дор хувьд л урагшлаад байдаг. Яг хачир дээрээ, газар дээрээ төдийлөн урагшлахгүй байгаа Монгол Солонгосын хамтын ажиллагаа бол. Тэгээд энэ ерөөсөө ГХЯ болон Элчин сайд нарын яг бодох ёстой гол асуудал байгаа.

Монгол иргэдийн аж байдал, тэр нөхцөл төдийлөн бас сайжрахгүй байна. 2 улсын худалдааны эргэлт өндөр түвшинд хүрэхгүй байна. Визгүй зорчих асуудал хүсэн хүлээснээр тийм ээ, энэ түвшиндээ бас хүрэхгүй байна. Иргэд хил дээрээс олноороо буцах асуудал бас нэлээн газар авч байна. Тэгэхээр энэ нэн ялангуяа энэ гишүүдийн яриад байгаа энэ 2 орны хамтын ажиллагааг эдийн засагжуулах гэж яриад байгаа асуудал маш чухал асуудал юм. Энэ дээр Элчин сайд маань яг юуг хийхийг зорьж байгаа гэдгийг тодорхой бас тайлбарлаж хэлж өгөөч гэж хүсье.

Сая 4 төрлийн нэг 3-4 төрлийн салбарт судлаачид бол судлаад энэ төрлийн энэ салбаруудад бол хамтын ажиллагаагаа өрнүүлэх нь бол зүйтэй гэж үзсэн гэж байгаа боловч хавьгүй дээр олон салбаруудад бол энэ ноу хау шинэ технологи нэвтрэх бол хамтын ажиллагаанд нэвтрэх ийм боломжууд нээлттэй байгаа. Уул уурхай, газар тариалан, эрдэс баялаг, тээвэр ложистик, энэ дэд бүтэц гээд маш их олон чиглэлээр энэ хөрөнгө оруулалтуудыг татах ийм боломжууд бол байгаа. Тэгэхээр энэ тал дээр ер нь ямар бодлогоор ажиллах вэ гэдгийг талаараа бас та нарийвчлаад тайлбарлаж хэлж өгөөч ээ гэж бас хүсье.

Манай улсын 50 гаруй мянган иргэд БНСУ-д суралцаж, амьдарч байна. Одоогоос 20 гаруй жилийн өмнө тэд суралцаж, бас энэ хөдөлмөрийн гэрээгээр ажилласан гэж бодох юм бол давхардсан тоогоор нэг ойролцоогоор 2 зуугаад мянган хүн бас энэ өнгөрсөн хугацаанд тийм ээ, энэ хөгжсөн орны шинэ технологи, аж үйлдвэрийн энэ ноу хауг суралцаад ирсэн гэж бол ойлгож болно. Тэгээд энэ олон мэргэжсэн хүмүүсийн суралцсан ноу хауг Монгол Улсын энэ хөгжил, эдийн засагт оролцоог нь хангах энэ менежментийг хийж чадаагүйд миний хувьд бол маш их харамсдаг юм. Энэ тал дээр ер нь уялдаа холбоог яаж хангаж ажиллах вэ? Бас байр суурийг нь сонсмоор байна.

Нөгөөтээгүүр энэ хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн квотын асуудлыг энэ Солонгосоос өгч байгаа Монголын квотдоо хүрэхгүй байдаг аа гээд, хүрэхгүй болохоор нь Вьетнам ч байдаг юм уу, Филиппин ч байдаг юм уу, Индонез байдаг юм уу ингээд бусад өөр улс орнууд руу энэ квотыг нь шилжүүлэх ийм асуудал гардаг юм байна лээ. Тэгэхээр үүнийг нь ингээд судлаад үзэхээр ер нь голдуу эрүүл мэндийн асуудал ч байдаг юм уу, эсвэл хэл усны асуудал л байдаг л юм байна лээ л дээ. Тэгээд энэ дээр энэ яамуудтай, энэ иргэдтэй харилцан ямар санаачилга гаргаж ажиллах вэ гэдэг тал дээр бол эхлээд ямар ч л байсан хариултуудаа авъя.

Ингээд бүгдэд нь баяр хүргэе. Амжилт хүсье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Эхлээд Батцэцэг сайд хариулах уу? Сүхээгийн Сүхболд нэр дэвшигч бас хариулъя тийм ээ, Сүхээгийн Сүхболд нэр дэвшигч хариулъя. Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье.

С.Сүхболд: Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Солонгост бол чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах хэлэлцээ яг ид шатдаа явагдаж байгаа гэдгийг би түрүүн хэлсэн. Тэгээд судлаачдын дүгнэж байгаагаар яах вэ, 4 салбарыг бол онцолсон. Гэхдээ үүнд тодруулаад хэлэх юм бол ялангуяа үйлдвэрлэлийн салбар дээр ховор металлын судалгааны төвийг байгуулахаар Монгол Солонгосын Засгийн газар хооронд тодорхой хэлцэл хийгдээд өнгөрсөн жил энэ судалгааны төвийг байгуулах хамтарсан комисс нь хуралдчихсан. Одоо судалгааны төвийг байгуулах яриа хэлцэл нь үндсэндээ дуусаад явж байгаа. Тэгэхээр энэ ховор металлын чиглэл дээр бас онцгойлон анхаарч ажиллах ийм бодолтой байгаа.

Солонгост байгаа Монгол Улсын иргэдийн хувьд бол нийтдээ өнгөрсөн оны тооцооллоор Солонгосын Хууль зүйн

яамнаас өгсөн мэдээллээр бол нэг 54394 иргэн байна гэсэн ийм тоо байгаа. Тэгэхээр хэрэв миний бие Элчин сайдаар томилогдох аваас иргэн бүрд хүрч ажиллах, тэр дотроо иргэдийн санаачилга, үүсгэл санаачилгаар бий болсон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, мөн Монгол иргэдийн хүүхдүүдийн сурч байгаа Монгол сургуулиудыг бас дэмжих чиглэлээр бол үргэлжлүүлэн ажиллана аа гэсэн ийм бодолтой байна.

Хөдөлмөрийн гэрээний квотын хувьд бол үндсэндээ 3 мянгаас 5 мянган квот руу хүргэж байгаа юм байна. Тэгэхээр энэ дээр бол мэдээж мэргэжлийн бас боловсон ажиллах хүчнийг ажиллуулах тал дээр бас анхаарч ажиллана гэж бодож байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн асуултаа асууя.

Л.Энх-Амгалан: Элчин сайдад нэр дэвшиж орж ирж байгаа Элчин сайд нарт бас ажлын өндөр амжилт хүсэн ерөөе. Бас мэргэжлийн ийм дипломатч бас орж ирж байна. Бүгдээрээ их туршилагатай ийм дипломатч очоод улс орондоо томилогдож байгаа улс орондоо улс орноо төлөөлөх ийм хүндтэй хариуцлагатай алба. Тэгээд би нэг 2 асуудлаар ярьж байгаа юм.

1 дүгээрт нь, энэ гадаадад амьдарч байгаа тэр тусмаа энэ Солонгост байгаа иргэдийн асуудал. Сая Сүхболд нэр дэвшигч хэлж байх шиг байгаа юм. Энэ 54 мянган иргэдийн асуудал гэж. Тэгээд ганцхан энэ Солонгос биш, АНУ, Чех гээд олноороо амьдардаг энэ юунууд дээр байгаа ажиллаж байгаа Элчин сайдынхаа яамдын бүтэц, зохион байгуулалтын асуудлыг Батцэцэг сайд аа, ер нь нэг эргэж харах ёстой юу гэж би ойлгоод байгаа юм. Тийм ээ, бүтэц зохион байгуулалт. Хэчнээн Элчин сайдыг бид нар томилж явуулаад тийм ээ, 100 мянган хүнтэй, 50 мянган хүнтэй газар дээр ганц Элчин сайд, ганц Консул бол хаанаа ч хүрэх үгүй шүү дээ. Тэгэхээр энэ

асуудал дээр ер нь ГХЯ нэлээн анхаарлаа хандуулах ийм цаг нь болсон гэж нэгд би бодож байгаа юм.

2 дугаар асуудал, энэ гадаадад амьдарч байгаа, суралцаж байгаа иргэдийн хүүхдүүдийн боловсролын асуудал байгаа. Энэ ТББХ, энэ Аюулгүй байдлын байнгын хороо дээр энэ энэ чиглэлээр ер нь асуудлууд яригдсан уу гэдгийг бас Энхболд даргаас бас би тодруулж асууя гэж бодож байна. ТББХ-нд. Энэ дээр нэг хариултаа өгчхөөрэй.

3-д, сая Монгол Улсын Ерөнхий сайд Солонгос улсад ажлын айлчлал хийж энэ үеэрээ Солонгост мянган эрүүл мэндийн ажилтнуудыг бэлтгэх энэ саналыг Солонгосын талд тавьсан. Үүний дагуу би оны өмнөхөн бас Солонгосын Шадар сайд бөгөөд Боловсролын сайдтай бас ажил хэргийн уулзалтууд хийж, яг эрүүл мэндийн салбарын мянган эрүүл мэндийн ажилтнууд эмч, эрүүл мэндийн ажилтнуудыг бэлтгэх асуудал дээр нэлээн ахицтай яриа хэлцлүүд хийсэн. Сүхболд нэр дэвшигч ээ. Үүнийг ажил хэрэг болгохын тулд таны анхны чинь ажил хэрэг энэ байх болов уу гэж бас бодож байна.

Өөр нэг яригдсан асуудал бол энэ Солонгост суралцаж байгаа нэг 14 мянган оюутан байгаа юм байна лээ, 14 мянган оюутан. Ер нь Солонгост байгаа суралцаж байгаа хамгийн их олон гадаад оюутны тоонд бол Монгол Улс 1-д жагсаж байна, 14800 гэсэн байх. Тэгэхээр энэ оюутнуудын сургалтын төлбөрийн асуудал байгаа. Тэгээд би энэ Боловсролын сайдтай уулзаж, ерөөсөө энэ 14800 оюутнууд дээр Солонгост сурч байгаа оюутнууд дээр энэ боловсролын зээлийн бүтээгдэхүүн шинэ бүтээгдэхүүнүүд гаргая, хамтарсан 2 талаасаа ийм хамтарсан ийм зээлийн бүтээгдэхүүнүүд гаргая гэдэг нэг яриа хэлцлүүд хийсэн байгаа. Үүнийг бас ажил хэрэг болгох ёстой. Тэгэхээр өөрсдөө ажиллаад хэдэн төгрөг олоод, тэгээд түүгээрээ сурна сурна гэдэг маш хүнд асуудал шүү дээ. Маш хүнд асуудал.

Тэгэхээр энэ чиглэлээр зөвхөн Солонгос ч гэхгүйгээр яг өөрсдөө сургалтынхаа төлбөрийг сурч сурч байгаа, олноороо сурч байгаа Япон, АНУ, Австрали, Хятад гэсэн энэ улсууд дээр бид нар бас энэ чиглэлийн зээлийн бүтээгдэхүүнүүд гаргах, энэ оюутнуудад ийн тэтгэлгүүдийг олгох чиглэл рүү, одоо явж байгаа Ерөнхийлөгчийн 2100 тэтгэлгийг өргөжүүлэхээс гадна яг өөрөө хувиараа мөнгөө төлж сурч байгаа энэ хүүхдүүд дээр бид нар бас онцгойлон анхаарах нэг ийм цаг нь болсон. Тодорхой шийдлүүд гаргах ийм цаг нь болсон л гэж би харж байгаа юм. Тэгэхээрээ энэ томилогдож байгаа Элчин сайдууд бол энэ чиглэл рүү бас онцгойлон анхаарч ажиллаарай гэдгийг бас та бүхэнд захиж хэлье гэж бодож байна. Ингээд бүгдэд нь ажлын амжилт хүсэн ерөөе.

Л.Мөнхбаатар: Энх-Амгалан гишүүн 2 асуулт асуусан. Эхний асуултад нь Батцэцэг сайд хариулах уу? Дараагийнхад нь Нямаагийн Энхболд дарга хариулъя. Ажлын хэсгийн 82.

Б.Батцэцэг: Баярлалаа. Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Солонгосын ЭСЯ-ны бүтэц, зохион байгуулалтын хувьд санал нэг байна. Тэгээд үйл ажиллагаа бол өргөжиж байгаа. Тэгээд 7 хоногт маш олон нислэгүүд, шууд нислэгүүд байгаа. Иргэдийн тоо үргэлж нэмэгдэж байгаа. Оюутны тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа. Тэгээд бүтэц, зохион байгуулалтын хувьд бол Консулын хэлтэс нь бол маш цөөхөн хүнтэй байсан. 2023 онд 2 орон тоо нэмэгдүүлсэн. Цаашидаа ер нь бол яамны үйл ажиллагааг өргөжүүлэх ийм саналтай байгаа.

Би саяхан бас ҮАБЗ-д гадаад харилцаа өргөжиж байгаатай холбоотой Гадаад харилцааны яамны бүтэц, зохион байгуулалтыг эргэж харах, төсвийг нь нэмэгдүүлэх, дипломат төлөөлөгчийн газрууд дээр дахин үнэлгээ хийж, байршлыг нь бас эргэж харах, үйл ажиллагааг нь бүхэлд нь эрчимжүүлэх ийм цогц төлөвлөгөөг бол танилцуулсан

байгаа. Тэгээд түүний хүрээнд асуудлууд ишийдэгдэх байх. Тэгээд таны хэлсэн бусад асуултууд дээр манай Элчин сайд бас үргэлжлүүлээд ажиллана.

Л.Мөнхбаатар: Энх-Амгалан гишүүний 2 дахь асуултад хариулъя. Нямаагийн Энхболд дарга хариулъя.

Н.Энхболд: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дээр нэр дэвшиж байгаа улсуудыг хэлэлцэх үед ер нь үг хэлсэн, санал хэлсэн гишүүн болгон хамгийн түрүүн ярьж байсан юм нь иргэдийн тухай асуудлын нэг гарцаа байхгүй байсан. Тэр иргэдтэйгээ ойр дотно, нягт холбоотой байх, санал хүсэлтэд нь анхааралтай хандаж байх, бололцооны хэмжээгээрээ тус дэм болж байх, мэдээж түүний дотор хүүхдийнх нь боловсрол, тэр Монгол сэтгэлгээ суулгах, орчныг нь тодорхой хэмжээнд бүрдүүлж өгөх энэ зүйлүүдийг ярьж байсан. Томилогдох гэж байгаа улсууд анхааралдаа авсан болов уу гэж бодож байна.

Жишээ нь өнөөдөр томилогдож байгаа 4 хүний хувьд 3 нь Монголчууд их олноороо төвлөрсөн Шведүүд байна. Швед сүүлийн үед маш их олон болж байгаа юм байна лээ шүү дээ. Монголчууд очиж. Польш байна. Олон жил уламжлалтай эмч нар их олон байдаг, хүүхэд иуухдууд нь гэр бүлээрээ тэнд байдаг. Солонгос бүр ойлгомжтой. Тэгэхээр энэ дээр ялангуяа тэнд сууж байгаа хүмүүс өөрсдөө бас санаачилга гаргаж, тэр хүүхдүүдээ дундаасаа зохион байгуулж байгаад сургалт зохион байгуулдаг ийм юмнууд нэлээд их хийдэг юм байна лээ. Сүүлийн үед их болж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ дээр ялангуяа манай Гадаад яам шинээр томилогдож байгаа Элчин сайд нар тус дэм болох тал дээр нь бүр онцгойлон нэг бүлэг болгож анхаармаар юм байна лээ. Тэнд олон жил болсон эцэг эхтэйгээ амьдардаг хүүхдүүд, эргээд Монголд ирээд хамгийн наад зах нь Монгол хэлээрээ чөлөөтэй зарим газар бол тийм биш байна шүү, жоохон хүүхдүүд оччихоод ирсэн хойно нөгөө

хүүхдүүд чинь хэлэндээ хүртэл муу байх ийм зүйлүүд байна. Тэгэхээр үүнийг их анхаараарай гэдгийг манай гишүүд ярьж байсан.

Дээр нь энэ жил болох сонгуулийн ажлыг бас тэр бол өөрсдөө иргэдийгээ энэ ажилд яаж идэвхтэй оролцуулах вэ, яаж би Монгол Улсын иргэн шүү төрийн эрх барих үйл хэрэгтээ эрхээ эдэлж оролцож байгаа вэ гэдгийг нь мэдрүүлж аль болохоор олон хүнийг сайн зохион байгуулж оролцуулах тал дээр анхаараарай гэдгийг хэлж байсан гэдгээ хэлье.

Нэр дэвшигчдийн хувьд бол бүгдийг нь дэмжиж байна. Би түрүүн Мөнх-Оргил гишүүний хэлсэнтэй бол бүрэн дүүрэн санал нэг байна. Энэ 4 хүн бол чинь заримыг нь би ажилд авч байсан, зарим нь надтай хамт ажиллаж байсан, заримыг нь би түрүүнд нь өөр янз бүрийн албан тушаалд томилж гадаадад явуулж байсан ийм хүмүүс байгаа. Бүгд бэлтгэгдсэн, аль ч талаас нь бодсон энэ Элчин сайдын ажлыг бүрэн биелүүлэх боломжтой улсууд гэж бодож байгаа. Насны хувьд 45-53 орчим насны хүмүүс байна. Ид л урьд нь сурсан, мэдсэн зүйл, туршилагаа ингээд эх орноо төлөөлж ажиллахдаа бүрэн дүүрэн ашиглаад, амжилттай хэрэгжүүлж чадах хүмүүс гэж бодож байгаа. Бүгдийг нь дэмжиж байна. Бүгдэд нь амжилт хүсье, та бүхэндээ. Итгэж байгаа. Чадна аа, бүгдээрээ. Ерөнхийлөгч, Гадаад яам, бас энэ удаа дандаа мэргэжлийн дипломатуудаа ингэж оруулж ирсэн байна. Амжилт хүсье, бүгдэд нь.

Л.Мөнхбаатар: Энх-Амгалан сайд бас чухал асуудлыг хөндөөд ярьж байгаа юм. Хилийн чанадад амьдарч байгаа иргэдийн хүүхдүүд бас эх хэлээрээ соёлоо суралцах энэ боломжуудыг бүрдүүлэх чиглэлээр бас Монголын төр анхаарах ёстой. Боловсролын яам, Гадаад хэргийн яам бас тодорхой анхаараад явж байгаа. Шведэд бол ингэдэг юм байна лээ шүү дээ. Тийм ээ, 5-аас дээш хүүхэд нэг ангид байх юм бол заавал Монгол багшаар

хичээл заалгадаг, хэлээр нь оруулдаг тийм зүйл байдаг юм байна лээ. Тэр бол бас бусад улс орнуудад ч гэсэн та бүгд бас яриад, зохион байгуулаад явах ийм боломжууд бас байх юм байна лээ шүү гэдгийг бас хэлье гэж бодож байна.

Одоо Балжиннямын Баярсайхан Байнгын хороон дарга асуултаа асууя.

Б.Баярсайхан: Баярлалаа. Өнөөдөр орж ирж байгаа нэр дэвшигч нар маань бүгдээрээ олон жил Гадаад харилцааны яаманд ажилласан, мерит зарчмаар орж ирж байгаа, мэргэжлийн дипломауд байгаад талархаж байна. Батцэцэг сайдад талархаж байна. Ер нь бол энэ өнгөрсөн өнгөрч байгаа энэ 4 жилийн ажилд Гадаад харилцааны яам салбарын сайд Батцэцэг, Төрийн нарийн бичгийн дарга Анхбаяр болон яам бол ер нь бол бусад яамнуудаа нэлээн манлайлсан ийм ажлыг улс орны хэмжээнд хийж гүйцэтгэж яваа ийм яам гэж бас ингэж дүгнэхэд хилсдэхгүй болов уу гэж ингэж бодож байна.

Мэдээж би бүх нэр дэвшигч нартаа өөрийн тухайн улсад амьдарч байгаа Монгол иргэддээ үзүүлж байгаа үйлчилгээгээ онцгой анхаарч, Монголчуудаа бас хайрлаж, тэдэнд онцгой анхаараарай гэдэг зүйлийг хэлье. Мөн сая дурдаж байна. Гадаадад төрж өсөж байгаа Монгол хүүхдүүдийн хэл, соёлын асуудал маш их санаа зовоож байгаа. Тийм учраас Монгол сургуулиудыг тухайн улс орондоо байгуулах, энэ чиглэлээр Боловсролын яам, мөн энэ БСШУСБХ-той хамтран ажиллах энэ бол нээлттэй байна. Би бол энэ ажлыг бол маш сайн дэмжинэ шүү гэдгийг бас хэлье.

Солонгос улсад Элчин сайд томилогдож байгаад бол маш маш их баяртай байна. Сая Мөнх-Оргил сайд бас хэлж байна. Хөрөнгө оруулалтын тал дээр ажиллах гэхээр тухайн яамнууд нь өөрсдөө бас хойрго байдаг аа гээд. Энэ дээр та нар маань нэгэнт энэ салбар хоорондын уялдаа холбоо, яам хоорондын уялдаа холбоогоо хангаад, ганцхан аялал

жуулчлал төдийгүй хөрөнгө оруулалт дээр нэлээн онцгой анхаарч ажиллаач. Ялангуяа энэ Солонгос улсад хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулагч нар, газрын ховор элементүүдийг хамтран ашиглах, Монгол инженерүүдээ сургах, оюутан солилцоо зэрэг бид нарт хийвэл маш их ажил байна. Энэ дээр Энхболд сайд таныг томилогдвол, Сүхболд сайд таныг онцгой анхаарч ажиллаасай гэж хүсэж байна.

НҮБ-ын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр Анхбаяр дарга томилогдож байгаад бол би маш баяртай байна, дэмжиж байна. Монгол Улсаа төлөөлөн суух НҮБ-ын төлөөлөгч бол маш хариуцлагатай ажил. Товчхондоо Монгол Улсыг гадаадын бусад улс орнуудтай олон талын хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улсыг энх тайвныг эрхэмлэсэн статусыг олон улсад таниулах ийм үүрэгтэй. Үүний хажуугаар Мянганы хөгжлийн зорилтуудын шалгуур үзүүлэлтийг хангахад анхаарлаа хандуулах, үүнд дурдагдсан жендерийн тэгш байдал, хүүхэд, эмэгтэйчүүдийн боловсрол, хүчирхийллийн эсрэг, хүүхдийн боловсрол, ядуурлын бууруулах чиглэлээр Анхбаяр дарга таныг идэвх санаачилгатай ажиллана гэж бодож байна. Хэрвээ та томилогдох юм бол таны томилолтын хугацаанд буюу 2026 онд Монгол Улс НҮБ-ын бүрэн эрхт гишүүнээр элссэний 65 жилийн ой тохиох гэж байна. Сая 23 онд Батцэцэг сайдын Гадаад харилцааны сайд эмэгтэй сайд нартай уулзсан уулзалт, мөн Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн НҮБ-ын Ерөнхий ассамблейд хэлсэн үг бол бусад улс орнуудын анхаарлыг татсан маш чухал үг хэлж, дээрээс нь энэ 24 онд дэлхийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулна гэж зарласан байгаа. Тийм учраас энэхүү ажлуудыг нэлээн өндөр түвшинд сайн гүйцэтгэнэ ээ гэж ингэж итгэж байна.

Ингээд 22 онд Дэлхийн банкны тооцооллоор гадаадад байгаа

Монголчуудын эх орондоо оруулж ирж байгаа мөнгө 500 сая буюу бараг хагас тэрбум долларын мөнгийг эх орондоо оруулж ирж байгаа гэсэн ийм тооцоо байгаа. Тэгээд ерөнхийдөө бидний эрхэм үүрэг бол гадаадад байгаа Монголчууддаа эх орныг нь төлөөлөн эцгийн хайраар, Элчин сайдын ёсоор хайрлаж, халамжилж, тэднийг онцгой анхаарч ажиллах гэдэг энэ эрхэм үүргээ бас та нар маань биелүүлээрэй. Надад бол асуулт байхгүй. Та нарынхаа ажилд амжилт хүсье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Баярсайхан гишүүн дэмжиж, үг хэллээ.

Одоо Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхийлөгчийн тухай хуульд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд Монгол Улсаас гадаад улсад суух төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөж томилно гэсэн ийм заалттай байгаа. Тэгээд энэ заалтынхаа дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчөөс дипломат ажилтнуудыг өнөөдөр 4 газар томилохоор оруулж ирж байна. Миний хувьд үнэхээр таатай байна. Оруулж ирж байгаа дипломат ажилтнуудын хувьд олон жил ажилласан, энэ чиглэлээрээ ажилласан, мэргэшсэн, ийм мэргэжлийн өндөр түвшинд ажиллаж байсан ийм хүмүүсийг оруулж ирж байна. Тийм болохоор Содбаатар дарга, Батцэцэг сайдад бас талархал илэрхийлье. Ер нь цааш цаашидаа ийм нэг зарчим бариад яг мэргэжлийн үүднээс томилдог ийм зарчим руугаа орох нь зүйтэй байх гэж бодож байгаа.

Ер нь гадаадад суух төлөөлөгчийн газрыг томилох, тэнд ажиллаж байгаа хүмүүсийг бид нар шилж сонгоно гэдэг маань Монгол Улсын нүүр царай шүү дээ. Нүүр царай. Тэнд байгаа бүхий л харилцаа, эдийн засгийн болон улс төрийн бүхий л дипломат харилцааны хүрээнд ажилладаг. Монгол хүнээ, Монгол Улсаа

төлөөлж байгаа ийм өндөр харууцлагатай. Тийм болохоор тэнд бид нар ямар нэгэн фактгүйгээр, ямар нэгэн алдаа дутагдалгүйгээр, боловсон хүчнээ зөв томилох нь маш зүйтэй байгаад байгаа юм.

Солонгос улсын хувьд бид сүүлийн хэд хэдэн томилгоонуудыг нэлээн алдсан байх. Буруу томилгоонууд явсан байх. Цаад талаасаа бас зарим нь сая Батцэцэг сайд хэллээ. Цаад талаасаа бас зөвшөөрөл нь ирээгүй эд нар гэсэн. Энэ чинь юу гэж байна гэхээр бас л 2 улсын хоорондын харилцаанд нэг л тийм таагүй байна л гэсэн үг шүү дээ, энэ чинь. Ирж байгаа төлөөлөгч нь бас сэтгэлд таалахгүй байна л гэдэг ч юм уу, нэг тийм байдал л үзүүлж байна л гэсэн үг байхгүй юу даа. Тийм болохоор ерөөсөө зөв хүнээ л томилох асуудал болчхоод байгаа юм.

2 дугаарт, сая Мөнх-Оргил гишүүн маань хэллээ. Бас их туршлагатай гишүүний хувьд хэллээ. Яг мэргэжлийн дипломатчийнхаа үүднээс би бас ийм үг гарахгүй болов уу гэж бодож байсан. Эдийн засагжуулах гэдэг асуудал дээр ер нь эдийн засгийн тийм 50, 50 хувьтайгаар мэргэшсэн бас эдийн засаг тал руугаа орсон ийм хүмүүсийг томилох нь зүйтэй юм болов уу гэсэн ийм чиглэлийг хэлж байх шиг байна. Тэгэхээр миний хэлэх гээд байгаа ер нь томилгоо болгон дээр л миний асуух гээд л байдаг хэлдэг зүйлүүд бол энэ шүү дээ. Ерөөсөө эдийн засгийн энэ харилцааг нэлээн өргөжүүлэх тал дээр нь л анхаарах хэрэгтэй байх л гэж хараад байгаа юм. Ганц нэгэн дипломат байгууллагын төлөөлөгчийн газарт очоод ингээд л уулзаад ярьж байхад тухайн улсынхаа эдийн засаг болоод Монгол Улстай харилцааны энэ эдийн засгийн харилцаатай холбоотой асуудал дээр. Тэр тусмаа миний сүүлийн үед их анхаараад байдаг хөдөө аж ахуйн асуудал дээр ерөөсөө мэдлэг мэдээлэл ерөөсөө багатай харагдаад байгаа. Тэгэхээр энэ дээр ер нь Батцэцэг сайд цааш цаашидаа ер нь ямаршуу бодлого барьж болох бололцоотой байна? Цаашаагаа ер нь юу бодож байна, төлөвлөж ажиллаж

байгаа вэ? Ер нь гадаад харилцааны хувьд сүүлийн хэдэн жил бол бид маш сайн ажиллаж байгаа. Таны засаглаж байгаа, таны сайд хийж байх явцад бас нэлээн өргөн хэмжээнд харилцаагаа өргөжүүлсэн, сайн хэмжээнд өндөр хэмжээнд ажиллаж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгэхээр ерөөсөө миний асуух гээд байгаа зүйл бол цаашидаа эдийн засагжуулах гэдэг гишүүдийн асууж байгаа энэ хүрээнд ер нь яаж шүү ажиллах вэ гэж.

2 дугаарт бол энэ Солонгосын хувьд бас Сүхболд дипломат маань нэлээн өндөр түвшинд ажилласан, турилагатай ийм дипломатч орж ирж байна. Солонгос дээр бид нар нэлээн анхаарал хандуулах хэрэгтэй байх, маш өндөр түвшинд ажиллах хэрэгтэй. Маш харилцаа холбоог сайжруулах хэрэгтэй. Миний хувьд бол урьд өмнө нь нэг Солонгост айлчилж байхад Солонгосын Ерөнхийлөгч нь тэгж байсан. 2 улсын хоорондын харилцаан дээр энэ энэ энэ энэ компаниудыг та нар хамтарч ажиллах боломж бололцоог нь олгож өгөөч гэж. Үүнийг би тухайн үед нь харж байхдаа яасан лоббичин Ерөнхийлөгч вэ гэсэн шиг юм тэр бүр анх удаа анх харж байсан. Гэтэл энэ чинь тийм лоббичинтой биш. Ер нь 2 улсын хоорондын харилцааг өргөжүүлэхэд ААН-үүдийн хооронд харилцааг л өргөжүүлнэ гэсэн үг шүү дээ. Тийм болохоор иргэд, аж ахуйн нэгжийн хоорондын харилцааг улам өргөжүүлэхэд юу анхаарах талаас бас Сүхболд энэ тал дээр бодож байгаа зүйлээ хэлье.

Л.Мөнхбаатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Юу хариулт өгөх үү? Батцэцэг сайд Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 82 дугаар микрофон өгье.

Б.Батцэцэг: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Гадаад харилцааг эдийн засагжуулах асуудлыг бас Улсын Их Хурлын гишүүд бараг бүгд ярьдаг. Тэгээд миний ойлгож байгаагаар

эдийн засагжуулах, гадаад бодлогыг эдийн засагжуулна гэдэг нь өөрөө илүү прагматик гадаад бодлого явуулна л гэж ойлгож байгаа. Тэгээд гадаад бодлогыг илүү прагматик байлгах энэ хандлага ганцхан манайд биш ер нь хөгжиж байгаа улс орон болгон бас ийм бодлого шийдвэр гаргаад бас гадаад харилцааныхаа, гадаад бодлогынхоо асуудалд бас ихээхэн анхаарч, сүүлийн жилүүдэд бүх улс орны Гадаад харилцааны яамнууд нэлээн идэвхжиж, бас гадаад харилцааныхаа салбарт нэлээд их хөрөнгө оруулалтуудыг хийж, хүний нөөцөө чадавхжуулах, бэлдэх чиглэлээр ажиллаж байна. Тэгээд манай Гадаад харилцааны яамны бодлогын хувьд ч бас их илүү прагматик гадаад бодлого явуулъя. Үүний тулд 1 дүгээрт, гаднын улс орнууд дипломат харилцаа тогтоосон бүх улс оронтойгоо бид нар дипломат харилцаа нэг улстай үлдчихсэн байсан. Тэрийгээ энэ 23 онд тогтоож ингээд бүрэн бүх гишүүн улсуудтай дипломат харилцаатай болсон. Энэ улсуудтайгаа бид нар илүү гадаад худалдаа хийх, баялаг бүтээгчидтэйгээ илүү боломж нөхцөлийг нь олгох, энэ эрх зүйн орчныг нь бүрдүүлэх чиглэлд анхаарч байгаа. Олон оронтой худалдааны чиглэлийн болон визийн хөнгөлөлт, агаарын болон авто зам, тээврийн энэ хэлэлцээрүүдийг олноор нь байгуулж байна.

Худалдааны дотоодын байгууллагуудын уялдаа бас маш чухал байгаа. Тэгээд ганцхан Гадаад харилцааны яам гадаад харилцааг улс төрийн итгэлцлийг бий болгох чиглэлээр ажиллаад байхгүй. Бүх яамнууд бас уялдаагаа сайн хангаж, Гадаад харилцааны яамтай яг маш сайн хамтарч ажиллах ёстой. Ялангуяа энэ аж ахуйн яамнууд гадаад улс орнуудад гаргах бараа бүтээгдэхүүн, төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар хийж хэрэгжүүлж байгаа бодлого болон мэдээлэл, бид юу чадаж мэдэхээ бас сайн мэдээллээр хангаж байх ёстой. Өөрөөр хэлбэл бусад яамнууд ч гэсэн гадаад харилцаагаа адилхан хөгжүүлж байж гадаад харилцаагаа бас дэмжих ийм үндэс нь бүрдэх юм.

Бид нар Элчин сайд нарт ер нь сүүлийн 3 жил томилогдсон бүх Элчин сайд нарт адилхан шаардлагуудыг тавьж байгаа. Мэдээж энэ гадаад бодлогоо эдийн засагжуулах чиглэл дээр өөрсдийнхөө хөрвөх чадварыг сайжруулах, дипломатуудын ур чадвар, эдийн засгийн мэдлэг, боловсролыг нэмэгдүүлэх, баялаг бүтээгчдийг аль болохоор дэмжиж ажиллах, иргэдийн асуудал дээр онцгойлон анхаарах ийм шаардлагуудыг тавьж байгаа.

Мөн бид нар энэ ЭСЯ-ууд бол маш бага бүрэлдэхүүнээр ажилладаг. Монгол Улс нийтдээ 300 хүрэхгүй дипломат байдаг. Тэгээд техник ажилтнуудтайгаа нийлээд 500 хүн л энэ салбарт ажиллаж байгаа. Төвдөө 150 хүн ажиллаж байгаа. Энд цаашидаа бол бид нар өргөжүүлэх ийм зайлиггүй шаардлагатай. Том ЭСЯ-ууд дээр нэг 10 орчим дипломат ажиллаж байна, жижгүүд дээр нь ганцхан дипломат, 2 дипломат ажиллаж байгаа. Тэгэхээр бид нар энэ ЭСЯ-ны дэргэд Консулын хэлтсүүдийг иргэд олонтой газар нэмж байгуулж байгаа. Цаашидаа бид нар Худалдааны төлөөлөгчийн газруудыг худалдаа илүү хийх боломжтой улс орнуудад байгуулах ийм төлөвлөлт гаргаад ажиллаж байгаа.

Л.Мөнхбаатар: Нэр дэвшигч Сүхболд асуултад хариулъя. Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье.

С.Сүхболд: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын хувьд бол мэдээж хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, ялангуяа хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнүүд бол экспортод гарах нь бол чухал байгаа. Мэдээж ААН-үүдийн үйл ажиллагааг хууль ёсны хүрээнд дэмжих нь Элчин сайдын бас тэргүүн үүргүүдийн нэг гэж ойлгож яваа. Өнгөрсөн жил эхэлсэн Солонгост эцэслэхээр ажиллаж байгаа чөлөөт худалдааны хэлэлцээр дотор энэ хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнүүдийг аливаа тарифгүй, хөнгөлөлттэй оруулах асуудлыг өнгөрсөн 12 дугаар сард болсон ажлын хэсгийн

хуралдаан дээр энэ асуудлыг бол ярьсан. Тэгэхээр энэ эрх зүйн орчныг нь бүрдүүлж байж, ААН-үүд бас тодорхой бизнесийн үйл ажиллагаа явуулах боломж нь бол нээгдэнэ гэж ойлгож байгаа учраас 2 улсын хооронд байгуулах энэ гэрээ хэлэлцээр дээр ялангуяа энэ хөдөө аж ахуйн чиглэлийн бүтээгдэхүүнүүдийг экспортлох ийм боломжийг нээх тал дээр бол түлхүү ажиллана аа гэж ойлгож байгаа.

Солонгос улсад авсан мэдээллээр бол ХАҮТ-ын төлөөлөл байдаг гэж ойлгосон. Тэгэхээр энэ Монголын ХАҮТ-ын төлөөлөлтэй бас хамтран ажиллаж, бизнесийн үйл ажиллагааг дэмжихэд нь бол бас түлхүү ажиллана гэж бодож байгаа. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгээд та бүхэндээ амжилт хүсье. Ямар ч л байсан мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн ийм дипломатчид маань томилогдохоор зөвшилцөөд байж байна. Ямар ч л байсан амжилт хүсье, сайн ажиллах байх гэж бодож байна. Би сая Батцэцэг сайдаас яагаад асуусан юм гэхээр зөвхөн бид нөгөө томилогдож байгаа хүмүүстээ л захиас захиад байдаг байхгүй юу. Тэгэхээр тэрнээс гадна хамгийн гол нь дээд удирдлага, сайд нараас тийм үү, яамны бүтэц чинь өөрөө та бас сая хариулах шиг боллоо. Ер нь бол эдийн засаг зохицуулах талаас бид нар яамны бодлого дотор орчихсон явж байна гээд. Энэ чинь чухал болчихоод байна гэж үүнийг л сонирхоод байгаа юм.

Тэгэхээр та бүхэн жишээ нь өөрөө сайд хүн яг энэ чиглэлээрээ өөрөө бас нэлээн эдийн засагжуулах тал руу нь өөрөө орж байж, тэгээд эд нартаа үүрэг даалгавар өгч, буцаад эргэх холбох харилцаатай байдаг юм уу, тэр мэдэхгүй, ажил үүрэг юмаа дүгнэх төлөвлөх, эд нартай бүх юм руу нь суулгадаг ч юм уу тийм ээ. Ингэж байж бүтэн цогц болох

ёстой байх. Тэр утгаар нь асуусан байна шүү. Тэгээд амжилт хүсье, та бүгдэд.

Л.Мөнхбаатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Би тэгэхээр гадаад бодлого дээр бол Монголчууд ер нь бол нэг нүүртэй, нэг бодлоготой, нэг яриа хэлтэй явах ёстой гэж үздэг хүний нэг. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгч асан Элбэгдоржийн үед гадаад бодлого бол нэлээн өндөр түвшинд явж байгаад унаад, буцаад Хүрэлсүх Ерөнхийлөгчийн үед илүү сайн түвшинд гарч байгаа гэдгийг бас цохон тэмдэглэе. Тэгээд энэ дээр бол ялангуяа Гадаад хэргийн сайд Батцэцэг, Монгол Улсын гадаад бодлогыг үндсэндээ харууцдаг Монгол Улсын Ерөнхийлөгч нарын хамтын ажиллагаа бас маш сайн түвшинд хүргэж байгаа шүү гэдгийг хэлэх нь зүйтэй.

Тэгэхээр ер нь бол яах вэ, энэ яг өөрийн бие дээр ингээд харахад бол харилцан айлчлал дээр бол маш тийм бодлоготой, зөв ийм сонголтуудыг бас хийж байгаад бас баярлаж байгаа. Яагаад гэвэл 2 том нам бол энэ Монгол Улсын гадаад бодлогыг хамтран авч, ээлжлэн төрийн тэргүүнүүдээрээ дамжуулан бас Гадаад хэргийн яам, Засгийн газраараа дамжуулан хэрэгжүүлж явсан. Тэгээд энэ дээр бол жишээ нь БНХАУ-д Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлал хийхэд бол жишээ нь яг тэр бүрэлдэхүүнд сөрөг хүчнээсээ намайг оруулж байх жишээтэй. Яагаад гэвэл миний бие энэ 2 хөрш рүүгээ тухайн орны царигаар төмөр зам барих тогтоолын төслийг өргөн барьсан. Энэ чинь өөрөөр хэлбэл энэ тухай тухайн оронтойгоо л эвтэй, найртай байя, хамтран ажиллая гэдэг ийм л бодлогын үр дүн гэнэ. Тэгээд тийм учраас энэ ажил айлчлалын бүрэлдэхүүнд орж байх жишээтэй.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Францын ажилд орсон. Би бол ураны экспортыг, ураны олборлолтыг бол тууштай дэмждэг хүн. Тийм учраас энэ

бүрэлдэхүүнд орж байна. Жишээ нь Монгол Улсын Ерөнхий сайдын АНУ-ын айлчлалд бас орсон. Түүн дээр бол Монгол Улсын Ерөнхий сайд бол манай энэ Пүрэвдорж бол манай Засгийн газрыг хамгийн их шүүмжилдэг ийм сөрөг хүчний лидер байгаа юм гэж хэлээд явсан. Тэгэхээр энэ ардчиллын оронд манай Монгол Улс ардчилалтай юм гэдгийг харуулах нь хамгийн чухал. Ийм л зүйлүүд байгаа тэгээд. Тийм учраас энэ гадаад бодлого дээр бас зөв зөв шийдвэрүүдийг гаргаад явж байгаад их талархаж байгаа.

Дээрээс нь би явж байгаа хүмүүсийг нэлээн сайн шүүмжилдэг. Энэ шүүмжлэл бол ташуур юм. Тэр ташуурын үр дүнд бол жишээ нь би АНУ-д Батбаярыг явахад нь бол мэргэжлийн бус хүн гэж би шүүмжилж байсан. Гэтэл үнэхээр сүүлийн үеийн, Америк Монголын гадаад харилцаа бол ялангуяа өндөр түвшинд бол маш тийм сайн болсон байна лээ. Тийм учраас АНУ-д сууж байгаа Батбаярт бас ажлаа сайн хийж байгаад чинь баяр хүргэе гэж бас би хэлмээр байна.

Тийм учраас дараа дараагийнхаа олон олон мэргэжлийн хүмүүс гадаадад Монголыг төлөөлж явж байгаа нь бол маш чухал байна. Энэ нь харилцаанд маш тийм сайн эерэг үр дүн, сайн бодлогыг авчирна гэж би үзэж байгаа. Энэ хүрээндээ хамгийн гол нь Монголдоо хэрэгтэй хөрөнгө оруулалтуудыг татах, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар ажиллах, ялангуяа тухайн орондоо байгаа Монголын иргэдээ хамгийн сайн хамгаалах л хамгийн чухал үүрэг байгаа. Тэр үүрэг дээрээ илүү сайн ажиллаарай гэж та бүхэндээ хүсье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Ер нь бол манай гадаад харьцаа бол бас их дээшилсэн, сайн түвшинд байгаа. Хэзээ байтлаа Монгол Улсын Ерөнхийлөгч Английн хаан ширээнд залах ёслолд уригдаад л ингэдэг байлаа.

Хэзээ байтлаа тэр Францын Елисейн талбай дээр хүндэт харуултай ингээж төрийн айлчлал хийдэг байлаа. Энэ нөхцөл байдлууд их амжилттай сайн байгаа.

Бас нөгөө талаар энэ Ерөнхийлөгчийн айлчлалд би бол нэлээн удаан энэ Улсын Их Хуралд АН-ыг төлөөлж ажиллаж байгаа, бараг л энэ Улсын Их Хуралд ардчиллын бэлгэ тэмдэг гэж хэлж болохуйцаар ийм хүн. Гэтэл яагаад намайг Ерөнхийлөгчийн айлчлалд нэг ч байлгахгүй байна. Тэр ямар нэгэн шалтаг шалтгаан байна уу? Тэрийг нэг асуучихъя.

Нөгөө талаар энэ дипломатуудын хувьд бол би бол зөв сонголт, сайн сонголт гэж хэлмээр байна. Гэхдээ бас нэг хэдэн зүйлийг анхааруулмаар байгаа. Манай Монгол Улс маань нөгөө 3 тасарсан ч гүрний дайтай, нөгөө могой 3 тасарсан ч гүрвэлийн дайтай гэдэг шиг тийм ээ, ийм л улс орон. Бид нарын гадаад харилцаа бол маш том дэлхийн түвшинд байх ёстой. Тэр рүүгээ бол ойртож очиж байна. Өшөө сайн ажиллах ёстой гэж ойлгож байна.

Энэ дипломатуудыг томилж байгаа Монгол Улсыг Элчин сайдыг төлөөлж ажиллаж байгаа энэ хүмүүсийн дунд маань нэг дутагдал бий. Үүнийг би ГЯЯ-нд бас анхааруулмаар байна. Энэ тал дээр яаж ажиллах вэ гэдэг талаар. Урьд нь бол бид бүхэн бол Элчин сайдуудаа бэлдэх, ингэхдээ бол сургууль соёлд явуулахын өмнө бол 1 жил цэргийн алба хаалгадаг байлаа, ард түмнийхээ дунд оруулдаг байлаа. Одоо бол бас жоохон тасраад байна. Тэгэхээр ард түмнийхээ амьдралыг мэддэг, ялангуяа тэр Самбуу гуай шиг ийм дипломат ажилчдыг бэлдэхгүй бол бас өндөр боловсролтой байж болно, хэлтэй устай байж болно. Нөгөө иргэдийнхээ амьдралыг бас ойлгодог байх ёстой. Энэ талаар яаж анхаарч ажиллах гээд байна гэдэг талаар бас тодруулмаар байгаа юм.

Нөгөө талаар бол манай иргэд энэ сүүлийн 30 жилд ардчиллын ач буянаар

бол мэдээж хэрэг Монгол Улс өнөөдөр бол энэ орчиндоо Зүүн Хойд Азидаа бол хамгийн ядуу улсын нэг л болчихоод байна шүү дээ. Энэ МАН 8 жил ингээд засаглаад, 1 нам олонх болоод ингээд явчихаар бол бид нар чинь нэг өнөөдөр нэг хүнд ноогдох нь нэг 4, 5 мянган доллар. Манай 2 хөрш гэхэд л 12, 3 мянга. Нөгөө саяхны Станууд болохоор Казакстан энэ тэр чинь бас 10 хэдэн мянган доллар болчихоод байгаа байхгүй юу. 3, 4 дахин ядуу. Тэгэхээр юу хэлэх гээд байна вэ гэхээр иргэд маань гадаадад ажиллаж амьдраад ялангуяа тэр АНУ, Япон, өшөө Солонгос ингээд өндөр хөгжилтэй, өндөр орлоготой улс оронд ажиллаад ингээд 2 дахь, 3 дахь үед нь гараад ирсэн байна. Би бол бодоод байгаа юм. Энэ хүмүүс маань Монгол аав, ээжтэй. Тэгсэн мөртөө иргэнийлээ бол гадаадын иргэнийл сонгоод байна. Бид ээж, аав нь Монгол ийм хүмүүсийг давхар иргэнийл 50 мянган доллароос дээш байдаг юм уу, тухайн улс орны, ийм ардчилсан улс оронд иргэдэд бас давхар иргэнийл өгөх бололцоотой юу? Энэ талаар хэн ч ярихгүй байна. Тэгэхгүй бол энэ талаар бодож боловсруулж байгаа, энэ талаар ажиллаж байгаа ийм хэтийн бодлого байна уу, байхгүй юу гэсэн ийм асуултууд байна. Тийм, ерөнхийд нь ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ганбат гишүүний асуултад хариулъя. Батцэцэг сайд хариулах уу? Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгье.

Б.Батцэцэг: Баярлалаа. Ганбат гишүүний асуултад хариулъя. Тэгээд айлчлалын бүрэлдэхүүнд Их Хурлын гишүүдийг бас ямар журмаар оруулдаг вэ гэж асуулаа. ГХЯ тухайн улсдаа айлчлал авах гэж байгаа улстай хүнийхээ тоог тохирдог. Хүнийхээ тоонд багтаагаад улс төрийн намуудын төлөөллийг оролцуулдаг. Мөн тухайн улстай байгуулсан парламент хоорондын найрамдлын бүлгийн гишүүдийг түлхүү оруулдаг. Өөрсдийнх нь бас саналыг харгалздаг. Тэгээд Ерөнхийлөгчийн

Тамгын газартай ярьж зөвшилцөөд шийддэг.

2 дугаарт нь, Элчин сайд нарыг томилохоос өмнө ямар арга хэмжээ авч байгаа вэ гэж байна. Бид ер нь яах вэ, өмнө нь олон жилийн өмнө бас орон нутагт удаан хугацаагаар ажиллуулдаг байсан юм байна лээ. Элчин сайдыг томилохоос нь өмнө бас нутаг орны амьдралтай танилцуулах, олон салбарын үйл ажиллагаатай танилцуулах ажиллагааг зохион байгуулдаг байсан. Одоо бол тодорхой төлөвлөгөө хөтөлбөр гаргаад, явахаас нь өмнө бүр 3-4 сарын хугацаанд бас бэлддэг. Бүх салбарын үйл ажиллагаатай танилцуулдаг, салбар болгоны сайдтай уулздаг. Тэгээд тухайн оронтой холбоотой онцлог салбаруудтай нэлээн нарийн мэдээлэл авхуулах ийм чиглэлийг өгч бол төлөвлөгөөний дагуу ажилладаг. Миний хувьд Элчин сайд нарын бас тантай санал нэг байгаа. Орон нутгийнхаа ажил амьдралыг сайн мэддэг байх ёстой. Хөдөө аж ахуйтайгаа маш сайн танилцсан байх ёстой гэдэг үүднээс орон нутагт ажиллуулах энэ саналыг тавиад энэ жилээс эхлээд хэрэгжээд явна.

Л.Мөнхбаатар: Ганбат гишүүн тодруулж асууя. Дашидондогийн Ганбат гишүүний микрофон өгье.

Д.Ганбат: Ер нь бол та бүхний ажлыг дэмжиж байгаа, боломжийн байгаа. Энэ Элчин сайдуудыг дэмжиж байна. Сая та тэр нөгөө энэ ээж, аав нь 2 дахь, 3 дахь үе нь ингээд өндөр хөгжилтэй улс орнуудад төрчихсөн ийм үеийг яах гэж байна вэ? Байна вэ? Тэд нар чинь Америкийн иргэншилтэй болж байна. Шведийн иргэншилтэй болж байна. Солонгосын иргэншил авч байна. Би бол тэгээд байгаа шүү дээ. Нэг 35 мянган доллароос дээш байдаг юм уу, 50 мянган доллароос дээш байдаг юм бол бас давхар иргэншил өгч болох уу? Тэр хүүхдүүдийг манай маш хэрэгтэй боловсон хүчнүүд болж байгаа. Ээж, аав нь өөрийнхөө хичээл зүтгэлээр эхний үе нь бол тэгээд хар ажил хийгээд, бид нарын нэг сайн юм

байна л даа. Хамаг мөнгөө үр хүүхдэдээ зориулдаг, маш өндөр боловсрол эзэмшсэн ийм залуучууд гарч ирж байна шүү дээ.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өгье. Асуултад тодруулгад нэмж хариулъя.

Н.Анхбаяр: Ганбат гишүүний асуултад тодруулга өгье. Төрийн нарийн бичгийн даргын хувиар. Таны хөндөж байгаа асуудал ялангуяа АНУ-д бодитой бий болоод нэлээдгүй хугацаа өнгөрч байна. Хуулийн дагуу буюу иргэншлийнх нь хувьд харьяатынх нь хувьд аваад үзэх юм бол Монгол эцэг эх нь, Монгол эцэг эхээс төрсөн Монгол хүүхэд хөлсний зарчмаар тэнд Америкийн иргэншил авч байгаа ч гэсэн Монголынхоо иргэншилд иргэн л байгаа, иргэн л байгаа. Бүртгэлийн хувьд. Мөн хөлсний зарчмаар юу АНУ-ын Үндсэн хуулийн дагуу АНУ-ын иргэн болж байгаа.

Одоо гол асуудал Монгол Улс харьяатынхаа тухай хуульд нэмэлт оруулж, хуулийн дагуу Монголын хуулийн дагуу хоёрдмол харьяаллыг нь хуульчлан баталгаажуулах уу, үгүй юү гэдэг асуудлаар бид нар нэлээн судалгаа хийчихсэн байгаа. Нэлээн судалгаа хийгээд ер нь хуулийн төсөл боловсруулбал ямар хүрээнд хуулийн төслийнхөө хамрах хүрээг бий болгох вэ гэх мэтчилэн. Ер нь зарчмын хувьд яг таны хэлээд байгаа хүрээ н ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Асуултад гүйцээгээд хариулчихъя. Анхбаяр даргын микрофоныг өгье. 84 дүгээр микрофон.

Н.Анхбаяр: Таны хэлж байгаа яг тэр хүрээнд хуулийн төсөл боловсруулахад зарчмын хувьд болохгүй зүйлгүй гэж бодож байгаа. Гэхдээ бас тэр ажиллаж амьдарч байгаа улс орнуудын Гадаадын иргэний эрх зүйн байдлынх нь хуулиудтай маш сайн уялдуулж байж тэдгээр Монгол иргэдийнхээ эрх ашгийг тэндээ байнга оршин суудаг улс орондоо болон Монгол Улсад зохих ёсоор нь эдлүүлэх өнцгөөс нь нэлээн судалгаанууд хийгдэж байж хийх

ёстой гэж үзэж байгаа. Төрийн алба хаах, цэргийн үндсэн үүрэгт ажлаа хийх, татварын асуудал, сонгуулийн эрхийн асуудал гэх мэтчилэн энэ олон асуудлыг судалж байгаа. Судалгааны ажлууд нэлээн урагштай явж байгаа. Баярлалаа.

Л.Мөнхбаатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ,
Мөнхцэцэг, Батсуурь, Баттөмөр,
Батжаргал.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар санал хураалт явагдах ёстой. Санал хураалтыг 14 цагаас санал хураалтыг явуулъя. 13 цаг болсон байна. Өдрийн завсарлага боллоо.

Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдааныг завсарлуулж байна.

ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН

Г.Занданшатар: Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн үдээс хойших хуралдаан нээснийг мэдэгдье.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа.

Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглана.

Одонтуяа дарга аа, нөхдийг цуглуулъя.

Ирэх 7 хоногийн Төрийн байгуулалтын байнгын хороогоор авч хэлэлцье.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орно.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан байгаа.

Байнгын хорооны саналаар Элчин сайд нарыг эгүүлэн татах асуудлаар нууц санал хураана. Үнэнбат дарга ирц шалгая.

Байнгын хорооны саналаар Монгол Улсаас БНПУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бархасын Доржийг, Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Жанабазарыг, 3-д, Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суух Байнгын төлөөлөгч Воршиловын Энхболдыг эгүүлэн татах саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

61,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ Цогтбаатар дарга санал хураалт явуулахаар л алга болчихоод л, яг гүйж орж ирдэг нэг муу зуршил тогтоож. Тийм, үүнийг эсэргүүцэл илэрхийлж байгаа гэж ойлгох уу. Сандагийн Бямбацогт гишүүн суу. Сайд нар суудалдаа сууна шүү.

Одоо Байнгын хорооны саналаар Монгол Улсаас БНСУ-д суух Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдаар Сүхээгийн Сүхболдыг томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураана.

Энэ дээр горим байдаггүй юм. Ямар горим байдаг юм бэ? Горим гэдэг чинь санал хураалт, хуралдааны дэгтэй холбоотой. Хүнд зориулж хэлсэн горимын санал гэж байхгүй.

Санал хураалт. Энэ ингээд хүнд зориулж үг хэлнэ гэсэн учраас наадах чинь хүлээн зөвшөөрөхгүй. Хүнд зориулж хэлсэн үг бол горимын санал биш ээ.

Ингээд Сүхээгийн Сүхболдыг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт, нууц санал хураалт.

67,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Бат-Эрдэнэ гишүүн картаа уншуулчих, карт чинь уншигдаагүй байна.

2. Монгол Улсаас БНПУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгалмааг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

68,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ Бөхчулууны Пүрэвдорж гишүүн битгий жалга довын үзэл гаргаад бай. Энэ Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайд нарыг томилж байгаа болохоос биш баруун, зүүн бүсээс гэж хуваагдаж ингээж асуудал ярьж болохгүй. Нэр дэвшигч нар ч гэсэн үүнийг анхаарвал зохино.

Монгол Улсаас Шведийн хаант улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэвэгдоржийн Мөнх-Өлзийг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулъя.

70,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр Нямдоржийн Анхбаярыг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

68,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Чуулганы нэгдсэн хуралдаан дээр явагдсан санал хураалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид албан бичгээр хүргүүлнэ.

Зөвшилцөх тухай саналыг хэлэлцлээ.

Ингээд Монгол Улсаас гадаадын улс орнуудад суух Элчин сайдаар томилогдохоор зөвшилцсөн та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Ингээд энэ Пүрэвдорж нарын гишүүд чинь ингээд яриад байгаа бүс нутаг юм уу аймаг төлөөлж байгаа улсууд биш Монгол Улсыг төлөөлж байгаа улсууд шүү. Жалга довын үзлээр Пүрэвдорж гишүүн шиг ингээж асуудалд хандахгүй байхыг та бүхнээс хүсье. Бүсчилж хөгжүүлэх гэж ядаж байхад хажуугаар нь ингээд.

14.20 цаг

“Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг танилцуулна.

Б.Батцэцэг: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт улс төр, эдийн засгийн харилцааны түвшин, ач холбогдол зэргийг харгалзан дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, орон тоог шийдвэрлэж байна гэж заасны дагуу Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах саналыг Засгийн газар гаргаж, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороотой 2023 оны 10 дугаар сард зөвшилцөн дэмжсэн шийдвэр гарсан.

Байнгын хорооны шийдвэрийн дагуу Элчин сайдын яам нээх хүсэлтээ Узбекистан тал дипломат шугамаар тавьж, зөвшөөрсөн хариу авсан тул холбогдох хууль тогтоомжийн дагуу “Бүгд Найрамдах Узбекистан улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлж байна.

Бүгд Найрамдах Узбекистан Улс нь хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр өндөр хөгжсөн 35 сая гаруй хүн амтай, бүс

нутагтаа томоохонд тооцогдох зах зээлтэй улс юм. Тус улстай хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллаж, импорт, экспортын бараа бүтээгдэхүүний нэр төрөл, худалдааны эргэлтийг өсгөн нэмэгдүүлэх, тэр дундаа манай улсаас мах махан бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүн нийлүүлэх бүрэн боломжтой. Мөн бүс нутгийн зах зээлд гарах гол түшиц газар болох байрилын давуу талтай юм.

Олон талт арга хэмжээний үеэр дээр 2 улсын төрийн тэргүүн нарын хийсэн уулзалт болон Гадаад харилцааны сайдын 2023 оны 3 дугаар сард хийсэн айлчлалын үр дүнд тус улстай Засгийн газар хоорондын комисс байгуулах, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх зэрэг тохиролцоонд хүрснээс гадна агаарын харилцааны болон авто тээврийн хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцож байгуулахад бэлэн болоод байна.

Ингэснээр тус улстай болон тус улсаар дамжин Төв Азийн улс орнуудтай харилцах, дамжин өнгөрөх логистикийн давуу тал бүрдэнэ. 2 улсын иргэд харилцан визгүй зорчдог тул иргэдийн солилцоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг өсөн нэмэгдүүлэх таатай боломж бас байна.

Элчин сайдын яам 3 орон тоотой ажиллах бөгөөд төсвийг 2024 оны төсөвтөө тусган батлуулсан болно. Элчин сайдын яамыг энэ онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй дээд түвшиний айлчлалын үеэр нээхээр төлөвлөж байна.

Иймд “Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хавдисламын

Баделхан танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Баделхан: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн “Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганбат уг төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд Төв Азид оршдог, 35 сая хүн амтай тус улстай гадаад харилцаа, худалдаагаа өргөжүүлэх боломжтой гээд манай улсын Элчин сайдын яам тус улсад үйл ажиллагаа явуулах Элчин сайдын яамны байраа түрээслүүлэх эсэхийг тодруулан асууж, боломжтой бол байраа худалдан авах нь зүйтэй тухай, мөн Бүгд найрамдах Индонез Улс болон Холбооны Бүгд найрамдах Бразил Улсад байгуулсан Элчин сайдын яамдыг татан буулгасан шалтгааны талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Бүгд Найрамдах Узбекистан Улс нь Төв Азид орших байрлал сайтай, цаашид хөгжих боломжтой улс учраас тус улстай гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татахад анхаарч, Элчин сайдын яамны байраа худалдан авах нь зүйтэй бөгөөд хаана ямар байриилд үл хөдлөх хөрөнгө худалдан авах талаар сайн тооцоолох, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд шинээр Элчин сайдын яам байгуулахад аж ахуйн талаар хүндрэл бэрхшээл ихтэй байдаг тул энэ тал дээр туршилагатай хүмүүсийг тус улсад томилохыг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин Элчин сайдын яам нээн ажиллуулахыг дэмжиж байгаагаа

илэрхийлээд, төв ажиллах хамгийн том эдийн засагтай 80 тэрбум долларын ДНБ-тэй алт, зэс, газрын хий, нефть олборлох, боловсруулах улс тул манай улсын Засгийн газраас баримталж байгаа эдийн засгаа солонгоруулах хөтөлбөрт ашигтай бөгөөд цаашид Хөдөө аж ахуй, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох, шууд нислэг, аялал жуулчлалыг нэмэгдүүлэх талаар гадаад харилцааны болон холбогдох яамд анхаарч ажиллах нь зүйтэй гэж санал гаргалаа.

Мөн Байнгын хорооны дарга Энх-Амгалан Гадаад харилцааны яамны зүгээс Улсын Их Хурлын гишүүдийн хэлж буй саналыг анхааралдаа авч, ажил хэрэг болгох, Турк, Азербайджан, Казахстан, Монгол гэсэн дунд коридор, Турк, Азербайжан, Казахстан, Пакистан, Зүүн Өмнөд Ази гэсэн 2 дахь коридор, дунд Ази руу чиглэсэн Узбекистан, Киргиз, Эстони, Армени гэсэн чиглэлүүд дээр манай улсын худалдааны бүс байж болох гарцыг судлах, Элчин сайдын яамны үйл ажиллагаа өргөжих үед орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн саналуудыг гаргалаа.

“Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхыг дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу. Батсуурь гишүүнээр

тасаллаа. Сандагийн Бямбацогт гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Бямбацогт: Энэ маш чухал Элчин сайдын яам нээгдэх гэж байгаа юм. Урьд нь бид нар Киргизэд Элчин сайдын яам нээсэн. Харьцангуй одоо юу гэдэг юм, 2, 3 сая, 3 сая орчим хүн амтай бас тийм юу гэдэг юм, хөгжлийн хувьд бас тийм сайн ч биш. Узбекистан сая бас хэллээ. Тийм ээ, 80 тэрбум долларын ДНБ-тэй, 30 хэдэн сая хүн амтай, Төв Азийн улсууд дотроо үндсэндээ хамгийн нөлөө бүхий нэлээн сайн хөгжиж байгаа ийм улс. Монголоос ч гэсэн бас Европ руу явах бас нэг хамгийн дөт зам гарц. Мөн бас Төв Азийн улсууд руу Төв Азиар дамжаад бас Арабын Ойрх Дорнодын улсууд руу гарах маш том гарц болж байгаа.

Тун удахгүй бид нар бас Узбекистан улстай авто тээврийн болон агаарын тээврийн хэлэлцээр байгуулна. Ташкент руу шууд нисдэг болно. Мөн бас Хятадаар дамжаад Узбек рүү авто тээвэр хийдэг болно. Яах гэж байгаа вэ гэхээр бид нар үндсэндээ Монголоос мах махан бүтээгдэхүүн тээвэрлэж, Узбек болон цаашлаад Төв Азийн орнууд, Ойрх Дорнодын улсууд руу, Иран, Пакистан гээд улсууд руу хүргэх, Саудын Араб, Эмират, наашлаад бас тийм үү, буцаагаад жимс жимсгэнэ, өнөөдөр Монголд зарагдаж байгаа энэ жимс жимсгэнэ Узбекистан Төв Азийн орнуудад хэд дахин 3-5 дахин хямд үнэтэй байдаг юм байна лээ. Ингээд 2 талдаа тээвэртэй. Ингээд 2 орны худалдаа, эдийн засгийн хөгжихөд энэ Узбекистан улстай Элчин сайдын яам байгуулагдах, Узбекистан улстай харилцаагаа хөгжүүлэх маш чухал байгаад байгаа юм.

Агаарын тээврийн хэлэлцээртэй болоод шууд нисдэг болчиход 2 улсын хооронд иргэд зорчино. Карго тээвэр ч хийх бололцоотой ачаа тээвэр үндсэндээ, онгоцоор жимс жимсгэнэ тээвэрлэх бололцоотой болно. Авто тээвэр Хятадаар дамжаад тээвэр хийх хэлэлцээр хийчихсэн. Энэ хэлэлцээрээ дагаад цаашаа Узбекистанд хийснээр

үндсэндээ Узбекистан руу Монголчууд, Монгол тээвэрчид тээвэр хийгээд мах махан бүтээгдэхүүн тээвэрлэж оччихоод, буцаагаад жимс жимсгэнэ тээвэрлээд ирэх ийм бас бололцоо боломж бий болох юм. Энэ тийм ач холбогдолтой учраас манай гишүүд бас зөв ойлгоосой. Киргизээсээ илүү Төв Азийн орнуудад хамгийн илүү ач холбогдолтой Элчин сайдын яам бол Узбекистан байгаа. Узбекистанаас ч гэсэн энэ бас цааши нислэгүүд задрахад олон улс руу цаашилаад Энэтхэг рүү, Африк руу, Ойрх Дорнодын улсууд руу задрахад бас хамгийн дөт ийм зам байдаг юм байна лээ. Ташкентын нисэх буудал ч гэсэн маш сайн задардаг ийм нисэх буудал юм байна лээ.

Тийм болохоор Элчин сайдын яам байгуулахыг дэмжиж байгаа. Гишүүд бас зөв ойлгох байх гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэллээ, тийм ээ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Элчин сайдын яамдын гол үндсэн ажил иргэдийн харилцан зорчих асуудал гол асуудал байдаг. Тэгээд би түрүүчийн томилгоо дээр сайдын томилгоо дээр үг хэлэх гээд чадсангүй. Тэгэхээр манай иргэдийг ялангуяа БНСУ-аас баахан виз өгчхөөд тэгээд түүнийгээ буцаадаг ийм зүйл ялангуяа 9 сар, 8 сарын үед хэрээс хэтэрсэн. Тэгээд одоо бас жоохон гайгүй болж эхэлж байгаа. Тэр нь бас тодорхой хэмжээгээр миний өгсөн ярилцлагатай холбоотой. Өөрөөр хэлбэл, би 2012 оны сүүлд очиход Гадаадын иргэн харьяатын байгууллагын даргаар очсон. Ингээд очиход ялангуяа Солонгосын хил дээрээс маш их олон иргэдийг буцаадаг байсан. Тэгээд 1 тохиолдол, өөрөөр хэлбэл Чэжү арал руу БНСУ визгүй оруулдаг мөртөө Монголын 7 иргэнийг тэнд 7 хоног хориод, нөгөө Хүннү эйрийн онгоц 7 хоногийн бүтэн сайн өдөр нисдэг. Дараагийн бүтэн сайн өдөр нь 7 хоног хорьчихоод тэгээд буцаагаад нисгэсэн юм. Тэгээд би тэр орой нь Кореан Эйрлайнс онгоц дээр очоод байгууллагынхаа бүх нисэхийн

байгууллагын ажилтнуудыг бүгдийг нь дуудаад өнөө оройны Кореан эйрийн онгоцоор 7 Солонгосыг буцаана гээд. Тэгэхэд манай тэр албаны дарга хэлж байсан л даа. Ер нь ингэж болохгүй, энэ чинь 2 орны харилцаанд муу нөлөө үзүүлнэ гэхээр нь би хэлж байсан. Нэг улс нь 7 Монголыг буцаадаг, нөгөө улс нь юу ч хийж чаддаггүй ийм хамтын харилцан ажиллагаа гэж ерөөсөө байдаггүй юм. Тэгээд 7 Солонгос буцаана гэсэн. Тэгээд манай хэд явж байгаад 6 болгосон. Тэгээд 6 болчихлоо дарга аа, гэхээр би заавал 7 болго гэсэн. Жоохон явж байснаа дахиад дарга аа, 8 болчихлоо гэхээр нь би хэлж байсан. Нэгийг нь оруул аа. Хэнийг нь оруулах юм гэхээр нь хамаагүй ээ хэн нь ч хамаагүй. Хамгийн гол нь тэр Хууль зүйн яамны ахлах мэргэжилтнийг заавал буцаагаарай. Тэгээд 7 Солонгос буцаасан. Амарсайхан энд сууж байна. Манай Гадаад харилцааны дарга байсан, бүгдийг нь мэдэж байгаа. Тэгээд маргаашаас нь эхлээд над дээр Солонгосын элчин, консулынхан бүгдээрээ ирээд уулзана гэхээр нь би та нар Монголчуудыг буцаадгаа больчихоод түүний дараа надтай уулзаарай гээд.

Тэгээд 2013 оны 01 сарын 01-нээс хойш намайг ажлаасаа буух хүртэл нэг ч Монгол хүнийг хил дээрээс буцаагаагүй шүү дээ. Энэ бас энд бас хэн сууж байгаа юм. Энхбаяр сайд сууж байна. Яг ийм байдлаар бас хууль хяналтын байгууллагыг бас энэ ажилдаа оролцуул. Ялангуяа гадаадын харьяатын байгууллага бол тодорхой хил дээр асуудлыг бас цэгцлэх ийм боломжтой. Тэгээд ер нь энэ ийм байдлаар энэ маш их хүмүүс виз авч, тэр баахан нөгөө виз гаргадаг хүмүүст зөндөө төлбөр төлж төлчхөөд тэгээд очингуут онгоцны билет аваад очингуут нь бүгдийг нь буцаадаг, хохирдог ийм явдал Монголчууд маш их гарч байгаа шүү дээ. Энэ зүйлийг ийм байдлаар тэмцэх ёстой байхгүй юу даа. Одоо жоохон багассан байгаа. Тэгээд энэ зүйл дээрээ бас нэг жоохон хатуухан байр суурьтай байхгүй бол болохгүй нь, 1 дүгээрт.

2 дугаарт, тэнд очиж ажиллаж байгаа нь их юм. Солонгост ажиллах хүчин олдохгүй хэцүүдэж байгаа. Монголчууд тэнд очиж ажиллаад тэд нарт л буян болж байгаа.

Г.Занданшатар: Энэ Амарсайхан нөхөр толгой дохиод л байна. Ингээж ярьж болдог л юм байлгүй. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Тэгээд энэ дээр нэг хэдэн зүйл тодруулъя. Тэгээд бас саналаа хэлье. Яг Монгол Улсаас гадаад улсуудад манай иргэд бас асуугаад байдаг юм. Хэдэн Элчин сайдын яам, консулын газар ажиллаж байгаа вэ? Түүнд зарцуулаад зориулж хэдэн төгрөг улсын төсвөөс тавьж санхүүжүүлдэг вэ? Үүнийг нэг мэдчихмээр байна.

Тэгээд энэ Узбекийн Ташкентад Элчин сайдын яам нээвэл ямаруу хэмжээний зардал нэмэгдэх юм бэ? Тэгэхээр зардал нэмэгдэнэ гэхээр бас л улсын нуруун дээр ачаа болно. Тэгэхээр энэ олон Элчин сайдын яамд байгаа байх. Энэ дээр Гадаа харилцааны яам энэ гадаад бодлого дээрээ Элчин сайдын яамнуудын асуудал дээр ер нь дүн шинжилгээ хийж, одоо ингээд шаардлагатай газар гээд бид нар байгуулж байна шүү дээ. Тэгэхээр энэ шиг шаардлага багатай, үр дүн багатай газар гэж ер нь байна уу? Ер нь болиулах, Элчин сайдын яамыг татах гэдэг юм уу ийм асуудал яригддаг юм уу? Бид нар ер нь яах вэ, олон тийшээ нээлттэй гадаад харилцааны бодлого ингээд явуулдаг. Тэгэхээр энэ дээр энэ Элчин сайдын яам байгуулаад Элчин сайд томилогдоод ингээд ажиллавал бас л нэг гарц гэж ингээж харж байна. Эергээр харвал.

Энэ хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний борлуулалт, ялангуяа энэ Узбек рүү тэр богийн мах, хонь, ямааны мах борлуулах энэ тал дээр бас ахиц гарчих болов уу гэж ингээж харж сууж байгаа. Тэгэхээр манай дээр ингээд илүү байгаа, илүүдээд байгаа борлуулалтаа хийж чадахгүй байгаа энэ

мах, махны асуудал бас жоохон бага ч гэсэн цэгцрэх юм болов уу гэж ингээж харж байгаа.

Тэгэхээр энэ дээр та бүхэн бас харж байна шүү дээ. Энэ жил ингээд малын мах нь байгаад байдаг, малын тоо байгаад байдаг, ингээд борлуулалт байхгүй, махны үнэ уначихсан, ингээд хүнд байгаа энэ үед энэ дээр ер нь судалгаа тооцоо гэж юм байна уу гэдэг нэг асуулт байна.

Буцаагаад мэдээж тийшээ борлуулсан тохиолдолд энэ Узбек өөрөө жимс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээрээ алдартай. Тэгэхээр энэ дээрээс бас эргэж, импорт хийх ийм боломж байгаа байх гэж ингээж харж байна.

Нэг зүйл, судалгаа байдаг юм уу үгүй юү? Өнгөрсөн жил Үйлдвэр хөдөө биш ээ, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо дээр гараад явсан нэг асуудал энэ ноолуурын боловсруулалттай холбоотой асуудал. Тэгэхээр бид нар ноолуурыг ганцхан Хятад руу биш дотооддоо боловсруулалт хийгээд самнаад, Европын зах зээл рүү энэ Узбекээр дамжуулаад цааш нь гаргах ийм боломж ер нь байгаа юу? ОХУ ингээд нэлээн дайн байлдааны асуудал ингээд янз бүрийн байдлаар энэ тээврийн хувьд ингээд асуудалтай болчихлоо, тийм ээ. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн бодсон, судалсан асуудал байгаа юу. Энэ ноолуур чинь бид нар Европын зах зээл тухайлах юм бол шууд Итали руу Монголдоо боловсруулалт хийгээд зарах юм бол бид нар эдийн засгийн үр өгөөж маш ихтэй тооцоо гарч байгаа шүү дээ. БНХАУ-д хийгээд угаагаад, самнаж байгаа тэр үйлдлийг манай Монголчууд хийж болно, өртөг шингэнэ. Тэгэхээр энэ дээр эдийн засгийн юм уу, ямар нэгэн байдлаар зам коридор болж чадах ийм судалгаа энэ Узбект Элчин сайдын яам нээснээр гарч ирэх үү гэдэг ийм асуултуудыг асууя.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Батцэцэг сайд 82.

Б.Батцэцэг: Туваан гишүүний асуултад хариулъя. Монгол Улс нийт 47 дипломат төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байгаа. Түүний 32 нь Элчин сайдын яам, 2 Байнгын төлөөлөгчийн газар, 9 Ерөнхий консулын газар, 3 консулын газар үйл ажиллагаа явуулж байгаа. Нийт төсөв нь 42,4 сая доллар, жилд, жилийн. Узбекистаны хувьд жилийн төсөв нь 355809 мянган доллар байгаа. Ер нь манай дипломат алба маш цөөхөн хүнээр үйл ажиллагаагаа явуулдаг. Цаашидаа өргөжүүлэх, хүний нөөцийн хувьд бэхжүүлэх, дипломатуудынхаа тоог нэмэх, дипломат төлөөлөгчдийнхөө газрыг нэмэгдүүлэх ийм бодлоготой ажиллаж байгаа. Гадаад харилцаагаа өргөжүүлье гэвэл бас дипломат албаа бэхжүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Тийм учраас цаашидаа хаах, хасах дипломат төлөөлөгчийн газар байхгүй. Харин нэмэгдүүлэх ийм бодлоготой байгаа. Ялангуяа Төв Азийн орнуудад Элчин сайдын яамыг Узбекистаныг сонгож бас нэлээн удаан хугацаанд бас судалж, хамтарч ажилласан. Узбекистаны тал ч өөрсдөө бас манайтай хамтарч ажиллах сонирхолтой байгаа. Өндөр дээд хэмжээнд бас улс төрийн нэлээн нарийн өндөр хэмжээний итгэлцэл үүссэн байгаа гэдэг утгаараа энэ Дипломат төлөөлөгчийн газар байгуулагдсанаараа үр ашиг нь нэл илүү хурдан харагдах байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Дашидондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Туваан гишүүн бас хариултаа дуусаагүй гээд байх юм. Туваан гишүүний хариултыг гүйцэд өгчихсөн нь дээр байх.

Г.Занданшатар: Батцэцэг сайд гүйцээгээд хариулчих.

Б.Батцэцэг: Тэгээд үргэлжлүүлээд хариулъя. Хөдөө аж ахуйн салбар өндөр хөгжсөн орон Узбекистан. Тэгээд махны импортыг Узбекистан маш

их сонирхож байгаа. Мах, махан бүтээгдэхүүн, ноос ноолуурын чиглэлээр хамтарч ажиллахаар ААН-үүд ажиллаад эхэлчихсэн байгаа. Тээвэр логистикийн хувьд Агаарын харилцааны хэлэлцээр, авто замын хэлэлцээрийг бид нар яриад эхэлчихсэн байгаа.

Мөн мал, мах дээр махны хорио цээрийн асуудлыг бас шийдэх шаардлагатай байгаа. Зөрүүлээд мэдээж Узбекистаны тал хүнсний аюулгүй байдал, хүнсний чанарын маш өндөр хангасан ийм орон. Тийм учраас хүнсний асуудал дээр бид нартай түрүүлээд хүнс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, цэцэг, самар зэрэг бүтээгдэхүүнийг манайд нийлүүлэх сонирхолтой байгаа. Тэгээд ААН-үүдтэйгээ бид нар бас эхний ээлжид 2 удаа бизнес форум зохион байгуулсан байгаа. Засгийн газар хоорондын комиссыг бас байгуулсан байгаа.

Г.Занданшатар: Дашипүрэвийн Амарсайхан. Төрийн захиргаа удирдлагын газрын захирал. Монгол Улсын иргэдийг хилээс буцаагаад байгаа асуудлыг шийдвэрлэх бололцоотой гэдэг дээр толгой цохисон. Түүнийгээ яаж шийдэх юм. Дашипүрэвийн Амарсайхан хариулъя. 81, 82.

Б.Батцэцэг: БНСУ-ын хилээр Монгол иргэдийг яагаад буцааж байгаа вэ гэдгийг үдээс өмнөх хуралдаан дээр бас тайлбарласан. Нийтдээ БНСУ-д хууль бусаар амьдарч, ажиллаж байгаа 430 мянган иргэн байгаа гэж тооцож байгаа. Түүнд мэдээж Монгол иргэд байгаа. Ингээд гэмт хэргийн гаргалт, үүсгэж байгаа зөрчил болон бусад бодлогынхоо хүрээнд энэ 430 мянган хууль бусаар оршиж байгаа иргэдээ багасгах бодлого барьж байгаа юм байна лээ. 50 хувь хүртэл бууруулах. Энэ бодлогынхоо хүрээнд 2023 онд гэхэд 40 мянган иргэнийг нутагт нь буцаасан байгаа.

Монгол иргэд визийг нь нөгөө визээ мэдүүлэхдээ зөв мэдүүлээд, хил дээр очоод хил нэвтрэх дээ мэдүүлсэн мэдүүлэгтэйгээ зөрдөг, зорилгоо

тодорхойлж чаддаггүй, буцах хугацаа нь тодорхойгүй, буух буудал нь тодорхойгүй гээд мөн урьд нь бас Солонгос улсад хууль бусаар оршин сууж байсан гэдэг ийм шалтгаануудаар Монгол иргэдийг заримыг нь бас буцааж байгаа.

Гадаа харилцааны яам энэ дээр үргэлж араас нь хөөцөлдөөд ажиллаж байгаа. Солонгос дахь Элчин сайдын яам маш ачаалалтай ажилладаг. Хилээр иргэдийг аль болохоор буцаахгүй байх, хил дээр саатуулагдаж байгаа иргэдэд бас туслалцаа үзүүлэх чиглэлээр ажиллаж байгаа. Гэхдээ айлын хууль дүрэмд нийцээгүй тохиолдолд яалт ч үгүй буцаж байгаа гэдгийг хэлж байгаа. Тэгээд Гадаад харилцааны яам иргэдийг буцааснаас эхлээд сүүлийн хагас жил 23 оны оны эхнээс байнгын мэдээлэл хийж, байнгын сэрэмжлүүлэг анхааруулга гаргаж байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Манайх Узбекистан улсад Элчин сайдын яамаа нээх гэж байгаа нь зөв байна. Үүнтэй холбогдуулаад бас би энэ хэд хэдэн зүйлийг тодруулаад бас өөрийнхөө санал бодлыг илэрхийлье гэж бодож байна.

Бид нар дэлхий дээр хамгийн том эзэнт гүрнийг байгуулж байсан. Хуурай газрын талыг дэлхийн талыг Монголд ч нэг үе тийм л явлаа. Гэхдээ агуу их түүхтэй байхаас гадна бид нарын ирээдүй бас энэ залуучууд сайн сайхан байх ёстой. Жишээлбэл Узбекистан бол өөрөө Батхааны ач чицэнцэрийн Узбек хааны нэрээр л нэрлэсэн ийм улс шүү дээ. Узбекистан гэдэг нэр авчихсан тийм, ийм байгаа. Тэгээд юу хэлэх гэж байна вэ гэхээр харамсалтай нь энд тэнд хөгжилтэй улс орнуудын хэл дээр манай иргэд ингээд л хөөгдөөд л, туугдаад л, шалгуулаад л ийм байдалтай байна. Уул нь энэ бүс нутагтаа Монгол Улс хамгийн ядуу улсын тоонд орчихсон. Иргэд маань нэг иймэрхүү маягтай ийм байж байна. Энэ харамсалтай байгаа юм. Энэ дээр

Монгол Улсын төрийг түшиж байгаа бид бүхэн ялангуяа энэ 2 нам эрх барьж байгаа, анхаарвал ажиллах бодлогоо арай өөрчилж ингэж анхаарч ажиллах ёстой юм гэж бодож байна.

Элчин сайдын яамдыг байгуулахдаа та бүхэн маань нэлээн судалгаан дээр байгуулж байгаа байх. Байгуулахдаа бас бид нарын нэг юу байна л даа. Уламжлал, 50, 60 жилийн өмнө байна, манай ахмад дипломатууд маш их сайн судалгаан дээр тэр газраа сонгож байсан байна. Байрлалаа сонгож байсан байна, тухайн хотдоо. Тэгэхээр танай яаман дээр тийм ажлын хэсэг байгаа юу. Аль нэг газартай хамааруулж байгаа юу. Нэлээн сайн судлах ёстой, тийм ээ. Энэ гудамжиндаа авбал зүгээр юм, энэ хэсэгтээ газраа авъя, Элчин сайдын яамнуудаа ингэж ингэж байгуулъя гээд. Болохгүй бол ганц Элчин сайдын эхний 3 хүндээ яах биш. Өмнө нь бүрэлдэхүүн явуулж судалж, үүнийг бэлдэж барьж хийвэл бас их үр дүнтэй байх болов уу гэсэн ийм бодол байна. Ингэж хийх ёстой. Энэ дээр яаж ажиллаж байна вэ?

Бас ингээд хараад байхад тэр Бразил, Индонез энэ тэр Элчин сайдын яам байгуулаад л, буулгаад л ингээд явсан. Ийм буруу зөрүү алдаатай ажил хийж байна. Энэ татан буулгаад ахиад байгуулаад байхаар мөнгө төгрөг их явна. Нөгөө ажиллаж байсан хүмүүсийн туршилага байхгүй болчихож байна. Тэгээд тэр Латин Америкийн улс орнуудад манайхыг төлөөлж ажиллах яг тэр нүдээ олсон Элчин сайдын юмаа байрлуулж чадаж байгаа юу? Би тухайлбал Мексикт байх ёстой гэж бодож байна. Тэр араб, Өмнөд Африк, Африкийн орнууд дотроо бас тэр хавьд нь байгуулж чадаж байна уу? Дэлхий жижигхэн болчихсон шүү дээ. Дэлхий хавтгай болчихсон, энэ улс орны хэмжээнд, дэлхийн хэмжээнд ажиллах ийм асуудлууд бид нарт байна.

Ер нь бид нар их хоцрогдож байна шүү. Энэ дэлхийн улс орнууд чинь бүр гараг ертөнцөд аялах, тэндээс бараг уул уурхайн бүтээгдэхүүнээ зөөх энэ

асуудлуудыг хүртэл ярьж байна шүү дээ. Гадаад харилцаанд бид нар нэг их мөнгө хайрлаад байх шаардлагагүй, оновчтой зөв зарцуулах ёстой. Тэгэхгүй бол зүгээр нэг авлигач түшмэлийн гэрээс л хэдэн тэрбум гарч ирж байна шүү дээ.

Г.Занданшатар: Хэн Батцэцэг сайд хариулъя. 82.

Б.Батцэцэг: Баярлалаа. Ганбат гишүүнд баярлалаа. Бас манай Гадаад харилцааны яамны үйл ажиллагааг тэлэх ёстой гэдэг санал хэлсэнтэй санал нэг байна. Бид бас бүс нутгуудаа судалж, бас хуучин байгаа бүтэц дээрээ нэлээд ийм судалгаа дүгнэлтүүдийг хийсэн. Тийм учраас Төв Азид бид нар ямар ч байсан Узбекистанд эхний ээлжид нээх ёстой. АСЕАН-ны орнуудад бид нар Индонезид Элчин сайдын яам байгуулж байсан, хаачихсан байгаа. Түүнийгээ дахиад буцааж сэргээж нээхээр болсон. Энэ ондоо багтаагаад нээнэ.

Латин Америкийн орнууд болон Африкийн орнуудын тухайд бас судалгаанууд хийгдсэн. Латин Америкуудын орнуудад Бразилд эсвэл Мексикт Элчин сайдын яам нээх асуудлыг судалж байгаа. Африкт Кайрт Элчин сайдын яам байгаа. Өмнөд Африкийн бүгд найрамдах улсад бас судалгаа хийгдэж байгаа.

Узбекистаны хувьд Элчин сайдын яамаа мэдээж нээхийн тулд бид нар тухайн орон нутагт нь айлын талаас бас санал болгож байгаа байр, савыг бас үздэг. Өөрсдөө түр эхний ээлжид түрээсэлнэ. Яваандаа үндсэн хөрөнгө болгож, худалдаж авах ийм зорилготой байгаа. Мэдээж урьдчилсан баг явж судалж үзсэний үндсэн дээр Элчин сайдын яамныхаа байрыг авна. Энэ чиглэлээр бас манай Төрийн нарийн бичгийн дарга явж ажиллахаар төлөвлөж байгаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооны саналаар “Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Дашпүрэвийн Амарсайхан Монгол Улсын иргэдийг Солонгосын хилээс буцаахгүй байх үүрэг амлалт авлаа шүү дээ, та тийм ээ. Толгой дохиод, үйл хөдлөлөөрөө. 1 л иргэн буцаах юм бол та 2-той ярина шүү.

Ирцээ бүрдүүл.

Санал хураалт явуулъя. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн хаачсан. Өглөө Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдахад байхгүй. Тэгээд сая гараад явчихсан. Мөнхцэцэг гишүүн тэр байж байна. Чойжилсүрэн гишүүн байсан байхгүй, Мөнх-Оргил сайд хаачсан, гишүүн хаачсан.

Санал хураалт явуулъя. Санал дэмжигдсэнгүй. Энэ санал хураалтаар. Дамдинням гишүүн байгаагүй, үг хэлэхгүй. Та л хоцорч орж ирсэн шүү дээ, Б.Энхбаяр, Т.Энхтүвшин.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Бямбацогт сайдын хэлээд байгаа тэр тийшээ нисдэг тэргээр дамжиж явна гэдгээсээ тэнд чинь хамаагүй үнэтэй газар, Туркмен. Киргиз нь хамаагүй хямдхан байдаг юм. Яг тэр нөгөө яг энэ нислэг дээр чинь зардлаа л нөгөө компаниуд бодно шүү дээ. Тийм учраас би бас энэ олон жил тэндээс онгоц авсан хүний хувьд сайн мэдэж байна.

Тэгээд сая би кноп дарахдаа буруу дараад юу андуурч дарагдаад кноп ажилласангүй. Та дахиж санал хураалгаж өгнө үү?

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүний саналаар энэ санал

хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулна. Энэ санал хураалт дэмжигдэхгүй бол тэгээд найдлагагүй шүү дээ. Санал хураалт.

59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Саранчимэг гишүүн ээ, санал өгөх болохоор ороод ирж байхад яадаг юм дандаа хоцорч байх. Аубакир Баделхан гишүүн хаачсан юм. Аубакир гишүүн хаачсан юм.

Одоо санал хураалт явуулна. Горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг дахиж явуулна. Сууцгаа, санал хураалт. Оюунчимэг гишүүн суудалдаа суу. Оюунчимэг гишүүн ажлын хэсгээс орж ирсэн бол суудалдаа суу. Энхтүвшин гишүүн, Ундрам гишүүн, Баттөмөр гишүүн хаачсан юм. Та нар өглөө 9-өөс хуралдах ёстой байсан шүү, тэгж яривал.

Санал хураалт. Санал хураалтыг дахиж явуулж байгаа, хүчингүйд тооцсон учраас.

66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Тогтоолын эцсийн найруулга хаана байна. Энд байна. Улсын Их Хурлын тогтоолыг уншиж танилцуулъя.

Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай. Дипломат албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулахаар тогтоосугай.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга дээр байна шүү дээ, Мягмар дарга аа, энэ дэндүү шалдан тогтоол болчихсон байна. 2 дугаарт тогтоол нь өмнөх Элчин сайдын яам баталж байсан загвараар 1, 2 дугаар заалт хий. Шууд тогтоогоод энэ эрэлтгүй. Эцсийн найруулгаар редакцияар үүнийг авлаа.

Дараагийн асуудалд орно. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

14.57 цаг.

“Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Ганбат дарга тооцоогоо өгөөрэй, Ганбат аа. Чүлтэмийн Ганбат нэрээ мэдэхээ больсон байна. Чи тооцоогоо өгөөрэй гэж чамд хэлсэн шүү.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Борхүүгийн Дэлгэрсайхан эзгүй байгаа тул Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улс нэг хүнд ноогдох газар нутгийн хэмжээгээр дэлхийд эхний байрт жагсдаг боловч өнөөдөр нийт нутаг дэвсгэрийн 0,3 хувийг эзлэх нийслэл Улаанбаатар хотод нийт хүн амын 50 орчим хувь нь амьдарч байна. Түүнчлэн төрийн байгууллагууд 100 хувь, их, дээд сургуулийн 90 хувь, нийт худалдаа үйлчилгээний 86 хувь, нийт хадгаламжийн 81 хувь, бүртгэлтэй ААН-үүдийн 78 хувь нь нийслэлд байрлан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ДНБ-ий 65 хувийг Улаанбаатар хот дангаараа үйлдвэрлэж байгаа нь нэг төв рүү чиглэсэн хэт төвлөрлийг бий болгож байна.

ҮСХ-ноос 10 жил тутамд явуулдаг Хүн ам, орон сууцын ээлжит тооллого, хүн амын шилжилт хөдөлгөөний жил бүрийн тайлангаас үзэхэд хотжилтын түвшин нь хөдөөгөөс хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр хурдацтай өсөж, 2020 оны байдлаар 70 орчим хувьд хүрээд байна.

Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан Шинэ сэргэлтийн бодлогод шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшин иргэд, ААН-ийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулах зорилт тусгасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан боловч төрийн байгууллагууд нийслэл Улаанбаатар хотод төвлөрсөн, хүн амын тоо жил бүр тогтмол өсөж байгаа зэргээс шалтгаалан уг үзэл баримтлалд дурдсан хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах асуудал гажуудсан байна.

Тогтоолын төслийг хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж, хөгжлийн түвшнийг ойртуулж, бүсүүдийн хөгжлийн түвшнийг эрэмбэ дараатай дээшлүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор боловсруулж дараах асуудлыг тусгалаа.

Монгол Улсыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн төрийн байгууллагуудын эрхлэх асуудал, чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хамрах үүрэг харгалзан бүсчлэн нийслэл Улаанбаатар хотоос үе шаттайгаар нүүлгэн байршуулах арга хэмжээ авах,

Улаанбаатар хотоос орон нутагт шилжин ажиллах төрийн албан хаагчид дэмжлэг үзүүлэх, нийгмийн баталгаа хангах асуудлыг судалж зохих арга хэмжээг авах,

Тогтоол батлагдсанаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах талаар бодитой арга хэмжээ авах боломж үүсэж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж, хөгжлийн түвшнийг ойртуулж, бүсүүдийн хөгжлийн түвшнийг эрэмбэ дараатай дээшлүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутагт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татаж, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг бүрдүүлэн, шинжлэх, тухайн технологи, инновацын үйлдвэрлэл, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээг хөгжүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 21.1-д заасны дагуу Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай горимоор хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.17-д заасан хуулийн төсөлд хамааран хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага, урьдчилан тандах судалгаа болон бусад тооцоо хийх шаардлагагүй боллоо. Тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Нямаагийн Энхболд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн танилцуулна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх

асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан нэн яаралтай хэлэлцүүлэх дэгийн дагуу 2024 оны 01 сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлаас Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан боловч төрийн байгууллагууд нийслэл Улаанбаатарт төвлөрсөн, хүн амын тоо жил бүр тогтмол өсөж байгаа зэргээс шалтгаалан уг үзэл баримтлалд дурдсан хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах асуудал шийдэгдэхгүй байгаа тул Улсын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлд заасанчлан Засгийн газар Үндсэн хууль бусад хуулийн биелэлтийг улс орон даяар зохион байгуулж хангах гэсэн бүрэн эрхийн хүрээнд төрийн байгууллагуудыг бүсчлэн нүүлгэн шилжүүлэх асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх чиглэлийг Засгийн газарт өгөх зорилгоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг ди парламент цэг мн цахим хаягт байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд төрийн байгууллагуудыг нүүлгэн байршуулах, орон нутгийг ямар хэлбэрээр бүсчилж байгаа талаар, бүсчлэн байршуулахтай холбоотой мэдээлэл тайлан байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл 2001 онд батлагдсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн үр дүнгийн тайлан гарсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах байршил болон тухайн асуудлаарх бодлого нь тодорхой болсон эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт алслагдсан бүс нутгийн хөгжлийг дэмжих мөн орон нутагт төрийн байгууллагуудыг нүүлгэн байршуулахдаа дэд бүтэц болон нийгмийн асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхболд бүсчлэлийн бодлого болон төрийн байгууллагуудын бүсчлэн байрлуулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байгаа талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

“Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 58,3 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Эрхэм гишүүд ээ, “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Батжаргал гишүүнээр тасаллаа. Жамбын Батсуурь гишүүн асуулт асууя.

Ж.Батсуурь: Энэ Их Хурлын тогтоолууд батлагдаж л байдаг л даа. Тэгэхдээ энэ тогтоол арай л нэг гурилдчихсан арай ядсан тогтоол байна. Арай ингэж болохгүй ээ. Энэ 2001 оны 57 дугаар тогтоол 20 гаруй жил, 24 жил 6 сонгууль яваад хэрэгжээгүй зүйлийг гэнэт чуулган завсарлагдаж байхад нэн яаралтайгаар оруулж ирээд, тэгээд энд нь үзэл баримтлалын ямар ч бодлогын шинжтэй юм байхгүй. Хар үгээр хэлэх юм бол чуулганы завсарлагаанаар саяын батлагдсан сонгуулийн бүсчилсэн

тойрогт Их Хурлын гишүүдийг явуулах, түүний зардлыг Засгийн газраас гаргуулах гэсэн л ерөөсөө л ийм удирдамж маягийн л юм байгаа байхгүй юу. Жишээ нь энэ оруулж байгаа Шадар сайд, Хууль зүйн, дотоод хэргийн сайд, Монгол Улсын ЗГХЭГ гээд ийм том асуудлыг оруулж байж Зам, тээврийн сайд нь уншиж байдаг. Тэгээд Засгийн газрын гишүүд нь байхгүй байдаг. Тэгээд ийм том бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай холбоотой асуудлуудыг ингэж явж болохгүй. Та хэд маань арай дэндэж байна, нээрээ. Жишээлэх юм бол энэ төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулна гэж байгаа юм. Ямар сургуулиудыг аль аймаг руу явуулах гэж байгаа юм, ямар байгууллагуудыг аль аль бүс рүү явуулах гэж байгаа юм. Ямар ч төлөвлөсөн зүйл байхгүй. Энэ бичсэн үзэл баримтлал дээр нь Лондон улс хөдөө рүүгээ ингэж нүүлгэсэн, Солонгос улс хөдөө рүүгээ нүү ингэж нүүлгэсэн гэсэн хоёрхон жишээ. Тэгээд өөр юу ч байхгүй. Тэгээд өнгөрсөн 24 жилийн энэ 6 Засгийн газрын, 4 сонгуульд нь МАН ялсан. Тэгээд бүсчилсэн хөгжлийн баримтлалаар Монгол Улсын газрын зургийг нэг 5 өөр өнгөөр будаж л нэг зурсан, өөр хуруугаа ч хөдөлгөөгүй.

Тэгээд яг чуулган завсарлах гэж байхад гэнэт унтаж сэрсэн юм шиг Засгийн газрын гишүүд нь ч байхгүй, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг, мөн энэ төрийн байгууллагуудыг ингэж хуваана гэсэн ийм тогтоол баталж байгаа нь үнэхээр алийгаа алдаж байна, та нар. Бямбацогт сайд аа, уншихаасаа яахаараа ичдэггүй юм бэ, та нар. Яахаараа ийм хүний алиагаа алдчихсан юмыг ингээд уншаад сууж байдаг юм.

Би хариулт авахгүй шүү. Би үг хэлж байгаа юм. Одоо нэг баахан худлаа дэвэн дэлхийн юм яриад, ёстой нэг янзын гоё юм байгаа гээд ярих гэж байгаа юм. Би асуугаагүй. 2001 оноос хойш 24 жил хийж чадаагүй зүйлийг гэнэт чуулган завсарлах гэж байхад яаралтай горимоор оруулж авчраад тэгээд энэ үг нь байна, бүр тодорхой байгаа байхгүй юу. Та хэд чимээгүй байгаач.

Занданшатар даргыг ЗГХЭГ-ын дарга байхад хэлэлцүүлэг нь явчихсан гэж байхгүй юу. Тэр хэлэлцүүлгээ дүгнээгүй байж байж одоо ахиад бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсронгуй болгох форумыг бүсчилсэн байдлаар зохион байгуул гэнэ ээ. Саяын сонгуулийн тойргоороо явж та бүхэн маань ярих юмаа бэлд ээ. Мөнгийг нь Засгийн газраас гаргаж өг өө. Гарын авлагуудын төрийн байгууллага гаргаж өг өө л гэсэн тогтоол байна шүү дээ. Юун бүсчилсэн том нэр өгдөг юм бэ? Арай дэндэж байгаа юм биш үү? Та нар ер нь арай л дэндэж байна. Энэ ард түмэн та нарыг ингээд харж байгаа шүү дээ. Хууль тэр ч одоо бүр өнгөрч. Одоо бүр сонгуулийнхаа сурталчилгаа хийх удирдамжаа бүр Их Хурлаар батлуулж аваад, Засгийн газраар мөнгөө батлуулж аваад, ингээд бүр алийгаа алддаг болох нь л дээ. Арай дэндэж байгаа юм биш үү?

Тэгээд нөгөө оруулж байгаа ЗГ-ынх нь гишүүд байхгүй, дуртайгаараа Бямбацогт уншаад л, тэгээд л. Ямар хэрэг байдаг юм. Тэгээд асуухгүй шүү, би асуухгүй.

Г.Занданшатар: Тийм, оруулж байгаа гишүүн нь Борхүүгийн Дэлгэрсайхан сайд байна л даа. Хот хөдөөгийн сэргэлт гээд ард чинь. Энэ ажлын хэсэг бас дараа нь хариулж болно.

Сандагийн Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Батсуурь гишүүн ээ, би энэ ажлын хэсгийн гишүүн юм, бас. Дээрээс нь Засгийн газрын гишүүн. Тийм. Би бас Байнгын хорооноос ч, бас Байнгын хорооны ч гишүүн бас тийм. Ер нь яах вэ дээ, бас бүсийн нэмэгдэл, бүс нутгийн хөгжил гэдэг асуудлыг олон жил бас ярьсан юм. Тийм болохоороо таны бас, та мэдээлэл муутай байж магадгүй, хариулчихъя.

Тэгэхээр 2001 онд Монгол Улсын Их Хурал бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг баталсан, 57 дугаар

тогтоолоор. Бүсийн тулгуур төвүүдтэй болсон. Үүнээс хойш нэг их ажил хийгдэхгүй олон жил болсон, үнэн, үнэн.

Энэ асуудлыг шийдэх гээд бид нар 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид нар Монгол Улсын хөгжлийн бодлого нь төрийн бодлого нь урт, дунд, богино хугацаандаа уялдаатай байх, бүс нутаг бүрээрээ уялдаатай байх, салбар дундын зохицуулалттай уялдаатай байх асуудлыг Үндсэн хуульд хийсэн. Үүний дагуу бид нар энэ Үндсэн хуулийнхаа заалтыг хэрэгжүүлэх, Үндсэн хуулийн 25.1.7 дугаар заалтыг хэрэгжүүлэх гэж Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль баталсан. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульдаа бид нар бас тийм үү, урт хугацааны бодлого гэж үүнийг хэлнэ. Дунд хугацааны бодлого гэж үүнийг хэлнэ. Богино хугацааны бодлого гэж үүнийг хэлнэ. Энэ бодлогууд нь хоорондоо ингэж уялдана. Энэ дотроо Монгол Улсыг нэгдмэлээр харна. Дээрээс нь бүс нутгаар нь хөгжүүлнэ. Энд дунд хугацааны бодлогууд нь 10 жилийн хугацаатай байна, 10 жилийн хугацаатай бодлого дотроо бид нар бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлал, бүс нутгийн хөгжлийн бодлого гэж байна гэж оруулсан. Үүнийгээ хэрэгжүүлэх гээд яваад байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол яг үүнтэй холбоотойгоор бид нар Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль батлаад Алсын хараа 2050 гээд Монгол Улсын 2050 он хүртэлх урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан, Улсын Их Хурлаар. Засгийн газар өргөн бариад. Тухайн үед ЗГХЭГ-ын даргаар Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ ажиллаж байсан. Алсын хараа 2050-ыг санаачилсан. Ажлын хэсгийг нь би бас Их Хурал дээр ажиллаж, ахалж ажилласан юм.

Ингээд энд бид нар Алсын хараа 2050-даа 8 дугаар бүлэгт нь бүсчилсэн хөгжлийн асуудлыг нэлээн тусгаж өгсөн юм. Алсын хараа 2050 гээд энэ төрийн мэдээлэлд гарчихсан энэ ном байж байгаа. Энэ дээр та бас 8 дугаар зүйлийг

нь харах юм бол 8.1, 2, 3 гэсэн заалттай. Энэ дотор бүс нутгаа ингэж хөгжүүлж ээ гэсэн бодлого зорилт туссан. Үүнээс гадна бид нар энэ бодлогуудаа хэрэгжүүлэх гэж үндсэндээ Алсын хараа 2050, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, үүнийгээ хэрэгжүүлэх Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасан дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилт буюу бүсчилсэн хөгжлийн зорилтыг 10 жилийн хугацаатай батлах ёстой юм. Их Хурал. Үүнийг тун удахгүй Засгийн газар Их Хуралд өргөн барина. Ингэхийн тулд өнөөдөр Засгийн газраас Их Хурлаас чиглэл аваад бодлогоороо, тэгээд ингээд гишүүд тойрогтоо ажиллахдаа Засгийн газрын гишүүд ажиллахдаа ийм байдлаар ажиллавал яасан юм бэ гэдэг тогтоолыг оруулж ирээд энэ таны саяын уншдаг тогтоол. Энэ төрийн байгууллагыг бүсчлэн байршуулах тухай гэсэн тогтоол. Энэ тогтоолынхоо хүрээнд үндсэндээ судалгаанууд хийе ээ. Ингэж байгаад ирэх хаврын чуулганаар бид нар энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасан дунд хугацааны зорилт буюу бүсчилсэн хөгжлийн зорилтуудыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Бид нар Шинэ сэргэлтийн бодлого гээд бас дунд хугацааны хөтөлбөрөө бас баталчихсан шүү дээ. Яг үүнтэй адилхан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн зорилтоо Их Хурлаар батлуулах юм. Үүний бэлтгэл ... /минут дуусав/

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн тодруулж асууна.

Ж.Батсуурь: Бямбацогт минь, чи ёстой төрийн төлөө оготно боож үхнэ гэж юун ч балай балай юм ярьдаг юм бэ дээ. Энэ үзэл баримтлал дээр нь юу ч алга. Лондоны жишээ яв энэ хөлийн, ямар ч юм байхгүй. Тэгээд ингэж байх юм байна л даа. Явж байснаа тогтоол батлагдсанаар Улаанбаатар хотын төвлөрөл саарч, бүх юм сайхан болох юм гэнэ ээ. Тэгээд энэ тогтоолыг 24 жил баталж л байхгүй үлийгээ хийж байсан

юм. Тэгээд энэ дотор чинь ямар ч очиж ярилцах юм байхгүй. Өөрөө тэр бүс нутагт очоод, тэр танай аймагт, танай бүс нутагт ийм сургууль ирэх юм, танайд ийм үйлдвэр аж ахуйн газар ирэх юм гээд нэг өгүүлбэр ч байхгүй, нэг өгүүлбэр ч байхгүй. Тэгээд үүнийг тайлбарлаж байгаа нь ерөөсөө хаа хамаагүй, тэмээ гэх гээд ямаа гэж юм яриад байгаа байхгүй юу. Энэ дээр бичсэн батлах гэж байгаа 1, 2 гээд заа л даа, та нар. Энэ дээр чинь аль бүсчилсэн хөгжлийн бодлогыг сайжруулах гэж. Өмнө нь тавих юм байхгүй юм чинь ямар юмыг сайжруулах гэж байгаа юм. Хэлэлцүүлнэ гээд байгаа байхгүй юу. Өмнө ... /минут дуусав/

Г.Занданиатар: Нямаагийн Энхболд хариулна.

Н.Энхболд: Энэ гуравхан заалт байгаа юм, Батсуурь гишүүн ээ. Өглөө бид нар бас Байнгын хороо дээрээ нэлээн сайн ярьсан. Ямар учиртай, ямар тогтоол гарах гэж байгааг та бас мэдэж байгаа. Тэгэхдээ яах вэ, чуулганы индэр дээр бас зориулалтын ийм үгнүүдээр ярьж байх шиг байна л даа. Үүнийг ингээд хэлэлцэхгүй орхичихъё гэж бодъё. Тэгээд хэзээ хэлэлцэж эхлэх вэ? Энэ асуудлыг. Бид нар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Төрийн бодлого тогтвортой, залгамж уламжлалт чанараа хадгална гэсэн ийм заалт бүр Үндсэн хуульдаа оруулсан. Түүний дагуу сая Бямбацогт сайдын яриад байгаа нөгөө 2030, 2050 оны ерөнхий чиглэлүүд гарчихсан байж байгаа. Үүний л үргэлжлэл. Түүн дотор энэ зөвхөн яамд биш л дээ, энэ чинь. Дэд бүтцийн байгууллагууд, төрийн бусад байгууллагууд эд нарыг хөгжлийн шаардлагадаа нийцүүлээд бүсэд яаж хуваарилж байх вэ гэдгийг төрийн бодлогоор тогтооно гээд заачихсан байж байгаа. Түүний л үргэлжлэл явж байгаа.

Тэгээд энэ дээр ямар 3 санаа яг энэ тогтоол дээр байгаа вэ гэхээр 1 дүгээрт, энэ төрийн байгууллагуудыг онцлогуудыг нь харгалзаж үзээд Улаанбаатар хотоос шилжүүлж болох газруудыг нь үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх

бодлогоо боловсруул л гэж байгаа юм. Яг үнэнийг хэлэхэд таны сая хэлчихсэн тэр бэлэн байгаа юмнууд нь одоо байхгүй байгаа байхгүй юу. Байхгүй байгаа учраас та нар эхлээд энэ бодлогоо гарга. Үүнийг чинь дагаад энэ хүмүүс энд ажиллах хүмүүсийн асуудал гарч ирнэ ээ. Өнөөдөр нэг гишүүн маань Байнгын хорооны хурал дээр ярьж байна лээ. Жишээ нь нэг сургуулийг хөдөө шилжүүлж гэхэд тэнд ажиллаж байгаа хүмүүсийн 60 хувь нь явахгүй ээ гэж ийм санал өгсөн байна лээ гэж. Тэгээд тэр улсуудын асуудлыг шийдэх ёстой юу, ёстой.

Тэгэхээр 2 дахь заалт нь үүнийг дагаад гарч болох эрх зүйн, эдийн засгийн, нийгмийн асуудлуудыг яаж шийдвэрлэх юм. Тэр хуулиудаа боловсруулж оруулж ир ээ гэж байгаа юм, 2 дахь заалт нь.

3 дахь заалт нь. Тэд нарыгаа хийчхээд жил болгон тэрийгээ Их Хурлаар бат ... /минут дуусав/

Г.Занданиатар: Жамбын Батсуурь гишүүн тодруулж асууя.

Ж.Батсуурь: Энэ чинь хэдэн минут юм бэ? Нэг л минут. Үгүй ээ, яах вэ, энэ төрийн энэ нэр нь аягүй мундаг юм байгаа юм. Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай гэж байгаа юм. Тэгээд энэ дотор нь нэг ширхэг ч төрийн байгууллага тэр бүсэд очно, тэр аймагт очно гэсэн нэг ширхэг ч өгүүлбэр байхгүй. Лондонд тэрийг нүүлгэсэн, Сөүлд тэрийг нүүлгэсэн. Ингээд бүр баахан элий балай юм бичиж байгаа. Тэгээд дээрээ болонгуут маш том том тамгануудтай. Эдийн засгийн хөгжлийн яам, ХЗДХЯ, ЗГХЭГ. Тэгээд энэ сайд нар нь өөрсдөө байхгүй. Тэгээд үүнийг боож өгсөн, одоо ингээд явахад юу ярих юм. Хэлэлцүүлгээ хийчихсэн гэж байгаа. Тэгвэл өмнөх хэлэлцүүлгийг боогоод нэгтгээд тэрийг чинь энэ сургууль тэнд байна, энэ байгууллага тэнд очих боломжтой юм гэсэн дүр зураг нь ядаж гарсан байх ёстой шүү дээ. Огтоос юу ч байхгүй ийм зүйлийг удирдамж хийгээд, 21 ... /минут дуусав/

Г.Занданшатар: 86 Эрдэнэбаяр хариулъя. Одоо энэ мэргэжлийн улсууд хариулъя. Та нар буруу хариулаад байна. Танай асуудал.

Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр байна. 7 жилийн хугацаанд 3 удаагийн хэлэлцүүлгүүдийг бүх улс орон даяар бүх аймгуудаар хийсэн. 100 орчим эрдэмтэд ажилласан. Жайка ОУБ-аас бас Монгол Улсын Засгийн газарт ирэх 30 жилийн орон зайн төлөвлөлттэй холбоотой судалгаануудыг бүх салбараар гаргаж өгсөн байгаа.

Мөн Алсын хараа 2050 дээр нийслэлийн баримжаатай хөгжүүлэх шинэ Хархорин хотыг суурийг тавих ажлыг эхний 10 жилд хийх ийм үүрэг даалгавар өгөөд Үндэсний хороо байгуулагдаж, ажиллаж байгаа. Ингээд энэ урт хугацаанд төр, засгийн байгууллагуудыг үе шаттай нийслэлээс шинэ Хархорин руу шилжүүлэх ажил урт хугацаандаа явагдана. Мөн өмнөд, хойд хэришийг холбосон эдийн засгийн коридортой холбоотой боомт хотууд, түүний үзүүр дээр байгаа боомтуудыг тээвэр ложистик, хуурай боомт болгох, чөлөөт бүс болгохтой холбоотой бас төр, засгийн зарим байгууллагуудыг орон нутагт байгуулах асуудал энэ судалгааны хүрээнд гарч ирсэн байгаа.

Мөн их, дээд сургуулиудыг үе шаттайгаар инженер, технологийн сургууль болгох ийм тогтоолыг Улсын Их Хурлаас гаргасан. 2024 оны 01 сарын 01-нээс эхэлж байгаа. Өөрөөр хэлбэл орон нутагт байгаа МСҮТ, Политехникийн коллежийг инженер, технологийн койсын сургууль болгож хувиргахтай холбоотой зарим их, дээд сургуулийн салбарыг шил хэлжүүлжүүлэх ажлууд мөн хийгдэхээр судалгаанууд гарсан байгаа.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах хүрээнд бүх тэргүүлэх салбарын орон зайн төлөвлөлтийг гаргаж, Их Хурлаар

хэлэлцүүлэхэд бэлэн болсон байгаа. Засгийн газрын хурал дээр танилцуулга хийгдсэн. Одоо 02 сарын 01-нээс эхлээд бүх орон даяар эцсийн хэлэлцүүлгийг хийхээр ажлын хэсгээс төлөвлөсөн байгаа юм.

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Энэ бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох гээд нээрээ л бодлого тодорхойлох юм шиг, нэг ийм том гарчигтай л юм байна л даа. Энэ

Г.Занданшатар: Тэр чинь дараагийн тогтоол.

Ц.Туваан: Үгүй ээ, үгүй харин тийм. Уг нь энэ 2 асуудлаа эхлээд нөгөөдхөө хэлэлцчихсэн бол арай дээр байж уу гэж ингэж бодогдож байна. Тэгээд ер нь энэ бүсчилсэн хөгжлийн бодлого гээд юм тэр 2001 он гээд л тэр дунд нь зөндөө л юм гээд яриад байсан. Хэзээ үүнийг ер нь барьж байсан юм. Сайд сайд нь дур дураараа, гишүүн гишүүн нь дур дураараа л тэгээд л би мэднэ чи мэдэхгүй гээд л энэ Монгол Улсыг ер нь будаа болгосон шүү дээ. Нэг яам гарч ирээд, нэг сайд солигдонгуутаа нөгөөдхийнхөө 180 градусын эсрэг бодлого явчихдаг шүү дээ. Хэзээ энэ бүсчилсэн хөгжлийн бодлогын энэ бичиг баримт энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг ер нь хэрэгжүүлж, бодож, шийдвэр гаргаж байсан юм. Ийм юм байхгүй шүү дээ. Ингээд Монгол Улсыг өнөөдөр ийм замбараагүй, бодлогогүй, цогцгүй, ийм байдалтай болгоод хаячихсан шүү дээ. Тэгэхээр энэ бүсчилсэн хөгжлийн бодлого гэдэг дээр яах вэ, та хэд бол манай эрх баригчид арай өөр юм бодож баталсан. Түүнийг чинь ард түмэн мэдэж байгаа. Сонгууль бодож энэ тойрог баталсан. Тэгээд 1 юм баталчихсан юм чинь түүнийхээ араас бас нэг юм хийх ёстой гээд ингээд форум ч гэх шиг ингээд тэр дотор нь байна л даа, ерөөсөө очиж нэг юм хийсэн нэр зааж бас нэг бид нар үүний бодлоготой энэ тэр гэж нэг юм харуулах

л юм байж байна шүү дээ, энэ чинь. Ямар бид нар анх удаагаа энэ юмыг чинь үзэж байгаа юм биш.

Яах вэ, тэгэхдээ энэ дээр юу гэдэг юм АН-ын тухайд бол бүсчилсэн хөгжлийн бүр бодлоготой. Энэ талаар зөндөө ярьдаг. Монгол Улсыг бүр босоогоор нь 4 том нэг аймаг гээд ингээд бүсчилж хөгжүүлье ээ гэдэг бүрэн бодлогын бичиг баримтуудтай, саналуудтай. Та хэд хэрвээ олон удаа суусан хүмүүс байдаг байх, тэрийгээ бүгд мэдэж байгаа байх. Манайхыг бас нэг юу ч үгүй энэ нөхөд бодлого байхгүй, ингээд нэг томоор баталчихвал тэгнэ ингэнэ гэж бодож байвал бас эндүүрэл. Тэгэхээр энэ бид нар нэг эхлээд том бодлогоо гаргаагүй, өнгөрсөн нийгмийг бид нар шүүмжилдэг, ялангуяа манайхан шүүмжилдэг. Тэгэхдээ тэнд чинь энэ системийн бодлого байсан юм. Тэнд чинь бодлогоо гаргачхаад тэрэндээ зохицуулаад зориулаад хуулиа баталчихдаг байсан юм. Дараагаар нь тэр стратеги төлөвлөгөөгөө боловсруулаад том том хөтөлбөрөө 5, 5 жилээр төлөвлөчихдөг юмнууд байсан юм байна лээ.

Одоо манай энэ үед ялангуяа сүүлийн үед энэ эрх баригчид 8 дахь жилдээ дараалан засаг барьж байгаа үед ямар бодлого явсан юм, ер нь. Би л лав мэдэхгүй юм байна. Тэгээд энэ дур дураараа сайдууд нь бүс бүсийн, дур дураараа өөрийнхөө тойрогтоо дахин сонгогдох гэж бодсон юмныхаа төлөө янз бүрийн юм хийсээр байгаад энэ улс орныг чинь будаа болгочихлоо шүү дээ. Тэгээд салбарын сайдууд нь, яг тэр салбар салбартаа хийх бодлогуудаа яг хамгаалаад яриад, ингээд засаг дээрээ яриад, Их Хуралтайгаа яриад авч яваагүйгээс Монгол Улс чинь нэг тийм бодлогогүй, цогц юм нэг ч байхгүй ийм л задгай болчихлоо шүү дээ. Тэгээд тэр төсөл, тэр юунуудаа салбарууд нь төсөл төслүүдээ гаргаж ирээд, яг энэ нэг уялдаатай үүнийгээ нэг ийм, нэг улс шиг ингээд хийгээгүйгээс болж энэ асуудлууд гарсан гэж би хувьдаа үздэг.

Тэгэхээр нэгэнтээ яах вэ, энэ төр байна. Бас юмаа баталчихсан учраас энэ рүүгээ бас бид нар явах байх. Тэгээд энэ дээр харин тэр 2 асуудлын дарааллыг нь оруулаад одоо энэ бүсчилсэн хөгжлийн бодлогоо ярих энэ янз бүрийн асуудлууд байвал тэр ажлын хэсэг байдаг юм уу, өшөө шийдвэр гаргах түвшинд нь энэ эрх барилцаж байгаа Их Хуралд суудалтай энэ намуудаасаа оруул ... /минут дуусав/

Г.Занданшатар: Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Тэр түрүүн Батсуурь гишүүнээс асуухгүй гэсэн асуултад хариулчихъя. Монгол Улсын Их Хурал бол төрийн бодлого тодорхойлдог, хууль тогтоох дээд байгууллага, төрийн эрх барих, хууль тогтоох, бодлого тогтоох дээд байгууллага. Энэ үүднээсээ тийм үү, энэ бүсчилж яаж улс орноо хөгжүүлэх вэ. Төрийн байгууллагууд бүсчилж яаж байршуулах вэ гэдэг чиглэл зөвшөөрлөө Улсын Их Хурлаас авах гэж Засгийн газар оруулж ирж байгаа юм. Ингээд та бүхэн Улсын Их Хурал батлаад, зөвшөөрөөд өгсний дараа хаана ямар төрийн байгууллагуудыг яаж, хэзээ шилжүүлж болох вэ. Ямар их, дээд сургуулийг хааш нь байрлуулж болох вэ. Ямар төрийн өмчит компаниудыг хааш нь байрлуулж болох вэ гэдэг юман дээр тодорхой судалгаа, тооцоо хийгээд буцаагаад Их Хуралд оруулж ирээд ингээд явах юм. Энэ агуулгаараа үндсэндээ Их Хурлаас зөвшөөрөл авах гээд л тийм үү, тогтоол оруулж ирж байгаа.

Туваан гишүүний асуултад хариулъя. Таны ярьж байгаа бас зөв өө, тийм. Ер нь Монгол төрийн бодлого тодорхой биш, тогтвортой биш, ялсан нам болгон өөр өөрсдийн бодлого явуулдаг байсан. Тэгээд л нэг нөхөр нь зүүн тийшээ харсан байшин барина гэхэд нөгөө нам нь ялангуутаа үгүй ээ, баруун тийшээ харсан байшин барина гээд л. Нэг нь 5 давхар байшин барина гэхэд нөгөөдөх нь үгүй ээ, 3 давхар байшин барина гээд л ингэж ирсэн. Үүнийг шийдэх гэж бид нар 19 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн.

Төрийн бодлого тодорхой байх ёстой, тогтвортой байх ёстой, харилцан уялдаатай байх ёстой. Ингэхийн тулд бид нар Хөгжлийн бодлого, төлөвлөлтийнхөө хуулийг баталсан. Төрийн бодлого урт, дунд, богино хугацаандаа уялдаатай байна. Үүнийг аль ч нам ялсан хэн ч Ерөнхий сайд болсон өөрчлөхгүй байх ёстой гэж. Үүндээ нийцүүлэн бид нар урт хугацааны бодлоготой болсон. Алсын хараа 2050. Энэ дээр үндсэндээ урт хугацааны бодлого маань тодорхой болчихсон. Дунд хугацааны бодлого буюу бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг бид нар 10 жилийн хугацаатай батлах ёстой юм. Үүнийгээ батлах гээд явж байгаа юм, батлах гээд. Ингэхдээ бүс нутгаа яаж хөгжүүлэх вэ? Одоо тухайлах юм бол би Ховд аймгаас сонгогдсон, сонгогдсон цагаас хойш бүсийн нэмэгдэл ярьсан.

Яагаад гэвэл Улаанбаатар хотоос алслагдах тусмаа ард иргэдийн орлого нь багасдаг. Нөгөө орлого гэхээр мах нь хямдхан, арьс нь хямдхан, ноос нь хямдхан, ноолуур нь хямдхан, төмс хүнсний ногоон нь хямдхан, орлого багатай. Зардал өндөр, бензин шатахуун өндөр, гурил, будаа өндөр, эрчим хүч өндөр, нөгөө элсэн сахар өндөр, нөгөө даавуу, даалимба нь өндөр. Яагаад гэвэл Улаанбаатараас алслагдах тусам тээврийн зардал нэмэгддэг. Ийм байдлаараа орлого багатай, зардал өндөртэй. Үүнээсээ болоод ганцхан Улаанбаатар гэсэн бүс рүү бүх тийм үү, 21 аймгаас ганцхан таталцлын төвтэй болчихсон. Үүнийг л тийм олон таталцлын төвтэй болгоё. Ингэхийн тулд тийм үү, тэр бүс нутаг бүрдээ нутагтаа сайхан амьдрах бололцоо боломжийг бий болгоё гэдэг үүднээс бид нар бүсийн нэмэгдэл, бүсийн хөнгөлөлт ярьж байсан. Одоо харин ингээд үндсэндээ бүс нутаг нь бүр нэг тойрог болж байгаа. Энэ маш том алхам.

Урьд нь Их Хурлын гишүүд зөвхөн өөрийнхөө сумыг, зөвхөн өөрийнхөө аймгийг боддог байсан. Сум болгондоо сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв,

спорт заал бүгдийг нь бариад дууссан. Одоо харин бид нар бүс нутгаа хөгжүүлэх, бүс нутгийн эдийн засаг тийм үү, томоохон таталцлын төвүүдийг бий болгох, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтэц, эдийн засгаа тэлэх, томруулах ийм л юманд анхаармаар байгаа юм л даа. Энэ рүү чиглэсэн бодлогыг харин нэгдээд нийлээд явуулъя. Ингэхийн тулд тойрог ч ингээд томорч байгаа, бүс нутаг болж байгаа юм чинь. Энэ рүү чиглээд тэр бүс нутаг бүр тэр зүүн бүсэд манай Батсуурь гишүүн ямар таталцлын төвүүд бий болгох юм. Яаж аялал жуулчлалаа, газар тариалангаа өшөө МАА хөгжүүлэх ... /минут дуусав/

Г.Занданиатар: Туваан гишүүн тодруулж асууя.

Ц.Туваан: Концепц дээрээ тэр бас алдаагаа ухаарч байгаа юм байна. Тэгээд энэ дээр уг нь 2001 оноос хойш зөндөө хийчихсэн байх цагууд байсан. Хийчихсэн юм байгаа байлгүй дээ. Тэгэхдээ ер нь манайд цаас багадаагүй ээ. Цаас багадаагүй, бодитойгоор хийдэггүй. 1 нэгнийхээ юмыг бусниулдгийн жишээ бэлхэн байгаа. Дарханы арьс ширний цогцолбор гээд байна. Нэг сайд солигдоод юу боллоо, бид нар бүгдээрээ мэдэж байгаа, зогсоогоод л хаячихсан. Дагаад Монгол Улсын мал аж ахуйн салбарын малчдын бүтээж өгсөн тэр арьс шир ямар ч үнэгүй хог болох энэ юмыг л хийчхээд сууж байгаа байхгүй юу. Дарханы зам байна, шаардлагагүй замыг шууд ороод л нурааж хаяад л, дахиад л хажуугаар нь тавьж байх жишээтэй. Тэгэхээр иймэрхүү юмнууд бодлогогүй юмнууд байгаа юм. Тэгэхээр ер нь бид нар нэг нэг Монгол Улс юм бол бас энэ дээрээ нэг тийм одоо юу гэдэг юм, цогц бодлогоо гаргаж байгаад 24 онд бүсээс сонгогдсон гишүүд нь голчилж хийх байлгүй дээ, тэгээд цаашидаа ... /минут дуусав/

Г.Занданиатар: Үг хэлчихлээ. Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр бид бүсчилсэн хөгжлийн тухай

асуудлыг нэг ч их сэрээд ярьчихаж байгаа ч зүйл биш л дээ. Нэлээдгүй олон жилийн өмнө бүсчилсэн хөгжлийн амин сүнсийг бас судалж тооцоод, үзэл баримтлалаа гаргаад, бодлого чиглэлээ тодорхойлоод, хууль, эрх зүйн орчин бүрдүүлээд, энэ хүрээнд зүгээр дан ганц цаас үйлдвэрлээгүй л дээ. Тодорхой бас баялаг бүтээх салбаруудын байр зүй, нийгэм, соёлын үйлчилгээний байр зүйнүүд, бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдээс авхуулаад хийгдсэн юмнууд бий. Зүгээр явц дунд удааширсан юмнууд байгаад байгаа. Үүнийгээ сэргээх ёстой. Сэргээх ёстой гэдгийг өдөр болгон илүүтэй тод харуулаад байгаа, бидэнд. Ганц таталцлын төвтэй хөгжлийн энэ бодлого загвараас олон таталцалтай хөгжлийн загвар бодлого руу явахгүй бол нэг газраа бүх хундрэлийг авчирдаг. Нэг хэсэг газраа эзгүйрэл гэдэг юм уу хөгжлийн доройтлыг бий болгодог юм байна.

Тийм учраас энэ улс орныг бас тогтвортой хөгжлийг хангана гэвэл хот, хөдөөгийн хөгжлийг тэнцвэржүүлэх тухай асуудал байх юм байна. Ингэж байж тухайн бүс нутагт амьдарч байгаа иргэд олон түмэнд үзүүлэх ёстой үйлчилгээнүүд нь ч тэр, эдийн засгийн идэвхжил нь ч тэр, амьдралын чанар нь ч тэр жигд өсөх ёстой юм байна гэж ингэж л үзэж байгаа. Тийм учраас би харин энэ тогтоолоор өмнө нь батлаад гаргачихсан тэр үзэл баримтлал, бодлого чиглэл, хууль тогтоомжуудынхаа хэрэгжилтэд нэлээн бодитой үнэлэлт дүгнэлт өгөөд, энэ цаг үед тавигдаж байгаа шаардлага юмандаа нийцүүлээд, суурь судалгаа юмнуудаа нэлээн нарийсгаж хийгээд энэ үзэл баримтлал, бодлого, эрх зүйн зохицуулалтаа боловсронгуй болгох асуудлаа оруулж ирэх тухай асуудал чиглэлийг нь хэлэх ёстой. Энэ тогтоолоор, 1.

2 дахь зүйл нь үүнийгээ дагуулж төрийн байгууллагуудын байршлын асуудлууд нь илүү тодорхой гарч ирэх ёстой. Хаанаа ямар төрийн байгууллагууд нь очиж байрших ёстой юм. Энэ бүх зүйлүүд чинь өөрөө их тодорхой болж

гарах ёстой. Үүнийг илүү бодитой амилуулахын гол асуудал нь энэ жилийн энэ Их Хурлын сонгуулийн буюу энэ төрийн эрх барих дээд байгууллагынх нь сонгуулийн тойргийн ерөнхий зураглал хийгдлээ гэж ингэж ойлгож байгаа. Ингэж ойлгож байгаа бол цаашид бид энэ төлөвлөлтийнхөө асуудлыг бас энэ бүсчилсэн төлөвлөлтийнхөө асуудлаар явдаг л байх ёстой. Дан ганц нэгжийн төлөвлөлтөөр биш энэ бүсчлэлийн төлөвлөлтөөр давхар явдаг ийм л зарчим руу шилжиж байж энэ бүс нутгууд чинь өөрсдөө тэнцвэртэй хөгжих ийм бололцоо боломж нь бүрдэнэ, 1.

2 дугаарт, мэдээж одоо байж байгаа энэ сум, суурин газруудын хөгжлийг бас чадамжуулахын тулд энэ кластер хөгжлийнхөө асуудлыг энэ бүсчлэлийнхээ ерөнхий бодлого зураглал дотроо багтааж оруулах ёстой юм. Хаанаа анхан шатын боловсруулалттай, хаанаа дунд шатын боловсруулалттай, хаанаа эцсийн шатын боловсруулалттай байх юм, энэ нь яаж хоорондоо холбогдох юм. Энэ эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээнүүд нь ч гэсэн тэр хаанаа ямар үйлчилгээний стандарттай байх ёстой вэ. Тэр нь хоорондоо яаж уялдах ёстой вэ. Сая ингэж л байж энэ улс орон энэ бүсчилсэн хөгжлийнхөө загвараар богино хугацаанд арай ахиу хурдан хөгжчих ийм бололцоо боломж нь бүрдэнэ. Угаасаа бидэнд нөөц ... /минут дуусав/

Г.Занданишатар: Үг хэллээ. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Оруулж ирсэн энэ тогтоолын төслийг бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Үнэхээр Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого гээд одоогоос 2 жилийн өмнө ярихад бас нөгөө Монгол цаас мундаагүй байгаа, хөтөлбөр мундаагүй байгаа гэдэг шиг эргэлзэж байсан хүмүүс олон байсан бол өнөөдөр 2 жилийн дараа үнэхээр энэ Алсын хараа 2050 цаашаа хэрэгжээд явах юм байна. Энэ Шинэ сэргэлтийн бодлого гэдэг зүйл хэрэгжээд явах юм байна. Эхнээсээ үр дүн гарч байна. Иргэд олон нийт бас энэ дээр

их бодитой дүгнэлтүүд хийдэг болсон байна, Тэгээд яг энэ цаг үед энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, хэдхэн хоногийн өмнө баталсан энэ Улсын Их Хурлын сонгуулийн тойрог томсгосон энэ бүх зүйлүүд тэртээ 2001 он, би 20 настай байсан тэр цаг үед батлагдсан энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гэдэг зүйл сэргэх юм байна, ажил хэрэг болох юм байна гэдгийн бас нэг том дохио болж байгаа гэж ингэж бас бодож байгаа юм.

Үнэхээр бид нар 2001 онд баталсан тэр үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал ч хэвээрээ л байж байгаа шүү дээ. Гэхдээ яг амьдрал дээр яадаг вэ гэхээр манай зүүн 3 аймгаар бодоход зүүн 3 аймгийн бүсийн зөвлөгөөн гэж жилдээ нэг хийдэг. Хүн гаднаас нь харахад их л том хурал болж байгаа бололтой. Яг дотор нь ороод сууж байгаа хүний хувьд бидний энэ ярьж байгаа юм ер нь хэзээ ажил хэрэг болох юм бол доо гэж бодохоор зүйлүүд дунд явж ирсэн. Ийм л түүхтэй. Дорнод аймаг Зүүн бүсийн төв, Хэнтий аймаг Тулгуур төв гээд л ингээд л ярилцаад 20 жил болчихсон. Тийм учраас өнөөдөр харин энэ хэрэгжихгүй байсан олон том энэ хөтөлбөр, төслүүд хэрэгжээд өнөөдөр зүүн бүс ер нь бүсээ ярьдаг болж байгаа энэ цаг үед ингээд дагуулаад бас ийм тогтоол орж ирээд, эндээс би нэлээн юмнууд бас тодорхой болох юм байна гэдэг дээр бас тэр тухайн бүсийг бас бүсийн нэг аймгийг хариуцаж байсан хүний хувьд баяртай байгаа. Бид ингэж байж л цаашаа хөгжил ярихгүй бол болохгүй.

Тэгээд би үүнээс цаашаагаа дахиад энэ төсвийн бодлого ч гэсэн энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал руугаа бас чиглэгдэх ёстой гэж ингэж бас боддог. Ийм хүний нэг байгаа юм. Тэгэхээр энэ дээр ингээд судалгаа юмнууд хийгдэх нь байна. Төрийн байгууллагууд орон нутаг руу шилжих нь байна. Тэнд ажиллах төрийн албан хаагчдын нийгэм, соёлын асуудлуудыг, нийгмийн хамгааллын асуудлуудыг шийдэх юм байна. Энэ хэрээрээ тухайн бүс нутгийн эдийн засгийн эрчимжилт сэргэнэ. Үгүй ээ, олон

зэрэг талууд байгаа. Тийм учраас үүнийг дэмжиж байгаа гэдгээ би хэлэх гэж зориуд үг авсан юм.

Дээрээс нь энэ төрийн байгууллагууд гэдэг дээр зөвхөн төрийн захиргааны байгууллагуудаас гадна энэ шинжлэх ухаан, энэ боловсролын байгууллагууд ч гэсэн энд би хамрагдах болов уу гэж ингэж бодож байгаа юм. Энэ Улаанбаатараар дүүрэн энэ их, дээд сургуулиудыг энэ аймгууд руу шилжүүлээсэй. Бас л олон жил ярьж байгаа. Энэ зүүн бүсүүд рүү шилжих сургуулиуд нь шилжээсэй. Жишээ нь яагаад бас тэнд шилжсэн сургууль хөгжихгүй байгаагийн шалтгааныг бас зөв тодорхойлоосой. Сүхбаатар аймаг ШУТИС-тай байсан, харамсалтай нь хаагдчихсан байгаа. Юунаас болж хаагдав, эргээд шилжүүлэхэд тэнд тэр сургууль дахиад байгуулагдах бололцоо бий юу гэдгийг бодитой бас дүгнээсэй. Ийм нэг эхлэлүүд тавигдаж байгаад бас баяртай байна.

Тэгээд энэ дээр Хэрэг эрхлэхийн газар энэ саяын бас хэлсэн зүйлүүд дээр бас анхаарлаа хандуулаасай гэж ингэж бас бодож байгаа гэдгээ бас хэлж байгаа юм. Дэмжиж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн үг хэллээ.

Одоо санал хураалт явуулна. Одоо тэгээд их ярих тусмаа ер нь тэгээд л хамгийн гол нь нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулья гэж түгжрэлийн сайдаа оруулж ирж байгаад л түгжрэл бууруулах гэж л энэ хотоос төрийн байгууллагуудаа гаргая гэж байгаа л ийм утгатай. Тэгээд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гээд л ингээд л томруулаад л түүнийгээ боловсруулаад, ахиж хянаж үзээд дахиад боловсруулахад том асуудал.

Ингээд бага ярьж, их хиймээр байна. Ингээд санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

53,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

15.37 цаг

Дараагийн асуудалд оръё.

“Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт танилцуулна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын эдийн засгийн бүсчлэлийн бүс нутаг, хот, хөдөөгийн хөгжлийн нэгдмэл болон бүсүүдийн харьцангуй бие даасан харилцан уялдаатай тогтолцоог бүрдүүлж, бүс нутаг, хот, хөдөөг тэнцвэртэй хөгжүүлэх, хүн амын нутагшил, суурьшлын олон төвтэй тогтолцоог бий болгох, нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, иргэдийн орон нутагт шилжин суурьших таатай нөхцөлийг хангах зорилгоор Улсын Их Хурлаас баталсан бодлого, хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд тайлбарлан таниулах, иргэдээс санал авах, байр суурийг нь сонсох ажлыг зохион байгуулахтай холбогдуулан “Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний

тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг заасныг баримтлан боловсруулж, Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулж байна.

Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үндэслэл, үзэл санаа, төрийн зохицуулалтын хүрээнд хэрэгжүүлэх зорилтуудыг тодорхойлон хэрэгжүүлэх үе шатыг тус тусан баталсан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод бүс, орон нутаг, нийслэл Улаанбаатар хот болон дагуул хотыг хөгжүүлэх, мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан Шинэ сэргэлтийн бодлогод боомтын болон хот хөдөөгийн сэргэлтийн зорилтуудыг тусган хэрэгжүүлж байна.

Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогод тусган хэрэгжүүлж байгаа бүсчилсэн хөгжлийн зорилтууд түүний хэрэгжилтийг иргэдэд тайлбарлан таниулж, иргэдийн санал, байр суурийг сонсож, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Тогтоолын төсөлд Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы завсарлагааны хугацаанд бүсчилсэн хөгжлийн талаарх бодлого, хууль тогтоомжийг иргэд, од, олон нийтэд тайлбарлан таниулах, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулахыг Улсын Их Хурлын гишүүдэд

даалгах, мөн түүнчлэн бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсронгуй болгох, Монгол Улсын эдийн засгийн бүсчлэлийг тогтоох асуудлаар эдийн засгийн форумыг бүсчлэн зохион байгуулах, холбогдох бодлого, хууль тогтоомж тогтоолын хэрэгжилтийн талаарх шаардлагатай мэдээллээр хангах арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгах зохицуулалтыг тусгасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт, санал гараагүй болно.

“Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж, өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Саналыг хүлээж авлаа. Тэгээд санал хураалтад орчихъё.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн алга байна. Цэвэгдоржийн Туваан гишүүнээр тасаллаа. Жамбын Батсуурь гишүүнээр тасаллаа. Жамбын Батсуурь гишүүнээр тасаллаа. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээ гээд. Тэгээд яах вэ, ер нь олон хууль, дүрэм, цаас 2001 оны тэгээд энэ юмнуудаа ярьж байна л даа. Тэгээд яах вэ,

энэ тогтоолын юунууд нь ирчихсэн байна. Заалтуудтайгаа ирчихсэн байна. Тэгээд аль 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явц гээд. Тэгээд энэ дээр нэг ийм зөрчилдөөнтэй юмнууд байгаад байна. Нэг ингээд харахаар нэг их аймаар бүсчилсэн хөгжлийн бодлоготой, түүнийхээ явцыг нь үзэх гээд байгаа ч юм шиг, нэг болохоор ямар ч бодлогогүй, түүндээ санал авах гээд байгаа ч юм шиг. Тэгээд ер нь шулуухан хэлэхэд чуулганы завсарлагааны хуралдаанаар нөгөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр санал авах гэдэг шиг нэг тиймэрхүү рекламны маягийн юм хийхээр гишүүд очих нэг иймэрхүү юмнууд л харагдаад байна л даа.

Тэгэхээр энэ дээр бас энэ ажлын хэсэг ер нь яг энэ хэрэгжилтийн явцыг авна гэж явчхаад тусгуулах юм авна, энэ тэр гээд байгаа. Энэ зөрчилдөөн байна уу, эс үгүй бол би буруу ойлгоод байна уу гэдэг дээр нэг хариулт авчихмаар байна.

2 дугаарт нь, энэ тайланг гаргуулж, 01 сарын 25-ны дотор бэлтгэх ажлыг ингээд бас даалгачихсан л юм байна. Гарын авлага, тайлан, лавлагаа, бусад мэдээллийг гээд. Энэ дээрээ АН-ын бүлгээс юугаа аваарай, санаа оноонуудыг нь аваарай. Яагаад вэ гэхээр бас энэ дээр бид нарт чинь бодсон, төлөвлөчихсөн бас засаг барьж байсан үеийн янз бүрийн юмнууд байгаа. Тэгэхээр тэр санаа оноонуудаа бас бүлгээс нь оруулаад яваарай гэсэн ийм бодлого юу зүйлийг бас энэ микрофонд хэлчихье.

Дараагийн нэг асуудал нь энэ төвийн бүс дээр ярьж л даа. Би энэ Дархан, Сэлэнгэ, Төв аймгийн бүсийг төвийн бүс гэж байгаа юм. Нэр яриад байхгүй ч гэсэн төвийн бүс гээд. Монголчуудыг хоосон хонох уу, хоолтой хонох уу, хөнгөн үйлдвэрүүдийг ажиллах, түүхий эдтэй байх уу гэдгийг шийдэх, бусад бүс нутгуудаасаа онцгой хөгжих дэд бүтцүүд нь бэлэн байгаа ийм бүс юм байгаа юм. Хажуу талынхаа энэ Орхон, Булган, Хөвсгөл аймагтай нийлээд ингээд нэг цогц

бодлого болгоод явахад Монгол Улсын нэлээн асуудлуудыг энд ярьчих боломж байгаа. Тэгэхээр энэ дээр байгаа тэр гарын авлага энэ тэртээ оруулах материал энэ тэр дээрээ бид нарт бас наана нь батлахаасаа өмнө бүлэг рүү хийгээд, цааснуудаа явуулчихвал бид нар бас нэг харчихмаар байна. Тийм.

Тэгээд ер нь энэ бүсчилсэн хөгжлийн бодлогыг дэмжиж байгаа. АН-ын саяын Улсын Их Хурлын тогтоолыг ч гэсэн АН-ынхан бүрэн нам дээрээ ч тэр, бүлэг дээрээ ч тэр дэмжээд явсан. Энэ бол Монгол Улсын эрх ашиг юм байгаа юм. Одоо бид нарын яриад байдаг нөгөө жалга довын гэдэг эрх ашгаасаа нэг алхам холдсон, улс орноо бодсон ийм шийдвэр гэж харж байгаа учраас манай намынхан энэ асуудлыг бүрэн дэмжиж байгаа. Тэгэхээр энэ дээр ажлын хэсэг тэр бэлдэж байгаа газрууд Засгийн газар бас анхаараад энэ асуудал дээр бид нарыг оролцуулаад нэг л Монгол Улсынхаа төлөө бодлого учраас энэ асуудлуудаа яриад яваарай. Бид нарт бэлэн бүх зураглалууд нь, бүх тооцооллууд нь янз янзын байдлаараа байгаа. Авто зам нь яаж явах юм, үйлдвэрүүд нь хаанаа байх юм, төмөр зам нь яаж явах юм бүх бодлогууд байгаа шүү гэдгийг бас микрофонд хэлчихье. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэлчихлээ. Жамбын Батсуурь гишүүн. Асуулт, үг нэг явж байгаа. Асуулт үг 2 нэг явж байгаа. Тэгээд санал хэлчихье. Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг ер нь дэмжиж байгаа. Гэхдээ энэ чинь анхан 2001 оноос эхэлсэн энэ 24 жилийн хугацаанд хийсэн ажил байхгүй, бэлэн биш байгаа гэдэг нь энэ орж ирж байгаа төслөө л харагдаж байгаа юм л даа. Би түүнд л харамсаад байгаа юм. Яг үнэндээ энэ тогтоолын үзэл баримтлал гэхэд энд ойлгомжтой нэг үг үсэг ч байхгүй. Зүгээр Лондонгоос хөдөө тэгж нүүлгэсэн, Сөүлээс тэгж нүүлгэсэн гэсэн 2 жишигээр бүсчилсэн хөгжлийг л ярьж

байгаа байхгүй юу. Асуудал нь түүндээ л байгаа юм. Гэтэл яг бодит нөхцөл бол энэ Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлнэ гэдэг энэ том бичиг баримт. Энд 3 тамгыг харсан ч гэсэн ЗГХЭГ, ХЗДХЯ, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд гээд ингээд баталсан 3 тамга, зүгээр л 2 жишээн дээр тавигдаад л, зүгээр нэг хөдөө явж байгаа ажлын удирдамж шиг юм орж ирж байгаа байхгүй юу. Үүнийг гишүүд нээрээ анхаараач.

Дараа нь, одоо бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын Их Хурлын тогтоолыг үзье ээ гэхэд энэ дотроос үзэх нэг үг үсэг ч байхгүй. Ийм алийгаа алдсан юм хийж байгаа байхгүй юу. Дээр нь та бүхний ярьж байгаа зүйлүүд зөрөөд байгаа юм л даа. Өмнө нь орон даяар бүсчилсэн хөгжлийн хэлэлцүүлэг хийсэн гэж байгаа юм. Занданшатар даргыг ЗГХЭГ-ын дарга байхад Монгол Улс даяар энэ хэлэлцүүлгийг хийчихсэн. Хэрвээ хийсэн бол түүний үр дүн, дүгнэлт, санаа оноо чинь орж ирж байх ёстой юм байгаа юм биш үү. Гэтэл, гэтэл дахиад хэлэлцүүлэе гэж байгаа юм. Энэ чинь тоглоом юм уу, шоглоом юм уу. Тэгэхээр энэ чинь өөрөө яг хаягаас нь харсан ч гэсэн энэ тогтоолын чинь агуулга нь Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх асар том юм ярьж байхад энэ дотор нь ямар нэгэн санаа оноо байхгүй, зүгээр гарын авлага аваад, чуулганы завсарлагаанаар бүсүүд дээр очих гишүүдийн сурталчилгааг Засгийн газраар мөнгийг нь гаргуулъя гэж байгаатай бараг л тэгээд биччихсэн тогтоол байгаа байхгүй юу, энэ чинь өөрөө. Тэгээд үүнийгээ та нар тайлбарлаж чадахгүй. Тэгээд өөр тайлбарлах ч хүн байхгүй. Тэгээд Бямбацогт ёстой нүдээ аниад л дайраад байгаа байхгүй юу. Тийм.

Тэгэхээр асуудлыг ингэж хандаж болохгүй л дээ. Их Хурлын тогтоол, Их хурлын хууль дүрэм гэдэг чинь бид нар нэлээд углуургатай, олон үе шаттай ингэж явдаг шүү дээ. Тэгэхээр хориод жил хийгдээгүй зүйлийг гэнэт яаралтай горимоор орж ирж байна шүү дээ.

Яагаад. 20 жил хийгээгүй юм яагаад яаралтай шугамаар орж ирж байгаа юм? Байж бай л даа, та нарыг ярихад чинь бид нар дуугардаггүй шүү дээ. Энэ хааяа нэг юм хэлэнгүүт л тэгээд бүгдээрээ барьж идчих гээд байгаа юм.

Үгүй ээ, өөр юм ярьсан, би өөр юу ярьсан юм. Үгүй ээ, үгүй тэгэхээр. Яагаад цаг дуусаж байдаг юм, дуусаагүй шүү дээ.

Харин одоо энэ бүсчилсэн би ард түмэнд уриалах гэж байгаа юм. Бүсчилсэн хөгжил яриад очиход нь ногоон автобусыг нь сайн асуугаарай. Хөгжлийн банкиг нь сайн асуугаарай, нүүрсний хулгайг нь сайн асуугаарай. Тэгээд бүсчилсэн хөгжил, ярих юм байхгүй наадуул чинь, байхгүй юм чинь. Тэгээд ер нь зүгээр ярих повод гаргах гэж ... /минут дуусав/

Г.Занданшатар: Та бүр. Одоо ингээд улс төржүүлж яриад хэрэггүй ээ. Та 7 минут ярьсан. Энэ төрийн албан хаагчид хариулаг, та нар ингээд. 86 энэ ажлын хэсгээс хариулчихъя. 86.

Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр хариулъя.

Судалгаа бол өнгөрсөн 7 жилийн хугацаанд нэлээн ул суурьтайгаар олон төрлийн суурь болон судалгаанууд хийгдсэн. Тэгээд хэлэлцүүлгийг бид нар 21 аймагт хийсэн. Хууль дээр орон нутгийн саналд үндэслэж боловсруулах ёстой гэсэн учраас эхлээд бид нар 21 аймгаар хэлэлцүүлэг хийсэн. Одоо бол илүү яамдыгаа оролцуулсан, эрдэмтдээ оролцуулсан, улс төрийн төлөөллийг оролцуулсан ийм хэлэлцүүлэг хийхээр Засгийн газраас шийдсэн. 2024 оныг “Засгийн газраас бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгож зарласан байгаа.

2001 онд батлагдсан үзэл баримтлал бол онолын хувьд нэлээд өөр болсон гэдгийг та бүхэнд бас онцолж хэлэхийг хүсэж байна. Яагаад гэхээр илүү нөөцөө дагасан ийм төлөвлөлтүүдийг

явах ийм олон улсын онолын чиг хандлагууд гарсан. Бид нар говийн бүсэд говийн бүсээ дагасан ийм төлөвлөлтүүдийг хийх, аялал жуулчлалын бүсээ гаргаж байж аялал жуулчлалын бүсэд нь тохирсон төлөвлөлтүүд хийх, ийм суурь судалгаануудыг хийгээд Алсын хараа 2050 батлагдах үеэр бид нар Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан энэ хувилбар дээр бүсчлэл байгаа гэдгийг бас энд хэлэхийг хүсэж байна. Та бүгд бас өргөн барьсан хувилбар дээрээс энэ бүсчлэлийн схемийг харах боломжтой. Энэ бүсчлэлийн схем маань одоо батлагдчихаад байгаа улс төрийн тойрогтой харьцуулаад үзэх юм бол 90 хувийн нийцтэй буюу эрдэмтдийн санал дээр суурилсан ийм бүсчлэл болсон гэдгийг бас тодотгож хэлэхийг хүсэж байгаа юм. Өөрөөр хэлбэл өнөөдөр гэнэт энэ асуудлыг оруулж ирж байгаа гэхээс илүү 7 жил Жайка болон Монгол Улсын энэ чиглэлээр судалдаг 100 орчим эрдэмтэд орон нутагт хийсэн 3 удаагийн хэлэлцүүлгийн үр дүнд гарсан.

Энэ хувилбарыг 2 дахь удаагаа Засгийн газраас Их Хуралд өргөн барихаар ингэж төлөвлөж байгаа. Эхнийх нь Алсын хараа 2005-ийг өргөн барихад энэ бүсчлэлийн схем орж хэлэлцэгдсэн. Одоо энэ бүсчлэлийн талаар мэдээллүүдийг тэр үеийн өргөн барьсан хувилбараас харах боломжтой байгаа юм.

Мөн түрүүн Туваан гишүүний хэлж байсан бүх улс төрийн намуудыг оруулж энэ хэлэлцүүлгийг хийхээр төлөвлөсөн байгаа. Улаанбаатар хотод хийх гэж байгаа хэлэлцүүлэг дээр төв намуудын төлөөллийг, бүсчилсэн хэлэлцүүлэг дээр нь орон нутагт байгаа намуудын төлөөллийг бүгдийг нь урьж оролцуулах, мөн олон улсын эрдэмтдийг урьж оролцуулах, томоохон компанийн төлөөллүүдийг, мэргэжлийн холбоодын төлөөлөл, худалдаа аж үйлдвэрийн төлөөллийг өргөн бүрэлдэхүүнтэйгээр оролцуулахаар ингэж төлөвлөсөн байгаа.

Г.Занданшатар: Энэ нөгөө юу байна л даа. Тогтоол учраас асуулт, үг 2

нэг. Тэгээд нийт минут 4 минут. Та 5, 6, 7 минут сая энэ схем харахад ярьчихсан байна.

Батсуурь гишүүн нэг минут тодруулъя. Та ингээд 8.

Ж.Батсуурь: Энэ үг хэлэхээр та хэд ерөөсөө яриулахгүй юм, барьж идчих гээд байх юм. Би зүгээр яг үнэндээ бодит л юм яриад байна л даа. Энэ бүсчилсэн байршуулах тухай ийм юуных нь үзэл баримтлал дээр нь 2 улсын жишээ л бичсэн байгаа байхгүй юу. Саяын энэ хүмүүсийн яриад байгаа тэр судалгаа, тооцоо чинь энэ дээр чинь нэг ширхэг ч өгүүлбэр байхгүй байна л даа. Тэгээд Лондонгоос бүсчилсэн хөгжлийн баримтлалаа ингэж нүүлгэсэн, юу Сөүлээс ингэж нүүлгэсэн гэсэн 2 юмтай үзэл баримтлал барьчхаад тэгээд үүнийг нь хэлэнгүүт нь барьж идчих гээд ингээд яриулахгүй байгаа байхгүй юу. Уул нь үүнийг бас нэг хэдүүлээ хэдэн талаас нь яриад, нухацтай тогтоол гарвал дараа дараагийнхаа үйл явцад нь хэрэгтэй л зүйл болох байх гэж ингэж бодсон юм.

Тэгээд чуулган ч завсарлах гэж байна. Та хэд маань 8 жил дураараа дургиллаа, дунд чөмгөөрөө найгалаа. Тэгээд улам сайн найга. Тэгээд ард түмэн дүнг чинь тавих байлгүй дээ. Үг хэлүүлэхгүй байгаад харамсаж байна.

Г.Занданшатар: Үгийг сайн хэлүүлж байгаа шүү, бас. Тийм учраас л яриад л байгаа шүү. Тэгээд бие биеийнхээ үгийг ер нь хүндэтгэлтэй сонсож байх хэрэгтэй. Тэгээд энэ Хэрэг эрхлэх газрын даргаар намайг ажиллаж байхад энэ эрдэмтдийн судлаачдаар бүсчлэл, эдийн засгийн мужийн судалгааг бид хийлгээд, Жайка, Азийн хөгжлийн банкны тээвэр ложистикийн судалгаа бий, Жайкагийн тэр Хөдөө аж ахуйн бүсчлэлийн судалгаанууд буюу ингээд энэ судалгаануудын чинь үндсэн дээр 3 тулгуурт хөгжлийн бодлого гэж хөгжлийн бодлого боловсруулаад тэр нь сүүлдээ Алсын хараа болоод тэгээд энэ.

Энэ чинь дандаа бүсчилж хөгжүүлэх тухай л асуудлууд байгаа л даа.

Тээвэр ложистикийг нь яаж хөгжүүлэх юм, дэд бүтцийг яаж хөгжүүлэх юм, ХАА газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн бүс, аялал жуулчлалын бүс гэх мэтчилэн байгаль орчны, тээвэр ложистикийн, эдийн засгийн мужлалын, эдийн газар зүйн тийм судалгаанууд хийгдсэн. Тэгээд үүнийг л бас ард иргэдийн, шинжлэх ухааны үндэслэлд суурилсан олон нийтийн санал бодолд тулгуурласан ийм шийдвэр гаргахын тулд үүнийг хийж байна гэж ойлгож байна.

Ийм учраас үүнийг төрийн. Тийм, үүнийгээ үзэл баримтлал дээрээ тавья.

Ингээд Байнгын хорооны саналаар “Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Тэгээд энэ бүх намууд, эрдэм шинжилгээний байгууллагууд оролцоод л ингээд явах эдийн засгийн форумууд хийх юм.

66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ 2 дугаар заалт дээр эдийн засгийн форм хийнэ гэж байгаа юм. Бүсийн эдийн засгийн формууд хийх заалттай. Түүний л зардал чирэгдлийн юмнууд. Нөгөө өвлийн давус гэдэг шиг давусын эдийн засгийн формууд хийгдээд байна шүү дээ. Тэгээд бүсчлээд формоо хийгээд юмаа ярьчих, потенциалдаа ярьж гэж байгаа юм. Төр, хувийн хэвшил оролцоно гэж байгаа юм. Тийм байна.

Ингээд тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолын төсөл батлагдлаа.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

15.56 цаг

Дараагийн асуудалд орно.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна.

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүн Ундрам нарын 6 гишүүнээс 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн хэлэлцэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт хэлэлцүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус Байнгын хорооны 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 6 дугаар тогтоолоор дээрх хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрөөр ахлуулан, Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар, Ганхуяг, Идэрбат, Цэрэнпунцаг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажилласан.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,

ХХОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа материал худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт хуулийн төслүүдийг эрхлэх асуудлын дагуу Төсвийн байнгын хорооны хороо хэлэлцэж, санал, дүгнэлтээ Байнгын хороонд танилцуулсан болно.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу явуулж, санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Ажлын хэсэг органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөлд органик болохыг илэрхийлсэн тэмдэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, шошго зэрэг нэр, томъёоны тодорхойлолтыг нэмж тусган, органик үйлдвэрлэлд баримтлах зарчим, органик үйлдвэрлэгчийн эрх үүрэг, баталгаажуулалтын байгууллагын үүрэг, органик бүтээгдэхүүнийг бүртгэх, органик үйлдвэрлэлийн эрхлэгчид тавигдах шаардлага, төрийн байгууллагын чиг үүргийг тодорхой болгох зарчмын болон найруулгын нийт 28 саналыг бэлтгэн хэлэлцүүлсэн.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ганибал, Саранчимэг, Мөнхцэцэг, Жавхлан нар хуулийн төслийг зарчмын зөрөөтэй, саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хороо зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулсан бөгөөд зарчмын зөрөөтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх

Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн ахлагч Баттөмөр гишүүнд баярлалаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Мэндбаярын Дондогдорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Байхгүй байна. Даваасүрэн гишүүнээр тасаллаа. Даваасүрэн гишүүн асуултаа асууя.

Дараа нь Даваасүрэн гишүүн үг хэлсний дараа санал хураалт явагдана шүү, гишүүд ээ.

Ц.Даваасүрэн: Энэ маш чухал хууль байна, би дэмжиж байгаа юм. Тэгээд бид нар ялангуяа энэ 1 хоёрхон эх үүсвэртэй эдийн засгийн өсөлтийг олон төрлийн болгоход анхаарахгүй бол жишигээр бид нар ямар байдал орчихсон байна гэвэл яг Аргентин шиг

байдал руу ороход ерөөсөө маш ойрхон болчихсон. Зөвхөн нүүрсний орлогоос шахуу шалтгаалаад бид нар төсвөө энэ чинь 2008 оны үед нэг 1,4 их наядын орлого л олдог байсан юм шүү дээ. Энэ төсөв чинь, 1,4 их наядын, одоо намайг гишүүн болж байх үед. Өнгөрсөн жил 14 их наяд байсан, тийм ээ. Одоо 24 их наяд болчихсон. 10 хэд дахин нэмэгдчихсэн.

Тэгээд 1 зүйлийг бид нар бодох ёстой. Яагаад гэвэл та бүхэн энэ улс орныг авч явж байгаа, хөтөлж явж байгаа төрийн эрх барих дээд байгууллагын улсууд. Нүүрсний орлого 2 дахин унахад юу болох вэ, юугаар нөхөх вэ? Тэгэхэд яг л бид нар Аргентин болно. Зөвхөн нэг орлогоос шалтгаалж яваа шүү дээ. Тэгэхээр ийм энэ өсөлтөө бид нар ингээд магтаад л тэд болчихлоо гээд, түүндээ биш. Бид энэ өсөлтийг хуримтлуулж явах ёстой байсан. Түүнээс биш үүгээр төсвөө тэлж, зардлаа тэлж явж болохгүй байсан. Одоо та нар нэг ингээд хэрвээ гай тохиолдоод хямрах юм бол төсөөлөөд үзээрэй. Нүүрсний орлого байхгүй болоход тал нь байхгүй болоход цалин, тэтгэврээ тавьж чадахгүй болоход, санхүүжилтүүдээ тавьж чадахгүй болоход, юу болох вэ? Тийм учраас үүнийг бид нар бас бодож, цаашидынхаа ирээдүйг харах юм бол ерөөсөө бусад төрлийн орлогыг нэн яаралтай бий болгох чиглэл рүү анхаарахгүй бол манай эдийн засагт нэг л асуудал тохиолдоход сүйрэх ийм нөхцөл байдал руу орчихсон ийм төсөв рүү явчихсан, ийм эдийн засаг руу явчихсан байгаа.

Тэгэхээр энэ органик хүнс буюу хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дээр тодорхой хэмжээгээр анхаарч өгөхгүй бол болохгүй ээ, одоо. Бидэнд өргөн уудам нутаг байна, олон 10 сая мал байна. Үүнийгээ л ашиглах руу, ашиглах руу явах ёстой. Гэтэл өнөөдөр тийм биш болчихсон байна. Сүүгээ саахаа больчихсон байна, арьс ширийг нь боловсруулахаа больчихлоо. Өөрөөр хэлбэл бид нар энэ хүндрэлийг давах юм уу, ямар нэг хэмжээгээр энэ орлогынхоо олон төрлийн болох хамгийн

боломжтой манай эдийн засгийн харьцангуй давуу тал болсон ХАА-гаа өөд нь татаж чадахгүй байгаад байна шүү дээ. Өөрөөр бид нар орлуулах юм байхгүй шүү дээ. Хэрвээ нүүрс жишээлбэл 50 хувь тасалдахад юм уу, нүүрсний орлого 2 дахин унахад бид яах вэ? Тэгээд ингээд ерөөсөө маргаашаа харахгүй ингээд алхаад яваад байж бид нар болохгүй л дээ.

Тийм учраас энэ ялангуяа хөдөө аж ахуйн чиглэл дээр ер нь онцгой анхаарч яахгүй бол бид нар болохгүй байх. Өөр юугаар нөхөхийг би олж харж чадахгүй байна. Яах вэ, аялал жуулчлал тодорхой хэмжээгээр юм оруулах байх. Тэгэхдээ хамгийн боломжтой бидний хийж чадсаар ирсэн юм бол ХАА. Зөвхөн малын сүү дээр 200 сая литр сүү саах мөнгийг бид нар алдаж байгаа шүү дээ, 200 сая литр сүү. 1 доллароор бод л доо 200 сая доллар, 200 сая доллар, зөвхөн сүүн дээр. Арьс шир дээр 10 сая арьс шир, 10 доллароор бодъё, 100 сая доллар. Тэгэхээр яг ийм чиглэлийн юмнуудаа бид нар нэлээн ингээж анхаарч яаж хэрвээ эдийн засаг энэ уул уурхайн салбар, байгалийн баялаг дээр үнийн уналт дэлхийд явагдах юм бол бид яах вэ гэдгийг бодож явахгүй бол үргэлж нартай өдөр байдаггүй.

Л.Мөнхбаатар: Даваасүрэн гишүүн байр сууриа илэрхийлж дэмжиж, үг хэллээ, тийм ээ. Санал хэллээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд байраа эзлэе. Санал хураалтаа явуулъя.

Энэ өнөөдөр хэлэлцэх асуудлын хамгийн сүүлийн асуудал байгаа. Энэ асуудлыг хэлэлцээд завсарлана.

Гишүүд байраа эзлээрэй.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийн дараах зарчмын

зөрөөтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал байна.

Нэг. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “дэмжлэг үзүүлэх” гэсний өмнө “төрөөс” гэж нэмж, төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Органик” гэсний дараах “хүнсний” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ундрам, Анужсин, Аубакир, Адьшаа, Саранчимэг, Туваан, Энхтүвшин. Цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт, санал хураалт гишүүд ээ.

Санал хураалт гишүүд ээ. Аубакир гишүүн суудалдаа сууя.

53,8 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь хөдөө аж ахуйн болон байгалийн гаралтай органик хүнс, хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүн, мал, амьтан, тэжээл, бордоо, таримлын үр, суулгацыг үржүүлэх, үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, тээвэрлэх, хадгалах, савлах, шошголох, худалдаалах, экспортлох, импортлох үйл ажиллагаанд үйлчилнэ.

3.2.Энэ хуулийн 3.1-д заасан үйл ажиллагаа шилжилтийн үеийн органик үйлдвэрлэлийн бүх үе шатанд хамаарна.

3.3.Амьтны тухай хуулийн 4.1.7-д заасан агнуурын амьтны түүхий эдээр органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал хураалт гишүүд ээ.

56,4 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.1. “органик үйлдвэрлэл” гэж шилжилтийн үеийн болон органик үйлдвэрлэлийн бүх үе шатанд нөөцийг зохистой ашиглах, экосистемийн тэнцвэр, биологийн олон янз байдлыг хадгалахад чиглэсэн уламжлалт арга барил, биологи ба механик арга технологийг хослуулан эрхлэхийг;

4.1.2. “органик бүтээгдэхүүн” гэж зохиомол аргаар нийлэгжүүлсэн нэмэлт бодис, эрдэс бордоо, пестицид, антибиотик, өсөлтийн даавар, хувиргасан амьд организм, цацраг туяа хэрэглээгүй энэ хуулийн 4.1.1-д заасан үйлдвэрлэлийн үр дүнг;” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.7, 4.1.8, 4.1.9 дэх заалт нэмэх:

“4.1.7. “органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдэг” гэж эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаар баталгаажсан, органик бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн органик болон шилжилтийн үеийн түүхий эд, бүтээгдэхүүнийг гэрчилж, шошгод байршуулсан тэмдгийг;

4.1.8. “урьдчилан сэргийлэх арга хэмжээ” гэж органик бүтээгдэхүүн нь органик бус бүтээгдэхүүнтэй холилдох, энэ хуулийн 8.2-т заасан органик үйлдвэрлэлд хэрэглэхийг зөвшөөрсөн бодисын жагсаалтад зааснаас өөр бодисоор бохирдох эрсдлээс зайлсхийхийг;

4.1.9. “шошго” гэж органик бүтээгдэхүүний оноосон болон худалдааны нэр, органик үйлдвэрлэлийн талаар бичсэн, хэвлэсэн, зурсан, товойлгосон, сийлсэн аливаа үг, бичиглэл,

мэдэгдэл, тэмдэг, дардас, зураг, тухайн бүтээгдэхүүнийг дагалдах баримт бичиг, хуудас, зүүлт, хавчуурга, бөгж, хүзүүвчийг.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт, гишүүд ээ.

Санал уначихлаа. Хэн, Нямаагийн Энхболд гишүүн горимын санал гаргая. Нямаагийн Энхболд гишүүний микрофоныг өгье. Нямаагийн Энхболд гишүүн

Н.Энхболд: Сая би уг нь дэмжсэн юм, дарга аа. Тэгээд энэ аппарат л юу яачих шиг боллоо. Дутуу дарчхав уу. Санал дахиж хурааж өгөхийг хүсье.

Л.Мөнхбаатар: Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

62,5 хувиар санал дэмжигдлээ.

Үндсэн саналын томъёоллын уншиж танилцуулсан. Санал хураалт явуулъя.

60 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Органик үйлдвэрлэлд баримтлах зарчим

5.1.Органик үйлдвэрлэлд дараах зарчмыг баримтална:

5.1.1.хөрс, ус, агаар, ургамал, амьтан, хүн амын одоо ба ирээдүйд эрүүл, аюулгүй оршин тогтнох, тэдгээрийн дархлаа, дасан зохицох чадварыг дэмжих, нөхөн сэргээх;

5.1.2.экосистемийн тэнцвэрийг хадгалах, биологийн олон янз байдлыг дэмжих, уламжлалт соёл, ёс заншлыг хүндэтгэх, үйлдвэрлэлийн нөөцийн тогтвортой байдлыг хангах;

5.1.3.зах зээлийн өрсөлдөөн, үйлдвэрлэлийн бүх үе шатанд шударга, энэрэнгүй ёсыг баримтлах, гадаад орцын хэрэглээг хязгаарлах, мэдлэгээ хуваалцах;

5.1.4.бүтээгдэхүүний органик болон байгалийн шинж байдлыг хадгалах, нөөцийг зүй зохистой ашиглахад чиглэсэн арга технологиор үйлдвэрлэл эрхлэх;

5.1.5.уламжлалт мэдлэгийг шинжлэх ухааны ололттой хослуулан органик үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, шинэ технологийг нэвтрүүлэхдээ урьдчилсан үнэлгээ хийх, эрсдлийг бууруулах, ил тод, нээлттэй шийдвэр гаргах;

5.1.6.шилжилтийн үеийн болон органик үйлдвэрлэлийг сайн дурын үндсэн дээр эрхлэх.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

64,1 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн **ХОЁРДУГААР БҮЛГИЙН** гарчгийн **“ЭРХЛЭГЧИЙН”** гэснийг **“ЭРХЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА”** гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 6 дугаар зүйл нэмэх:

“6 дугаар зүйл.Органик үйлдвэрлэл эрхлэгчид тавигдах шаардлага

6.1.Органик үйлдвэрлэл эрхлэгч нь дараах нийтлэг шаардлагыг хангана:

6.1.1.энэ хуульд заасан шаардлага, журмыг баримталж органик үйлдвэрлэлд шилжих;

6.1.2.органик үйлдвэрлэлд шилжихдээ энэ хуулийн 8.2-т зааснаас бусад бодисыг тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хэрэглэхээ зогсоох;

6.1.3.усны бохирдлоос сэргийлэх, цас, борооны усыг ашиглах,

хаягдал багатай, эсхүл хаягдалгүй усны технологи ашиглах;

6.1.4.биотехникийн болон биологийн олон янз байдлын чанарыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;

6.1.5.өөрийн болон хөри зэргэлдээ, нийтийн эзэмшлийн газрын байгаль орчин, эд зүйлсийг хамгаалах.

6.2.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь органик үйлдвэрлэлд шилжихдээ хууль тогтоомжид заасан хүнсний аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

6.3.Хуулиар хориглоогүй бол улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон орчны бүсэд органик үйлдвэрлэл эрхэлнэ.

6.4.Орцын 95 болон түүнээс дээш хувь нь органик найрлагатай бүтээгдэхүүнийг органикт тооцно.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

55,3 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 6 дугаар зүйлийн гарчгийн “эрх” гэсний дараа “, үүрэг” гэж нэмж, мөн зүйлийн 6.1.2 дахь заалтын “энэ хуулийн 8.2-т заасан журмын дагуу” гэснийг “энэ хуульд заасны дагуу” гэж өөрчилж, 6.1.1 дэх заалтын “шилжилтийн үеийн, эсхүл органик болохыг илэрхийлсэн” гэснийг, 6.1.3 дахь заалтын “энэ хуулийн 8.2-т заасан бодис, хувиргасан амьд организм, цацрагийн боловсруулалт, өсөлтийн даавар хэрэглээгүй болон” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.1.4, 6.1.5, 6.1.6 дахь заалт тус тус нэмэх:

“6.1.4.органик үйлдвэрлэл эрхлэхэд үндэсний, эсхүл олон улсын стандартыг хэрэглэх;

6.1.5.баталгаажуулалтын байгууллагыг сонгох;

6.1.6.хамтын баталгаажуулалтын байгууллагын гишүүнээр элсэх хүсэлт гаргах.” Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт.

56,4 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн “7 дугаар зүйл.Органик үйлдвэрлэл эрхлэгчийн үүрэг” гэснийг, мөн зүйлийн 7.1.3 дахь заалтыг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.10 дахь заалт, 7.2, 7.3 дахь хэсэг тус тус нэмэх:

“7.1.2.шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнийг энэ хуулийн 12.2-т заасан журмын дагуу мэдээллийн цахим санд бүртгүүлэх, мэдээллийн үнэн зөвийг хариуцах;

7.1.3.урьдчилан сэргийлэх арга хэмжээг багтаасан шилжилтийн болон органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөний төслийг боловсруулж, баталгаажуулалтын байгууллагаар батлуулан хэрэгжүүлэх, энэ хуулийн 6.6-д заасан мэдээллийн санд тайлан, мэдээг хүргүүлэх;

7.1.4.шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах;

7.1.10.ойн дагалт баялаг, байгалийн ургамлыг түүх ажлыг бусдаар гүйцэтгүүлэх бол холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, зааварчилгаа өгч, тэмдэглэл хөтлөх.

7.2.Сум, дүүргийн байгаль орчны асуудал хариуцсан албан тушаалтан энэ хуулийн 7.1.8-д заасан талбайг тогтоож, тодорхойлолт олгоно.

7.3.Органик үйлдвэрлэлд хэрэглэх бодист тавигдах шаардлага, тэдгээрийг үнэлэх аргачлал болон жагсаалтыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

56,4 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.8.сүүлийн гурван жилийн хугацаанд энэ хуулийн 8.2-т заасан жагсаалтад орсноос бусад бодисыг хэрэглээгүй, авто зам болон бохирдлын эх үүсвэр, эсхүл органик бус аж ахуйгаас нэг км-ээс багагүй зайтай талбайгаас ойн дагалт баялаг болон байгалийн ургамлыг түүх;” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

56,4 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.6, 8.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.6.хөрсгүй технологи /гидропоник/ ашиглах;

8.1.7.энэ хуулийн болон эрүүл ахуйн шаардлага хангаагүй, буруу шошготой хуурамч түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, сурталчлах;” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

51,3 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.1.8 дахь заалт нэмж, мөн зүйлийн 8.2 дахь хэсгийг хасах.

“8.1.8.органик бүтээгдэхүүнтэй харьцах бүх төрлийн гадаргуу, сав, баглаа, боодолд нано бүтэцтэй материал ашиглах.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

51,3 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн **ГУРАВДУГААР БҮЛГИЙН** гарчгийн **“ШОШГОЛОЛТ, БҮРТГЭЛ”** гэснийг **“БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САН, ШОШГО”** гэж өөрчилж, төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “тус тус” гэснийг хасаж,

төслийн 9.4 дэх хэсгийн “түүнийг байгуулах,” гэсний дараа “бүртгүүлэх,” гэж нэмж, төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.5 дахь хэсэг нэмэх:

“9.5.Баталгаажуулалтын байгууллага нь эрх бүхий байгууллагаас олгосон давхцалгүй бүртгэлийн дугаартай байна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.1.органик үйлдвэрлэл эрхлэх, баталгаажуулах тухай гэрээг үйлдвэрлэл эрхлэгчтэй байгуулах, хэрэгжүүлэх, хянах;” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

14. 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.4, 10.1.5 дахь заалт нэмэх:

“10.1.4.энэ хуулийн 15.3-т заасан журмын дагуу органик үйлдвэрлэлийн байршил, төрөл, мэдээллийн сангийн бүртгэл, мэдээлэл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дүгнэлт зэргийг харгалзан шаардлагатай тохиолдолд шилжилтийн үеийн хугацааг тогтоох;

10.1.5.энэ хуулийн 12.2-т заасан журмын дагуу органик үйлдвэрлэл эрхлэх, баталгаажуулах тухай гэрээний хэрэгжилт, тохирлын үнэлгээний тайлан, баталгаажуулалтын гэрчилгээ, шилжилтийн болон органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөө, шаардлагатай бусад мэдээлэл, баримт бичгийг мэдээллийн санд оруулах;” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11 дүгээр зүйл.Органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах, бүртгэх

11.1.Үйлдвэрлэл эрхлэгч органик үйлдвэрлэлд шилжих тухай хүсэлтийг мэдээллийн санд илгээхдээ дараах шаардлагыг хангасан байна:

11.1.1.дотоод хяналтын хуудсыг бөглөх;

11.1.2.мэдээллийн санд хэрэглэгчээр бүртгүүлэх маягтыг бөглөх.

11.2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардлага хангасан үйлдвэрлэл эрхлэгчийг хэрэглэгчээр бүртгэж, мэдээллийн санд хандах эрх олгоно.

11.3.Үйлдвэрлэл эрхлэгч мэдээллийн санд бүртгэлтэй баталгаажуулалтын байгууллагаас сонгож, органик үйлдвэрлэлд шилжих тухай хүсэлт, холбогдох бусад мэдээллийг баталгаажуулалтын байгууллагад илгээнэ.

11.4.Баталгаажуулалтын байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

11.4.1.үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаанд урьдчилсан үнэлгээ хийж, хуульд заасан шаардлага хангасан гэж үзвэл органик үйлдвэрлэл эрхлэх, баталгаажуулах тухай гэрээг байгуулж, хэрэгжилтийг хангуулах;

11.4.2.шаардлага хангасан үйлдвэрлэл эрхлэгчид шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнд баталгаажуулалтын гэрчилгээг олгож, холбогдох баримт бичгийн хамт мэдээллийн санд илгээх.

11.5. Мэдээллийн сангаас шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн бүртгэгдсэн тухай мэдэгдэл ирснээр үйлдвэрлэл эрхлэгчид бүтээгдэхүүний шошгод органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдэг хэрэглэх эрх үүснэ.

11.6. Энэ хуулийн 11.4.2-т заасан баталгаажуулалтын гэрчилгээний загварыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.7. Органик үйлдвэрлэл эрхлэгч нь органик үйлдвэрлэлийн талаарх олон улсын стандартын дагуу баталгаажуулалт хийлгэсэн бол органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдгийг хэрэглэж болно.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

16. Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.3. Органик бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох тохиолдолд гаалийн байгууллага нь тухайн бүтээгдэхүүнийг мэдээллийн санд бүртгэлтэй эсэхийг шалгаж улсын хилээр нэвтрүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

52,5 хувиар санал дэмжигдлээ.

17. Төслийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг, 13.5.1 дэх заалтын “илэрхийлсэн” гэсний дараа, 13.5.2 дахь заалтын “дэвсгэртэй” гэсний дараа “гэрчлэх” гэж тус тус нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.7 дахь хэсэг нэмэх:

“13.7. Улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 13.6-д заасан үг болон эдгээртэй агуулгын хувьд дүйцэх үгийг хуулийн этгээдийн нэрээр баталгаажуулахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

18. Төслийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.7. Органик бүтээгдэхүүний орц, найрлага тооцох аргачлалыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

19. Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.3 дахь хэсэг нэмж, төслийн 14.3 дахь хэсгийн “Импортлогч” гэсний дараа “, экспортлогч” гэж нэмэх:

“14.3. Бөөнөөр нийлүүлсэн органик бүтээгдэхүүний шошгоны мэдээлэл эсжиглэн савласан органик бүтээгдэхүүний шошгоны мэдээлэлтэй ижил байх ба савласан огноог шошгонд ил харагдахуйц тусгана.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

20. Төсөлд доор дурдсан агуулгатай 15 дугаар зүйл нэмэх:

“15 дугаар зүйл. Төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэг

15.1. Органик үйлдвэрлэлийн бодлого, эрх зүйн зохицуулалтыг төлөвлөх, удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх чиг үүргийг улсын хэмжээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага, сум, дүүрэгт хөдөө аж ахуйн нэгж хариуцан гүйцэтгэнэ.

15.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага органик

үйлдвэрлэлийн асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.2.1.Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих бодлогыг тусгах, салбар хоорондын уялдааг хангах, хэрэгжүүлэх;

15.2.2.энэ хуулийн 12.1-д заасан мэдээллийн санг байгуулах, шинэчлэх, шаардлагатай бусад мэдээллийн сантай холбох;

15.2.3.шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн, органик үйлдвэрлэл эрхлэгчийг мэдээллийн санд бүртгэх үйл ажиллагааг удирдах, холбогдох мэдээллийг олон улсын байгууллагад хүргүүлэх;

15.2.4.Хүнс хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн бүтцэд органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх судалгааны нэгж байгуулах;

15.2.5.органик үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон бүс нутгийн байгууллагатай хамтран ажиллах, гишүүний татвар, хандивыг улсын төсвөөс төлөх;

15.2.6.органик салбарын Үндэсний зөвлөлийг байгуулах, ажиллах журмыг батлах.

15.3.Органик үйлдвэрлэлд тавигдах шаардлага, баримтлах журмыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.4.Энэ хуулийн 15.3-т заасан журамд дараах асуудлыг тусгана:

15.4.1.мал аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх;

15.4.2.тариалангийн органик үйлдвэрлэл эрхлэх;

15.4.3.органик хүнсийг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх;

15.4.4.зөгийн органик аж ахуй эрхлэх;

15.4.5.хоол үйлдвэрлэл, үйлчилгээг органик зарчимд нийцүүлэн эрхлэх;

15.4.6.хүнсний бус органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх;

15.4.7.органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах, бүртгэх, органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдгийг шошгод байршуулах, нийтийн хэрэгцээнд нийлүүлэх;

15.4.8.органик бүтээгдэхүүнийг хадгалах, савлах, тээвэрлэх, экспортлох, импортлох.

15.5.Органик үйлдвэрлэлийг органик бус үйлдвэрлэлтэй хавсран эрхлэх асуудлыг энэ хуулийн 15.3-т заасан журамд тусгана.

15.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих талаар тухайн орон нутгийг хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулан, үр дүнг мэдээллийн санд оруулна.

15.7.Итгэмжлэлийн байгууллага нь органик бүтээгдэхүүний тохирлын үнэлгээний дүнг олон улс, бүс нутаг, гадаад улстай харилцан хүлээн зөвшөөрөх асуудлыг хариуцна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

21.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтын “дотоодод үйлдвэрлэсэн” гэсний дараа “, баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй” гэж нэмж, мөн заалтын “ашиглаж байгаа тариалангийн анхан шатны” гэснийг “ашиглах тохиолдолд” гэж өөрчилж, мөн зүйлийн 15.1.2 дахь

заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

57,5 хувиар санал дэмжигдлээ.

22.Төслийн 15 дугаар зүйлийн 15.2.2 дахь заалтын “органик бүтээгдэхүүнийг” гэсний өмнө “баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй” гэж нэмж, 15.2.1 дэх заалтын “ерөнхий боловсролын сургуулийн” гэснийг “бүх шатны боловсролын байгууллагын” гэж, 15.2.3 дахь заалтын “нийлүүлсэн” гэснийг “нийлүүлсэн нь Технологи дамжуулах тухай хуульд заасны дагуу нотлогдсон” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

53,8 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.1.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэн тэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшилэлийг нийцүүлэн өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал байна.

Нэг. Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “үйлдвэр” гэснийг “үйлдвэрлэл” гэж, төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүн” гэснийг “бүтээгдэхүүний” гэж, төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “бичиг баримт” гэснийг “баримт бичиг” гэж, мөн хэсгийн “хяналт” гэснийг

“хяналтыг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

62,5 хувиар санал дэмжигдлээ.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг танилцуулъя. 3 санал байна. 3 санал байна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжсэн санал байна.

Нэг. Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “3.2 дахь заалтын ““үйлдвэрлэл” гэсний дараа “импорт, экспорт” гэж тус тус” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжээгүй санал байна шүү, гишүүд ээ. Байнгын хорооны дэмжээгүй саналаар санал хураалт явагдах гэж байна.

Нэг. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Төслийн 1 дүгээр зүйлийн 39.1.4.5 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“39.1.4.5.нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсад үйлдвэрлэсэн, баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй органик бордоог ашиглах;” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Ажлын хэсгийн ахлагч үүгээр хураалаа шүү дээ, тийм ээ. Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

**2. ААНОАТ-ын тухай хуульд
нэмэлт оруулах тухай хуулийн төслийн
талаар санал хураалтыг явуулъя.**

Төслийн 1 дүгээр зүйлийн 22.5.10¹
дахь заалтын “6.1.1-д” гэснийг “4.1.2-т”
гээж өөрчилж, мөн заалтын “буюу
тариалсан” гэснийг хасах. Санал гаргасан
ажлын хэсэг, санал хураалт.

37 хувиар санал дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрөөтэй саналын
томъёоллоор санал хурааж дууслаа.

Органик бүтээгдэхүүний тухай
хуулийн төсөл болон хамт өргөн
мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн
хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль
орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын
хороонд шилжүүлээ.

16.37 цаг

Одоо Улсын Их Хурлын даргын
дэргэдэх зөвлөл хуралдана. Зөвлөлийн
гишүүд хуралдаа ороорой.

Өнөөдрийн нэгдсэн чуулганы
хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан
тул өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг
мэдэгдье.

Гишүүдэд баярлалаа.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ